



Үйлчлэхээр Эгцлэн Босохуй

Рухи Институт



2-р ном

ҮЙЛЧЛЭХЭЭР ЭГЦЛЭН БОСОХУЙ

Рухи Институт

Энэ цуврал дахь номууд:

Доор Рухи Институтээс боловсруулсан цуврал материалд өнөөгийн байдлаар буй номуудын нэрс байна. Уг номууд нь залуучууд болон насанд хүрэгсдийн нийгэмлэгтээ үйлчлэх чадавхыг хөгжүүлэх зорилго бүхий системтэй хүчин чармайлтын хүрэн дэх үндсэн шаталсан сургалтын материал болж байгаа юм. Рухи Институт мөн Бахайн хүүхдийн хичээлийн багшид зориулан энэхүү цувралын Гуравдугаар номоос салбарлан гарах багц сургалтын материал, мөн өсвөр насны бүлгийн удирдагчдыг бэлтгэхэд зориулж Тавдугаар номоос салбарласан багц материалыг тус тус боловсруулж байгаа билээ. Эдгээр багцыг мөн доор багтаав. Талбар дээр туршлага хуримтлагдан сайжрах хэрээр уг жагсаалт өөрчлөгдөж болох бөгөөд эдүгээ боловсруулалтын шатанд яваа сургалтын материалууд нийтэд хүртээлтэй болох түвшинд хүрсэн үед нь шинэ номууд нэмэгдэн орно гэдгийг дурдах нь зүй буй за.

1-р ном	<i>Оюун санааны амьдралын тухай эргэцүүлэхүй</i>
2-р ном	<i>Үйлчлэхээр эгцлэн босохуй</i>
3-р ном	<i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 1-р анги</i> <i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 2-р анги (салбар сургалт)</i> <i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 3-р анги (салбар сургалт)</i> <i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 4-р анги (салбар сургалт)</i>
4-р ном	<i>Ихэр Элч</i>
5-р ном	<i>Өсвөр насны залуучуудын чадавхыг нээн хөгжүүлэхүй</i> <i>Анхны тэмүүлэл: Тавдугаар номын эхний салбар сургалт</i> <i>Өргөжин тэлж буй хүрээ: Тавдугаар номын хоёр дахь салбар сургалт</i>
6-р ном	<i>Үйл Хэргийг багшлахуй</i>
7-р ном	<i>Үйлчлэхүйн зам мөрөөр хамтдаа алхахуй</i>
8-р ном	<i>Бахауллагийн Гэрээс</i>
9-р ном	<i>Түүхийн ойлголттой болох нь</i>
10-р ном	<i>Эрч хүчтэй нийгэмлэгүүдийг бүтээн босгохуй</i>
11-р ном	<i>Материаллаг арга замууд</i>
12-р ном	<i>(боловсруулагдаж буй)</i>
13-р ном	<i>Нийгэмд хандсан үйл ажиллагаанд оролцохуй</i>
14-р ном	<i>(боловсруулагдаж буй)</i>

Copyright © 2013, 2024 Колумб улс дахь Рухи Сангийн. Зохиогчийн бүх эрх хамгаалагдсан.

Хувилбар 1.1.1.ПЕ нь 2013 онд хэвлэгдэв. Хувилбар 2.1.1.ПЕ 2024 онд хэвлэгдэв.

Хэвлэсэн улс: Монгол

Анх Испани хэл дээр *Levantémonos a servir* нэрээр хэвлэгдсэн.

Copyright © 1987, 1996, 2020 Колумб улс дахь Рухи Сан

ISBN 978-958-52941-0-3

Энэхүү номыг Монгол хэл дээр тодорхой тоогоор хэвлэх эрхийг Рухи Институтээс Монголын Бахайчуудын Оюун Санааны Чуулгад олгов.

Ruhi Institute
Cali, Colombia
Email: instituto@ruhi.org
Website: www.ruhi.org

Монголын Бахайчуудын Үндэсний
Оюун Санааны Чуулга
+976 - 11 321867
secretariat@bahai.mn
www.bahai.mn

Агуулга

Сургагчид хандах хэдэн зүйл	7
Сургаал багшлахуйн баяр жаргал	13
Сэтгэл сэргээсэн харилцан яриа	31
Гүнзгийрүүлэх сэдвүүд	55

Сургагчид хандах хэдэн зүйл

Рухи Институтээс санал болгодог үндсэн дарааллын сургалтуудын хоёр дахь ном нь бидэнд утга учиртай, сэтгэл сэргээсэн харилцан яриа өрнүүлэхэд хувь нэмрээ оруулах чадавхыг хөгжүүлэх тухай юм. Уг номын үндсэн сэдэв болох үйлчилгээний онцгой үйлийн талаар гуравдугаар бүлэгт дүрсэлсэн. Асар нөлөөтэй хүчнүүд нэгдмэл байдлыг тараан бутаргаж байгаа энэ дэлхийд найз нөхөд болон хөршийнхөө гэрээр айлчлан нийгмийн амьдралын голлох сэдвүүдээр хамтдаа судлан ярилцах дадал нь соёлын чухал хэсэг болж чадвал бие биеэсээ улам бүр хөндийрөх байдлаас үүдэх зарим өвчин эмгэгийг анагаах эм нь болж чадна. Ийнхүү нөхөрлөлийн холбоо үүсэх нь цоглог бадрангуй, эв найртай нийгэмлэгүүдийг бүтээн босгох үйл явцыг бэхжүүлэх үүрэгтэй хэмээн энэхүү бүлэгт санал болгож байна.

Бичил хороод болон сум тосгодод гэрийн айлчлал хийх тогтвортой хөтөлбөр нь холбогдох засаг захиргааны институтууд ба агентлагуудын дэмжлэгийг авсан өөрийгөө зориулах сэтгэлтэй анд нөхдийн цөмийг оролцуулсан тодорхой зохион байгуулалттай байх шаардлагатай. Уг сургалтыг явуулж буй сургагч энэхүү тасралтгүй үргэлжлэх үйлсэд оролцогчдоо бэлтгэж байгаа гэдгээ ямагт санаж байх нь чухал юм. Тус сургалтын нэг хэсэг болгон тэдэнд зориулан зохион байгуулах айлчлал нь үйлчлэхүйн амьдралын чухал хэсэг бөгөөд жилээс жилд тэднийг энэхүү хүчин чармайлтад өөрийгөө зориулахад чиглүүлэх учиртай юм.

Оюун санааны болон нийгмийн агуулгатай сэдвүүдийг судлан ярилцах тодорхой зорилгоор айл өрхөөр айлчлах дадал нь нийгэмлэгийн соёлыг баяжуулах нь тодорхой. Гэр орон, ажлын газар, сургууль болон худалдааны төвд өрнөж буй олон янзын албан бус яриа хэлэлцүүлгүүд нь мөн адил чухал ач холбогдолтой юм. Өдөр тутмын харилцан яриандаа үе үе оюун санааны зарчмуудыг танилцуулах нь анхааран хөгжүүлэх ёстой бас нэгэн чадвар юм. Хоёрдугаар бүлэгт энэхүү чадварыг хөгжүүлэхийг зорьж байгаа ба ингэснээр гуравдугаар бүлгийг судлах суурийг тавьж байгаа билээ.

Хөршүүд болон найз нөхөдтэйгөө өрнүүлж байгаа бидний харилцан яриа сэтгэл сэргээсэн байхын тулд бид тэдэнтэй ярилцахдаа баяр жаргалыг бий болгож чаддаг байх ёстой. Энэ сэдвийг “Сургаал багшлахуйн баяр жаргал” хэмээх нэгдүгээр бүлэгт судална. Рухи Институтээс санал болгож буй үйлчлэхүйн бүхий л үйл нь мөн чанартаа Бахауллагийн Үүдэл Нээлтийн далайгаас нээж илрүүлэх тэнгэрлэг мэргэн ухааны сувд эрдэнэсийг бусадтай хуваалцах явдал юм. Нэгдүгээр бүлгийг судлах нь энэхүү

эрэл хайгуулаас үүдэлтэй баяр жаргалын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой. Бурханы Үгсийн тухай, түүнийг бусадтай хуваалцах нь ямар адис ивээлтэй гэдэг талаар хэд хэдэн хэсгийн туршид эргэцүүлэн бодохыг оролцогчдоос хүснэ. Энэ үйлээс үйлчилгээний зам мөрөөр алхах алхааг хурдасгах баяр жаргал бий болдог гэдгийг уг бүлэгт санал болгож байна. Энэхүү оюун санааны гүн гүнзгий үнэнийг бүрэн дүүрэн ойлгосон хэдий ч бид эл үйлчилгээг чухалчлан тодотгох хандлага болон зан чанаруудыг ойшоохгүй бол сургаал багшлахуйн баяр жаргалаа алдах эрсдэлтэй. Эдгээр нь цуврал дахь дараа дараагийн номуудын хэлэлцүүлгийн сэдэв байх бөгөөд үүнээс цөөн хэдийг нь энэ хэсэгт судлах ба долоодугаар хэсэг ангижрал гэсэн сэдвээр эхэлнэ. Бахайн Сургаал бичмэлээс түүвэрлэн авсан эшлэлүүд нь уг зан чанарын талаар эргэцүүлэх үндэс суурийг бүрдүүлэх агаад энэ зан чанар байхад гаднын хүчин зүйлүүд үйлчлэхүйн баяр жаргалыг бөхөөж чадахгүй. Оролцогчид сургалтаасаа олж авах хамгийн чухал зүйл бол ангижрал гэдэг нь хөндий хүйтэн, эсвэл хайхрамжгүй байдлыг илтгэсэн утга санаа агуулдаг хэмээн буруу ташаа ойлголт авахгүй байх нь чухал юм. Бид улам илүү үр дүнд хүрэхийн тулд хөдөлмөрлөхдөө хүчин чармайлтаа эрчимжүүлж, үйлчилгээнийхээ үр нөлөөг нэмэгдүүлэхийг тасралтгүй хичээх ёстой. Ингэхийн тулд хүчин чармайлтын шинж чанарын тухай хангалттай ойлгох шаардлагатай бөгөөд энэ сэдвийг наймдугаар хэсэг дээр судална. Үйлчлэхүйн замаар замнах явцад үндэс суурь болсон өөдрөг үзэл ба талархах сэтгэл хэмээх хоёр хандлагын талаар дараачийн болон сүүлийн хэсэгт товчхон судлах болно.

“Сэтгэл сэргээсэн харилцан яриа” хэмээх хоёрдугаар бүлэг нь боломж гарах бүрийд оюун санааны зарчмуудыг дурдан, энгийн харилцан яриаг өрнүүлэх чадвараа хөгжүүлэх дээр төвлөрөх болно. Энэ бүлэг нь янз бүрийн сэдвүүдийг агуулсан хэд хэдэн богино сэдвүүдээс бүрдэж байгаа бөгөөд эдгээр нь хэдийгээр Абдул-Бахагийн яг хэлсэн эшлэл биш ч гэсэн Түүний айлдвар дээр тулгуурласан бөгөөд яриандаа ашиглаж байсан олон үг хэллэг болон хэв маягийг агуулсан юм. Эдгээр нь бүх нийтийн сонирхол татахуйц, янз бүрийн гарал үүсэлтэй хүмүүсийн хүсэл эрмэлзэл, санаа зовнилыг агуулсан сэдвүүд юм. Эдгээр сэдвүүдийг судалснаар оролцогчид оюун санааны зарчмуудыг тайлбарласан Абдул-Бахагийн арга ухаанаас урам онгод авч, Бахауллагийн Үүдэл Нээлтийн тэнгис далайд оршиж буй сувд эрдэнэсийг нээн илрүүлэхийг хичээн чармайлх явцдаа Түүний зүг ханддаг дадлыг эзэмших бөгөөд Түүний Эцгийн сургаалын утга учир, үр дагаврыг ойлгож бусадтай өгөөмрөөр хуваалцах юм.

Энэ бүлгийн зорилгыг биелүүлэхийн тулд оролцогчдод сэдэв бүрийг хэд хэдэн удаа уншиж, гарч буй санааны дарааллыг тодорхойлон, өөрийн болтол дадлага хийх боломжийг олгосноор тэд утга санааг нь чөлөөтэй илэрхийлдэг болох юм. Эхэндээ

зарим нь тухайн сэдвүүдийг цээжлэн, бүлэгт бичигдсэн хэлбэрээр нь давтана. Үүнийг оролцогчдоос хүсэх хэрэгтэй. Шүтлэгийн талаарх мэдлэг нь дээшилж, туршлага суухын хэрээр тэд илүү өргөн хүрээтэй агуулга болон илүү баялаг үгсийн санг ашигладаг болох бөгөөд энэ нь бусадтай харилцах харилцаанаас нь харагддаг болно. Сургагч энэ шатанд сургаалыг хялбар байдлаар тайлбарлах, мөн Абдул-Бахагийн бодолтой нийцэж байх гэсэн хоёр талт зорилгыг тэнцвэртэй хадгалах ёстойг ойлгох хэрэгтэй.

Бүлгийн бүх гишүүд сэдэв бүрийн агуулгыг танилцуулж чаддаг болсны дараа олж мэдсэн санаагаа гэр бүл, найз нөхөд болон хамт ажиллагсдынхаа нөхцөлтэй уялдуулсан дасгал дээр ажиллана. Эцэст нь тэд тухайн сэдвээр харилцан яриа өрнүүлэх явцад урган гарч ирж болзошгүй асуултуудын талаар ярилцаж аль тохиолдолд тухайн санааг илүү сайн танилцуулах боломжтой болохыг олж тогтооно. Абдул-Бахагийн айлдсан оюун санааны зарчмууд нь хаа сайгүй хүмүүсийн санааг зовоосон асуудлыг ойлгоход нь тусалж байгааг зарим сэдвүүд дээр нэг юм уу хоёр жишээн дээр харуулсан. Номыг судлах явцад сургагч, бүлгийнхээ гишүүн бүрд нэг сэдвийг сонгон авч, доторх санааг нь хэлэлцэх хоёр хүн сонгоход нь тусалбал энэ дасгал илүү үр дүнд хүрэх юм. Энэ тохиолдолд оролцогчид хамтдаа цуглан, өрнүүлсэн харилцан яриа нь ямар динамик хэмнэлтэй өрнөснийг нэг нэгэндээ тайлбарлах цаг гаргаж өгч болно.

Уг бүлэгт багтсан сэдэв тус бүртэй холбогдуулан Бахауллагийн Сургаалын эшлэлээс цөөн хэдийг цээжлэх зорилгоор оруулсан болно. Рухи Институтийн хувьд Сургаал бичвэрээс цээжлэх явдлыг онцолж буй нь цувралын эхний номоос илт байсан бол хоёрдугаар ном бүр ч тод харагдаж байна. Сургаал бичвэрээс цээжээрээ санах нь оюун санааг нь хэрхэн тэтгэн тэжээдгийг оролцогчид өдийд мэддэг болсон биз ээ. Тэгвэл энэ номд, тэд Бурханы Үг хүмүүний зүрх сэтгэлд хэрхэн нөлөөлдөг талаар үргэлжлүүлэн эргэцүүлэх бөгөөд гурав дахь бүлэгт, хоёр дахь бүлэг дээр судалсны адилаар, Сургаалаас олж мэдсэн зарчмууд болон санаануудаа илтгэн танилцуулж, тохиромжтой үед Сургаал бичвэрээс шууд эш татаж сурах юм. Сургаалуудыг бусдад үнэн зөвөөр тайлбарлаж, яг байгаагаар хүргэх нь бидний үйлчлэхүйн замаар замнан явахдаа хөгжүүлэхийг хичээдэг олон чадварын нэг билээ. Абдул-Бахагийн хийсэн тайлбаруудыг үзэж судлан, Түүний жишгээр илэрхийлэх нь хоёр дахь бүлгийн бүтцийн суурь нь байх юм.

Дээр өгүүлсэнчлэн “Гүнзгийрүүлэх сэдвүүд” нэртэй гурав дахь бүлэг нь энэ номд дурдсан үйлчлэхүй буюу нийгмийн амьдралд чухал ач холбогдолтой сэдвээр ярилцах зорилгоор найз нөхөд, хөршүүдийнхээ гэрээр хийх айлчлалын тухай авч үзнэ.

Уг бүлэгт гурван төрлийн харилцан яриа өрнөх бөгөөд харилцан яриа бүр тохирох агуулгатай байх юм. Эхний төрөл нь системтэй айлчлалын хөтөлбөрийн хүрээнд сум тосгон, бичил хороодын оршин суугчидтай хамт судлах хэд хэдэн сэдвийг тойрон өрнөх юм. Өгөгдсөн агуулгыг сонирхсон хэн бүхэнтэй төрөл бүрээр хуваалцаж болох ч сэдвүүдийн анхдагч зорилго буюу тухайн гэр бүлийн гишүүдэд Шүтлэгийн талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэх боломж олгох явдал хамгийн чухал хэвээр байх юм. Иймдээ ч бүлгийн дийлэнх хэсэг энэ төрлийн харилцан ярианд зориулагдана.

Сүүлийн жилүүдэд сум тосгон, хот суурин газрын бичил хороо гэх мэт газарзүйн жижиг нэгжүүдэд сургагч, өсвөр насны залуучуудын бүлгийн удирдагч, хүүхдийн хичээлийн багшаар үйлчилж чадах хүмүүсийн тоо нэмэгдэхийн хэрээр айл өрхүүдээр зочлох дадал нь илүү далайцтай болоод байгаа юм. Энэхүү дадал нь зөвхөн Шүтлэгийн талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой төдийгүй, мөн өсвөр үеийнхнийг оюун санааны хувьд чадавхжуулах, хүүхдүүдэд оюун санааны боловсрол олгох хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэдгээ харуулаад байна. Удирдагч болон багш нар, хоёр хөтөлбөрт хамрагдаж буй хүүхэд залуусын эцэг эхчүүдтэй тогтмол уулзаж, тэдэнд хөтөлбөрийн гол санаа, арга барилын талаар ойлголт өгч байх хэрэгтэй гэдэг нь эндээс тодорхой байна. 14 ба 15 дугаар хэсэгт судлах хоёр дахь төрлийн харилцан яриаг бүрдүүлдэг ийм хэлэлцүүлгийн талаар судлах болно. Энэ хоёр хэсгийн агуулга тийм ч өргөн цар хүрээтэй биш юм. Учир нь оролцогчид дараа дараагийн сургалтаас уг хоёр хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй ойлголт олж авах юм. Гэхдээ тэдний хувьд, энэ төрлийн харилцан ярианы ач холбогдлыг ухамсарлан хүүхдийн хичээлийн багш нар болон өсвөр насныхны залуучуудын бүлгийн удирдагчдыг эцэг эхчүүдтэй уулзахад нь дагалдан явах нь эхэн үедээ ихээхэн үр дүнтэй байж болох юм.

Энэхүү бүлэгт орж буй гурав дахь төрлийн харилцан ярианы зорилго нэн онцгой. Маш олон залуу эрэгтэй, эмэгтэйчүүд дэлхийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзлээ илэрхийлэх арга замыг хайсаар байна. Тэд бол нийгмийг өөрчлөх асар их нөөц чадавхтай, өөрсдийгөө зориулахад бэлэн залуус юм. Үе тэнгийнхэн хоорондоо эрч хүч, авьяас чадал оргилсон залуу насанд л олдох боломж бололцоо, үүргийн талаар эргэцүүлэн бодох нь үйлчлэхүйн талаар ярилцахад чиглүүлж, дэлхий өнцөг булан бүрд сум тосгод, бичил хороодод хэрэгжиж буй ажлуудыг сонирхох сонирхлыг бадраах нь олонтоо. Олон хүн хүүхдийн хичээлийн багш, өсвөр насны бүлгийн удирдагчийн хувьд өсвөр залуу үеийнхэнд оюун санааны боловсрол олгох чадвар эзэмших зорилгоор институтийн сургалтад хамрагдах урилгыг дуртайяа хүлээн авах болно. Ес ба аравдугаар хэсгүүдэд энэ төрлийн харилцан ярианд судалж болох зарим санааг тусгасан болно.

Хувь хүмүүсийн утга учиртай яриа өрнүүлж, үргэлжлүүлэх чадварыг бэхжүүлэхийн тулд энэхүү бүлэг нь мэдээж өргөн сэдэв, холбогдох агуулгыг санал болгох төдийхнөөр хязгаарлагдах ёсгүй. Оролцогчид санаагаа ойлгомжтой илэрхийлэх чадвараас гадна зөв хандлага хийгээд оюун санааны зан чанаруудаа хөгжүүлэх хэрэгтэй. Эдгээр нь бүлэгт өгүүлэх ихэнх үйл явдлын суурь нь байх хэдий ч шаардлагатай чадваруудыг хөгжүүлэхэд хэчнээн чухал болох нь дөрөв дүгээр хэсэгт оролцогчид айлаар айлчлахаар бэлдэж байхдаа сэтгэл зүрх хийгээд оюун ухаанаа ямар мэдрэмж, ямар бодлоор дүүргэх ёстой талаар тунгаан бодох үед, мөн тавдугаар хэсэгт даруу төлөв байдлын тухай эргэцүүлэн бодох үед харагдах болно. Оролцогчид эдгээр хэсэгт хангалттай анхаарал хандуулах тал дээр сургагч санаа тавих учиртай. Учир нь бид хэчнээн их мэдлэг олж авч, санаагаа хэчнээн ойлгомжтой илэрхийлж чаддаг байлаа ч харилцан яриа үр дүнтэй болох эсэх нь бидний зан чанар хийгээд хандлагаас л хамаарна.

Энэхүү цуврал номд дүрслэн харуулсан үйлчилгээний үйлс нь нийгэмлэгийн өсөлт болон хөгжилд голлох байр суурь эзэлдэг хэдий ч сурахуй болон үйлдэхүйгээр дамжуулан хувь хүний чадавхыг дээшлүүлэхийг эрмэлздэг үйл явцын бүх элементүүдээс дээгүүр ордог гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Сургагч бүрийн ойлгох ёстой зүйл бол эдгээр үйлс нь бие биедээ тулгуурлан, номоос ном руу улам нарийн цогц болж байгаа явдал юм. Үйлчилгээ бүрийг үр дүнтэй хийж сурах нь дараа дараагийн алхмыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай чадавх суухад ихээхэн чухал. Энэ номд өгүүлснээр харилцан яриаг хэд хэдэн айлчлалын турш өрнүүлэх нь нэгдүгээр номд уриалдаг үйл ажиллагаа болох мөргөлийн цуглааныг бие даан эсвэл цөөн хэдэн хүнтэй хамтран тогтмол зохион байгуулахаас илүү их хүчин чармайлт шаардах нь ойлгомжтой. Цаашлаад илүү нарийн цогц үйлчилгээ хийж гүйцэтгэхийн тулд оролцогчид энд дурдсан чадваруудаа хөгжүүлэх нь хэчнээн чухал болохыг ойлгоход тийм ч бэрх биш билээ.

Нэгдүгээр номын танилцуулгад дурдсанчлан, дэлхий өнцөг булан бүрд институтийн сургалтад хамрагдаж буй хүмүүс янз бүрийн гаралтай бөгөөд Бахайн сургаалын талаарх мэдлэг нь харилцан адилгүй. Энэхүү Хоёрдугаар номыг эхлүүлэх үед тэд бүгд, уг сургалтуудаар нээж өгөх үйлчлэхүйн замд хөл тавьсан байна. Гэхдээ зарим нэг ялгаа байсаар байна. Залуучуудын тухайд авч үзэхэд хэрэв тэд хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөрт хамрагдаагүй бол энэ ном дахь олон өгүүлэмж, сэдэв тэдэнд шинэлэг байх бөгөөд тэдгээрийг үзэж судлах нь тэдний хувьд Шүтлэгийн талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэх хэрэгсэл болох юм. Үүнтэй холбогддуулан сургагч нь бүлгийн гишүүн бүрийн ойлголтыг төлөвшүүлэхэд хэрэгтэй уян хатан

байдал, бүтээлч байдлыг харуулахад бэлэн байхын зэрэгцээ сургалтын үндсэн зорилго болох оролцогчдод утга учиртай, сэтгэл сэргээсэн харилцан яриа өрнүүлэх боломжийг бүрдүүлж өгөх ёстой. Түүгээр ч үл барам, номыг ашиглаж буй мянга мянган газарт, эдгээр гурван бүлгээр дамжуулан хувь нэмрээ оруулахыг зорьж буй нийгэмлэгийг бүтээн босгох үйл явц өөр өөр шатандаа явж байгаа билээ. Эндээс үзэхэд, сурсан зүйлээ ажил хэрэг болгох нь газар газар өөр байх бөгөөд сургагч бүлгээ эдгээр материалыг судлахад залж явахдаа хүн нэг бүрийн хэрэгцээнд хэчнээн анхааралтай, нямбай хандах ёстой нь харагдаж байна.



Сургаал багшлахуйн баяр жаргал

Зорилго

Бурханы Үгийг бусадтай хуваалцах үед амсдаг
сургаал багшлахуйн баяр жаргалыг ойлгон үнэлэх

1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Рухи Институтээс санал болгож буй үндсэн дарааллын сургалтын хоёрдугаар ном болох *Үйлчлэхээр эгцлэн босохуй* хэмээх энэхүү ном нь сурахуй болон үйлдэхүй хоёрыг хослуулахыг зорьсон юм. Энэхүү номын зорилго нь танд оюун санааны ба оюун ухааны хувьд өсөн хөгжих болон нийгмийн хувьсал өөрчлөлтөд хувь нэмэр оруулах гэсэн хоёр талт зорилго өвөрлөн үйлчлэхүйн зам мөрд урагшлахад тань туслахад оршино. Эхний сургалтад та хамрагдсанаар энэхүү зам мөрөөр алхана гэдэг нь Бахауллагийн Сургаал бичвэрт зөгнөсөн дэлхийн шинэ эмх журмын зорилгоос харцаа салгалгүй үйлдэх янз бүрийн үйлчилгээ байдаг гэдгийг бид хэдийнээ ойлгож авсан билээ. Тиймээс бидний нэрлэж заншсанаар “үйлчлэхүйн замаар алхахуй” хэмээх нь Түүний сургаалыг өөрийн болон хүн төрөлхтний амьдралд хэрэгжүүлэхээр зорьж буй бидний хичээл зүтгэлийг хэлнэ. Тэрээр Үүдэл нээлтийнхээ талаар ийнхүү өгүүлжээ:

“Аяа, Миний шадар зарц нараа! Миний ариун, тэнгэрлэг зарлигаар бий болсон Миний Үүдэл нээлтийг бүхнийг гялбуулан цацрагч, агуу их үнэт эрдэнийн тоо томшгүй их сувд эрдэнэсийг гүн ёроолдоо нуусан тэнгис далайтай зүйрлүүлж болох юм. Өөрийгөө дайчлан, энэхүү тэнгис далайн эрэгт хүрэхийг тэмүүлж, улмаар эрмэлзлийнхээ эрч хүч хийгээд гаргасан хүчин чармайлтынхаа хэрээр Бурханы буцашгүй бөгөөд нуугдмал Судар бичигт урьдчилан айлдсан ач тусаас хүртэх нь эрэлч хүн бүрийн үүрэг болой.”¹

Энэхүү эхний бүлэгт бид Бахауллагийн Үүдэл нээлтийн их далайд орших мэргэн ухааны сувд эрдэнэсийг нээж, бусадтай хуваалцсанаар зүрх сэтгэлийг маань бялхаах тэр баяр жаргал руу бидний бодол санаа тэмүүлдэг тухай судлах юм. Түүний Сургаалууд дахь тэнгэрлэг удирдамжийн сувд эрдэнэсийн яруу тансгийг Нэгдүгээр номыг судалснаар та хэдийнээ мэдэрсэн билээ. Энэ талаар дахин хэдэн эшлэл тунгаан бясалгацгаая:

“Бурханы айлдвар бол дэнлүү, харин дэнлүүний гэрэл нь гэвэл дараах үгс юм: Та нар бол нэгэн модны жимснүүд, нэг мөчрийн навчис болой.”²

“Миний сэтгэлд бүхнээс эрхэмлэдэг зүйлийн дээд нь шударга ёс. Хэрэв Намайг хүсвээс шударга ёсноос нүүрээ бүү буруул, хэрэв Миний итгэлийг эрвээс шударга ёсыг бүү үл орхи.”³

“Амьдарч байгаа цаг үеийнхээ шаардлага хэрэгцээнд санаа сэтгэл тавьж, ухаан бодлоо түүний хэрэгцээ шаардлагад тохируулж яв.”⁴

“Бүх хүмүүс ямагт хөгжин дэвших соёл иргэншлийг урагшлуулахын тулд бүтээгдсэн билээ.”⁵

“Хорвоо мөнх бус. Мөнхөд орших нь Бурханы хайр.”⁶

“Чи болбоос Миний зул, Миний гэрэл чамд оршиж буй нь тэр. Чи түүгээр гэрэлтэн бадамлаж, Надаас өөрийг бүү эрж хай. Учир нь Би чамайг баян болгож бүтээсэн агаад ивээл хайраа чам дээр өгөөмрөөр тусгасан болой.”⁷

Эдгээр богино эшлэлүүдийг хэсэг хугацааны турш цээжлэхийг санал болгоё.

2 ДУГААР ХЭСЭГ

Энэхүү бүлэгт судлах үндсэн сэдвийг эхлүүлэхээсээ өмнө дээрх хэсгийн эшлэлүүдийг дахин уншаад, дараах дасгалыг хийнэ үү:

1. Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү.

а. Өөрийгөө _____ Бахауллагийн Үүдэл Нээлтийн тэнгис далайн _____ нь бидний үүрэг болой.

б. Бид Бахауллагийн Үүдэл нээлтийн энэхүү тэнгис далайн эрэгт хүрэхийг тэмүүлж, улмаар _____ хийгээд гаргасан _____ Бурханы бөгөөд нуугдмал Сударт бичигдсэн урьдчилан айлдсан _____ хүртэнэ.

в. Бахауллагийн Үүдэл нээлтийн ач тусаас бид _____ хийгээд _____ хэрээр хүртэнэ.

2. Өөрийгөө “дайчлах” гэж юу гэсэн утгатай вэ? _____

3. Аливаад “хүрэхийг тэмүүлэх” гэж юу гэсэн утгатай вэ? _____

4. Эрэлч хүн бүр юунд хүрэх гэж тэмүүлэх хэрэгтэй вэ? _____

5. Аливаа зүйлийг хэмжээнийхээ хэрээр хүртэнэ гэдэг нь юу гэсэн утгатай вэ? ____

6. Гаргасан хүчин чармайлтынхаа хэрээр Бахауллагийн Үүдэл нээлтийн тэнгис далайгаас ач тус хүртэнэ гэж Бахаулла бидэнд айлджээ.

a. Энэхүү ач тусаас хүртэхийн тулд бидний гаргадаг хүчин чармайлтын хэдэн жишээ гаргана уу. _____

b. Бидний хүртдэг ач тусын хэдэн жишээ гаргана уу. _____

3 ДУГААР ХЭСЭГ

Бахауллагийн Үүдэл Нээлт бол гүн ёроолдоо үнэлж баршгүй сувд эрдэнэс бүхий далай мэт гэдгийг бид мэдэх тул эдгээр буян хишгээс хүртэж, энэхүү тэнгис далайн эрэгт хүрэхэд нь бусдад тусалж дэмжихийн тулд бүхий л хүчин чармайлтаа гаргах шаардлагатай. Гэхдээ тэнгис далайн эрэг нь хэр хол юм бол хэмээн өөрөөсөө асууж болох юм. Бахаулла ийнхүү айлджээ:

“Аяа, шадар зарц нар аа! Цорын ганц үнэн Бурхан Миний гэрч! Энэхүү нэн агуу, ёроолгүй давлагаалагч Далай болбоос та нарт тун ойр, гайхалтай их ойр шүү. Энэ нь амин судаснаас чинь их ойр гээч! Та нар хүсэх л юм бол нүд ирмэхийн хурдаар энэхүү дундаршгүй адис ивээл, энэхүү Бурханаас заяасан хишиг, энэхүү гандашгүй бэлэг, энэхүү нэн хүчирхэг, дүрсэлшгүй үзэсгэлэнт буян хишгээс хувь хүртэж чадмой.”⁸

1. “нэн агуу ёроолгүй давлагаалагч Далай” гэж юуг хэлж байгаа вэ? _____

-
2. Энэ далай бидэнд хэр ойрхон байгаа вэ? _____
-
3. Энэ далайд бид хэр түргэн хүрч болох вэ? _____
-
4. Дараах өгүүлбэрүүдийг гүйцээнэ үү:
- a. Бахауллагийн Үүдэл нээлтийн нэн агуу ёроолгүй далай бидэнд тун ойр, _____ ойр шүү.
- b. Бахауллагийн Үүдэл нээлтийн нэн агуу ёроолгүй далай бидний амин судаснаас ч _____ гээч.
- c. Бид хүсэх л юм бол, Түүний Үүдэл нээлтийн их далайгаас _____ зуур _____ чадна.
- d. Бид _____, Түүний Үүдэл нээлтийн нэн агуу далайгаас нүд ирмэхийн зуур хувь хүртэж чадна.

4 ДҮГЭЭР ХЭСЭГ

Бахауллагийн Үүдэл Нээлтийн далайн эрэгт хүрэхэд Түүний эрдэнэсээс хүртэж, тэнгэрлэг удирдамжийн сувд эрдэнэсийг ямар ч нөхцөл болзолгүй, өгөөмрөөр бусадтай хуваалцах бөгөөд сурч судлах, мөргөж бясалгах хийгээд Түүний Үйл хэрэг болон хүн төрөлхтөнд үйлчлэх өөрсдийн хүчин чармайлтаас тасралтгүй нээн илрүүлэх болно. Доорх сургаал нь энэхүү үүргийг ариун нандин болохыг бидэнд байнга сануулж байгаа бөгөөд цээжлэх хүсэл төрж байгаа биз ээ.

“Бурханы замаар замнагч аянчин минь ээ! Түүний гоо жавхлангийн тэнгис далайгаас хувь тасалж, гүн ёроолд нь нуугдмал буй зүйлсээс бүү татгалз. Түүний эрдэнэсээс хүрт. Энэхүү тэнгис далайн нэгхэн дусал тэнгэр диваажин хийгээд энэ дэлхий дээр байгаа бүхнийг Хамгаас Хүчит, Бүхнийг Мэдэгч, Бүхнээс Мэргэн ухаантан Бурханы ивээл хишгээр баяжуулан хангаж чадмой. Өөрөөсөө татгалзах буяны мутраар түүний амьдрал хайрлагч рашаан уснаас алга дүүрэн хутгаж, хамаг бүхэнд цацагтун. Чингэвээс хамаг бүхэн хүний бий болгосон бүхий л хязгаарлагдмал чанараас ариусаж, Бурханы хүчирхэг суудал буюу энэхүү ариун бөгөөд үзэсгэлэнт Газар ойртон дөхөх болно.”

5 ДУГААР ХЭСЭГ

Институтын сургалтуудаар дэвшин суралцахдаа шаардагдах судалгаа, дадлага ажлыг хийснээр үйлчлэх чадавхаа нэмэгдүүлж, бидний зүрх сэтгэлийг хязгааргүй их аз жаргалаар дүүргэх мөн амьдралын хоёр талт зорилгоо биелүүлэхэд тус болохуйц хүүхэд багачуудад оюун санааны боловсрол олгох хичээл заах, оюун санааны хувьд чадавхжуулах хөтөлбөрт өсвөр насныхныг оролцуулах, анд нөхдөө шаталсан сургалтуудад хамруулах гэх мэт үйлчилгээний талбаруудад үйлчлэхэд биднийг чадавхжуулах юм. Хөгшин залуу хамаагүй бүхий л хүмүүстэй хуваалцаж байгаа Бурханы Үг бол энэхүү аяллын туршид биднийг тэтгэх урам зоригийн байнгын ундарга нь болж байх юм. Хүний зүрх сэтгэлд нөлөөлөх үүний хүч нөлөөг эргэцүүлэн бясалгаж байх нь зохистой билээ. Дараагийн эшлэлд энэхүү хүчний талаар Бахауллагч ийнхүү айлджээ:

“Бурханы Үгийг хүмүүсийн зүрх сэтгэлд үндсийг нь ургуулсан нялх ургамалтай адилтгаж болно. Үндэс нь бат төгс болж, мөчир нь тэнгэр диваажин ба түүнээс ч дээш дүүлэхийн тулд чи түүнийг мэргэн ухаан, ариун гэгээн үг айлдварын амьдрал хайрлагч рашаан усаар ундаалан тордогтун.”¹⁰

1. Бурханы Үгийг юутай адилтгаж болох вэ? _____

2. Бурханы Үгийн модны үндсийг хаана ургуулсан бэ? _____

3. Бид энэ модыг хэрхэн тордох ёстой бэ? _____

4. Энэ мод хэр өндөр ургах боломжтой вэ? _____

5. Бурханы Үгийг бусадтай хуваалцах нь яагаад чухал болохыг хэдэн өгүүлбэрээр тайлбарлана уу. _____

—

6 ДУГААР ХЭСЭГ

Өдөр тутмын амьдралд хийдэг төрөл бүрийн зүйлсээ бодож үзэцгээе. Бид бие махбодоо торддог. Бид шинэ мэдлэг эзэмшиж, оюуны чадвараа нэмэгдүүлэхийн тулд суралцдаг. Бид ажил эрхлэн, нийгэмд гар бие оролцож буй иргэн нь байхын тулд хэрэгтэй чадвараа хөгжүүлдэг. Бид спортоор хичээллэж, амарч зугаалдаг. Оюун ухааны болон материаллаг хөгжилд маань чухал энэ мэтчилэн олон зүйлс ихэнх цагийг маань авдаг. Мөргөл үйлдэх, тэнгэрлэг сургаалыг ганцаараа болон найз нөхөдтэйгөө судлан гүнзгийрэх, эсвэл Бахауллагийн Үүдэл Нээлтийн далайд нуугдмал орших эрдэнэсийг хайхад өөрсдийн эргэн тойронд байгаа нэгэнд туслах гэхчлэн оюун санаагаа идэвхжүүлэх онцгой цаг үе бас байдаг. Эдгээр цаг үе нь хэмжихийн аргагүй үнэ цэнтэй биш гэж үү? Эдгээр тэнгэрлэг адис ивээлээс хувь хүртэхээс илүү баяр жаргал бий гэж үү?

Хүн төрөлхтний хөгжил дэвшлийн төлөө өөрийгөө зориулахыг Абдул-Баха бидэнд уриалж байсныг ямагт санаж явах учиртай:

“Биднийг Тэнгэрлэг үйл хэрэг нэгтгэж байгаа бөгөөд бид ямар ч материаллаг зорилгыг өвөртлөөгүй билээ. Бидний хамгаас эрхэм хүсэл бол Бурханы Хайрыг дэлхий даяар түгээн дэлгэрүүлэх явдал билээ!”¹¹

Нэгдүгээр хэсэг дээр цээжилсэн эшлэлийг найзтайгаа хуваалцах боломж танд олдлоо хэмээн төсөөлье. Таны зүрх сэтгэлдээ мэдрэх баяр жаргал хаанаас үүдэлтэй вэ? Найз чинь Бахауллагийн сургаалаас урам зориг авна гэж чи найдаж болох юм. Гэтэл найз чинь хүссэн шиг чинь урам зориг авахгүй бол чи яах вэ? Зүрх сэтгэлийг чинь дүүргэх баяр жаргал сарнин алга болох уу? Үгүй бол яагаад?

7 ДУГААР ХЭСЭГ

Амьдралдаа хийж гүйцэтгэдэг бүхий л зүйлийн дотроос Бурханы үгийг бусадтай хуваалцаж буй хором мөч бүрээс онцгой ивээл хишгийг хүртдэг гэдгийг ойлгосноор чухал дүгнэлтэд хүрсэн нь үйлчилгээнээс хүртдэг баяр жаргал бол хийж буй үйлийн

дотоодод байдаг тухай ойлголт юм. Мэдээж бид хийж буй үйлчилгээгээ үр дүнтэй байлгахыг хүсэх нь зүйн хэрэг хэдий ч үр дүнд анхаарлаа хэт төвлөрүүлээд, бусдын магтаал болон шүүмжлэлд хэт их автах юм бол сургаалыг багшлахуйн баяр жаргалаа гээх болно. Бид амжилтад хүрэх, ашиг хүртэх, нэр хүнд олох хүслээр биш харин хайрласандаа л үйлчлэх урам зоригийг өгдөг нь Бурханы хайр юм. Эдгээрээс ангижрах сэтгэлийг олох нь баяр жаргалтайгаар үйлчлэх нэгэн шаардлага билээ. Дараах эшлэлүүдийг судалбал энэхүү чухал сэдвийг гүнзгийрүүлэн бясалгахад тус болно.

“Аяа, Хоёр мэлмийт хүмүүн! Нэг нүдээ аньж, нөгөөг нь нээ. Энэ дэлхий хийгээд түүнд байгаа бүхэнд нэг нүдээ аньж нөгөө нүдээрээ Хайрт Эзнийхээ бишрэм Гоо сайхныг харж яв.”¹²

“Аяа, Анд нөхөд! Зуурдын гоо сайхны хойноос хөөцөлдөн Мөнхийн гоо сайхныг бүү март, зуурдын энэ тоост орчлонгийн юмст дур хүслээ бүү зориул.”¹³

“Аяа, Үгийн үр! Нүүрээ зөвхөн Надад хандуулж, Надаас бусад бүхнээс хөндийр. Миний эрхшээл мөнх бөгөөд Миний ноёрхол хувиршгүй. Хэрэв чи Надаас өөр бусдыг эрэх ахул, тиймээ, бүх л орчлонг ч нэгжих ахул эрэл чинь мухардах буюу.”¹⁴

“Аяа, найрсгаар угтуулсан үл таних хүн! Зүрхний чинь дэнлүүг Би хүчит мутраараа асаасан, түүнийг хувиа хичээх үзэл, шунал тачаалын сөрөг салхинд бүү бөхүүл. Өвчин эмгэг бүхнийг чинь илаарьшуулах зүйл гэвэл Намайг дурсан санах явдал, үүнийг бүү умарт. Намайг хайрлах хайраа өөрийн эрдэнэ болго, түүнээ нүднийхээ цөцгий, амь амьдрал мэт сахин дээдэл.”¹⁵

“Орчлонгоос ангижран чөлөөлөгдөх явдал нь нар лугаа адил бөгөөд ямар ч хүний зүрх сэтгэлд асан бадамлах аваас элдэв атаа шунал, бие чөтгөрийн галыг унтраана. Мэлмийн харц нь ухаарлын гэрлээр гийсэн хэн боловч газар дэлхий болон түүний хоосон чанараас өөрийгөө хөндийрүүлэх нь гарцаагүй... Энэ хорвоо ба түүний олиггүй явдал чамайг бүү гонсойлгог. Эдээр баян ч бардам биш, ядуу дорой ч уйтгар гунигт үл автагч хүмүүн аз жаргалтай билээ.”¹⁶

1. Энэ ертөнцөөс ангижрах гэдэг нь даяанч шиг амьдарна гэсэн үг үү? _____
2. Энэ ертөнцөөс ангижран хөндийрсөн мөртөө эд баялаг эзэмшиж болох уу?

3. Амьдралынхаа хором бүрийг ажилдаа зориулдаг хүн энэ ертөнцийн зүйлсээ ангижирсан уу ? _____
4. Наад захын шаардлага хэрэгцээгээ хангахын тул ажиллачхаад бусад цаг үед нь юу ч хийхгүй байгаа хүн энэ ертөнцөөс ангижирсан байна уу? _____
5. Үйлчилгээний талбар дээр материаллаг тав тухыг эрэлхийлж байгаа хүн энэ дэлхий ертөнцийг зүйлсээс ангижирч уу? _____
6. Материаллаг эд зүйлсээс гадна өөр олон зүйлд бидний сэтгэл татагддаг.
7. Дараах тохиолдолд хүн юунд татагдсан байна бэ?
- a. хийж буй үйлчилгээг нь хэн ч үнэлж тоогоогүй учир бууж өгөхөөр шийдсэн

- b. гаргасан санал нь дэмжигдээгүйд бухимдах мэдрэмж төрж байгаа _____

- c. бусдын шүүмжлэлээс эмээсэндээ өөрийн итгэл үнэмшлээ нуудаг _____

8. Ангижрал гэдэг бол хүйтэн хөндий, анхаарал халамжгүй гэсэн утгатай биш юм. Дараах өгүүлбэрийн аль нь ангижрахгүй байгааг илэрхийлж байна бэ?
_____ Бусдад гарч буй ахиц дэвшлийг хараад аз жаргал төрдөг

_____ Цөөхөн хүүхэд дүрсгүйтсэний төлөө хичээл заахаа болих
_____ Бусдын амжилтаар сайрхах

_____ Хичээлээ тун сайн хийсний ачаар өөрийн гаргасан дэвшилдээ сэтгэл хангалуун байх

_____ Нийтийн сайн сайхны төлөө үйлчлэх чадвараа хөгжүүлэхийн тулд хичээнгүйлэн зүтгэх

_____ Мэргэжлээ төгс эзэмшихийг эрмэлзэх

_____ Гэр орноо цэвэр цэмцгэр, эмх цэгцтэй байлгаж, цэвэрлэх

_____ Өөрийн эд зүйлсээ хариуцах

_____ Бусдын сайн сайхны төлөө санаа тавих

_____ Гаргасан хүчин чармайлтыг нь сайшааж магтахгүй бол сэтгэлээр унах

8. Ангижрал бол хүн бүрд чухал сэдэв тул энэхүү хэсэгт толилуулсан бүх эшлэлүүдийг цээжлэхийг танд зөвлөж байна.

8 ДУГААР ХЭСЭГ

Хүн төрөлхтөнд үйлчлэх амьдралын баяр жаргалын буян хишгээс хүртэхийн тулд хичээл зүтгэл гаргаж, золиослонгуй хандах ёстой юм. “Золиослох” гэдэг үгийг бид амьдралдаа байнга хэрэглэдэг. Хэрвээ найз чинь аяллаасаа үүрээр буцаж ирэхэд нь угтаж авахын тулд өглөө эрт босох байх. Унтах цагаасаа золиослов гэж ярьдаг. Ойр дотно хэн нэгэн маань өвдөхөд бид өөрсдийн чөлөөт цагаа золиосолж түүнийг асардаг. Амьдралд асар их шаргуу хөдөлмөрлөх үе тохиодог бөгөөд тэр үед урдаа тавьсан зорилгодоо хүрэхийн тулд тав тухаа золиосолж байна гэж бодож магадгүй.

Үйл хэрэгт үйлчлэх хүсэл эрмэлзэл бид бүхэнд дүүрэн байдаг болохоор цаг хугацаа болон эрч хүчээ өгөөмрөөр зориулахаас гадна цаашлаад материаллаг эд хөрөнгөнөөсөө зарцуулдаг. Үйлчлэхүйн замаар ийнхүү алхаж байхдаа энэ дэлхийн бүхий л зүйлийг орхих хэрэгтэй боловч оюун санааны хувьд өсөж хөгжин, жинхэнэ баяр жаргалыг хүртэнэ гэдгийг бид санаж байх хэрэгтэй. Дараагийн сургалтуудаар бид золиослохуйн мөн чанарын талаар илүү дэлгэрэнгүй эргэцүүлэн судална. Мод болон ургахын төлөө үр жимс өөрийгөө золиосолдгийн нэгэн адил дээд үйлийн төлөө доод зүйлээс татгалзахад золиослохуйн мөн чанар оршино гэдгийг анхнаасаа ухаарах нь чухал юм. Золиослохуйн баяр жаргалыг хүртээдэг бөгөөд тууштай хүчин чармайлт гаргахгүй л бол энэхүү баяр жаргалаас бид хүртэж чадахгүй юм.

“Түүнийг эрж хайх ахул хөдөлмөр хэрэгтэй, Түүнтэй нэгдэхийн бал бурмаас амсах ахул оролдлого идэвх хэрэгтэй бөгөөд бид энэ бумбаас хүртэх аваас энэ дэлхийг орхин одно.”¹⁷ хэмээн Бахаулла айлдсан бол Абдул-Баха бидэнд ийн зөвлөжээ:

“... бүү амрагтун, бүү тайвшрагтун, зуурдын энэхэн хорвоогийн элбэг дэлбэгт бүү автагтун, сэтгэлийн хамаг уяаснаас өөрийгөө чөлөөлж Бурханы Хаант улсад баттай оршихын төлөө бүхий л сэтгэл зүрхээрээ тэмүүлэгтүн. Тэнгэрлэг эрдэнэсээс олж авагтун. Өдрөөс өдөрт гялалзан гэрэлтэгтүн. Эв нэгдлийн босгонд улам бүр ойртогтун.”¹⁸

Бид зорилгодоо хүрэхийн тулд хичээл зүтгэл гаргах ёстой гэж итгэдэг. Гэвч энэхүү энгийн итгэл үнэмшил нь бодит байдал дээр тодорхой нөхцөлийг шаардаж байдгийг мартаж болохгүй. Нэгдүгээрт, зорьсон зорилт, хийх даалгавраа гүйцэтгэхэд хэр их хөдөлмөр хүчин чармайлт болон хэдий их энерги хүч шаардагдах нь өөр хоорондоо хамааралтай бөгөөд харилцан нөлөөлнө гэдгийг санах хэрэгтэй. Хичээл зүтгэл гаргахгүйгээр зорилгодоо амархан хүрнэ хэмээн бодвол өөрийгөө хуурч байгаа хэрэг юм. Гэхдээ хичээн чармайлт нь амжилтыг дүгнэх цорын ганц хэмжигдэхүүн биш юм. Тогтвортой бөгөөд тууштай байх ёстой. Мөн анхаарлаа төвлөрүүлэх чухал шаардлагатай. Хийж буй юмаа дуусгахгүйгээр, нэгээс нөгөө рүү үсчилгүй байж нэг зүйлээ тогтвортой хийх нь аливааг гүйцэтгэхэд шаардлагатай чухал дадал билээ. Хагас дутуу оролдлогоор ямар ч үр дүнд хүрэхгүй. Долоо хоног тутам явуулдаг хүүхдийн оюун санааны боловсролын хичээлийг аваад үзье. Багш хичээл бүхнээ бэлдэхэд заавал тодорхой хэдэн цагийг зориулан, хичээлийн турш тухайн хичээлийн агуулгыг ойлгоход нь шавь нараа дэмжиж туслах, хүүхдүүдийнхээ эцэг эхтэй тогтмол уулзах, тэдний ахиц дэвшлийг нэг бүрчлэн тэмдэглэх зэргийг долоо хоног тутам тогтмол хийдэг. Багш хичээлээ санасан үедээ бэлтгэдэг, ядрахаараа ангиа цагаасаа эрт тараадаг, хүүхэд нэг гарч буй өөрчлөлтийг эцэг эхтэй нь хэлж ярихад цагаа зориулдаггүй бол ямар үр дүнтэй байх вэ? Эсвэл багш нь өөрт нь чухал ажил гарах жишээлбэл өөр хотоос ирсэн найзтайгаа уулзах гэх мэтийн тохиолдлуудад хичээлээ хойшлуулаад байвал ямар үр дүн гарах вэ?

Дээр дурдсан санаагаар гаргаж буй хүчин чармайлт болон үр дүн, чанарт аль алинд нь анхаарал хандуулах ёстой гэдгийг л анхааруулах гэсэн юм. Энэ асуудал зөвхөн үйлчилгээ хийхэд хамаараад зогсохгүй бидний хөгжил дэвшилд ч мөн хамаатай юм. Түүнчлэн, цуврал сургалтын эхний номоос таны судалсан оюун санааны дадал болгох тогтмол мөргөл үйлдэх, Сургаал бичмэлээс өдөр бүр уншиж, судлах, судалсан сургаалаа амьдралд хэрхэн хэрэгжүүлэх, мөргөлийн цуглаанд чин сэтгэлээсээ оролцох зэрэг нь таны тасралтгүй хүчин чармайлтаас хамаарах юм. Дараах өгүүлбэрүүд нь хүчин чармайлт гаргах тухай юм. Эдгээрийн аль нь үнэн зөв болохыг сонгох дасгал хийх нь энэхүү сэдвийг цаашдаа эргэцүүлэхэд тань тус нэмэр болох болно:

_____ Хэрвээ чи ухаантай бол их хөдөлмөрлөх шаардлагагүй.

_____ Урт зам туулах хэрэг юу байна? Ямагт дөт зам хайж бай.

_____ Зовохгүйгээр амжилт олохгүй

_____ Томоор мөрөөдөж явбал хүсэл чинь биелнэ.

- _____ Том шагналд их зүтгэл оршдог.
- _____ Хүчин зүтгэл их байх тусам үр дүн нь “илүү амттай” байна.
- _____ Эхэндээ амжилтгүй байсан ч дахин дахин оролд
- _____ Чамайг чадахгүй бол бусад нь хийгээд өгөхөөс хойш хөдөлмөрлөх хэрэг байна уу?
- _____ Хэрвээ их хүчин чармайлт шаардагдвал утгагүй зүйл
- _____ Жижиг алхаад, зогсолтгүй бөгөөд тууштай байхад хол замыг туулдаг
- _____ Үнэ цэнтэй зүйл амар хялбар олддоггүй.
- _____ Аливаад чин сэтгэлээсээ хандан, өөрийгөө зориулснаар төгс төгөлдөрт хүрнэ.
- _____ Мянган бээрийн аялал нэг алхмаас эхэлнэ.
- _____ Зүтгэхгүй, зүгээр л додомдох нь олиггүй
- _____ Болно гээд гараа хумхиж хүлээлгүй өөрсдөө хийх учиртай.
- _____ Амжилт гэдэг бол азын л асуудал.
- _____ Бид хоёр талт зорилгодоо ид шидээр хүрэхгүй.
- _____ Бид амьдралынхаа зам мөрийг өдөр бүр тунгаах ёстой.

Бид үйлчлэхүйн замаар алхах явцдаа оюун санаа болон оюун ухаанаа хөгжүүлж, нийгмийг хувьсган өөрчлөхөд хувь нэмрээ оруулахын тулд хичээн чармайдаг. Энэхүү хоёр талт зорилгоо биелүүлэхэд бидний зүгээс асар их хүчин чармайлт шаардагдах нь илэрхий билээ. Бахаулла бидэнд айлдахдаа:

“Зүйрлэшгүй Бүтээгч Бурхан бүх хүмүүсийг нэг л бодиос бүтээж, тэдний мөн чанарыг хамаг амьтнаас давуу байхаар соёрхжээ. Тиймээс амжилт, уналт, ашиг, алдагдал бүхэн нь бүгд хүний өөрийнх нь хүчин чармайлтаас шалтгаалах ёстой. Хүн хэдий чинээ хичээн чармайна, төдий чинээ хөгжин дэвшинэ.”¹⁹

Та энэ эшлэлийг өмнө нь цээжилж байгаагүй бол цээжлээрэй.

9 ДҮГЭЭР ХЭСЭГ

Үйлчлэхүйн баяр жаргалыг мэдрэхийн тулд бид зарим нэг хандлагыг төлөвшүүлэх ёстой. Жишээ нь, Бурханаас бидэнд хүртээсэн үйлчлэхүйн буянд бид талархаж явах учиртай бөгөөд Түүний Үйл хэрэгт үйлчилж байгаагаа Түүнд тус хүргэж байгаа мэтээр бодож хэрхэвч болохгүй. Бид гутранги үзлээс зайлсхийж амьдралыг ямагт өөдрөгөөр харж сурах ёстой. Үйлчлэхүйн замд тулгарах саад бэрхшээлийг цаашдын хөгжил дэвшилд хүргэх гишгүүр болгон хувиргаж болно. Ярвигтай, хэцүү бэрх нөхцөл үүссэн ч ирээдүйгээ бид итгэл дүүрэн харна. Абдул-Баха, бидний хүчин чармайлтын нэгэн чанар болох итгэл найдвар, өөдрөг үзлийн талаар ийн өгүүлжээ:

“Эхэндээ өчүүхэн байсан үр эцэстээ сүрлэг том мод болон ургадаг. Үрийг нь бүү хар; сүрлэг том мод, түүний цэцэг, навч, үр жимсийг нь хар.”²⁰

“Тиймийн учир жинхэнэ Тариаланч нигүүлслийн мутраараа Их Эзний хагалсан талбайд тарьж, хишиг буяны хур бороогоор усалж, Үнэний Нарны дулаан илч, гэрэл гэгээнд ургуулж буй энэ өчүүхэн үрийн амин чухал ач холбогдлыг хүлээн зөвшөөр.”²¹

“Мод ургаж хөгжиж байвал үр шимээ өгнө хэмээн найдаж бай. Тэр мод цэцэглэж, эцэст нь үр жимсээ өгөх л болно. Харин мод хатаж эсвэл хөгширсөн байвал үр жимс өгнө гэх найдвар үгүй.”²²

“Иймийн тулд Бурханы хайрыг хүлээгсэд итгэл найдварын энэхүү модыг хүсэл эрмэлзлийнхээ усаар усалж хичээнгүйлэн арчилж ургуулах ёстой.”²³

“Зүрх сэтгэл Бурханы адислалаас татгалзах юм бол жаргалд хүрнэ гэж яаж найдах юм бэ? Итгэл найдвараа Бурханы Өршөөл ивээлд даатгахгүй юм бол амирлыг яаж олох юм бэ?”²⁴

Эдгээр эшлэлүүдийг эргэцүүлэхийн тулд дараах өгүүлбэрүүдийг гүйцээнэ үү:

1. Эхэндээ өчүүхэн байсан үр эцэстээ _____

2. Бид өчүүхэн үрийг бус, харин _____
_____ харах ёстой.

3. Тийм ч учраас бид Бурханы, нигүүлслийн мутраараа _____

_____ өчүүхэн үрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрөх ёстой.
4. Ургаж буй модыг үзээд би

5. Мод ургаж байгааг хараад бид тэр мод _____
хэмээн найдаж байх ёстой .
6. Хүсэл эрмэлзлийнхээ усаар бид _____
_____ ёстой.
7. Зүрх сэтгэл Бурханы адислалаас татгалзах юм бол _____
_____ ?
8. Итгэл найдвараа Бурханы Өршөөл ивээлд даатгахгүй бол _____
_____ ?

Одоо хэсэгхэн зуур эргэцүүлье: бидний мэдэрч буй баяр жаргал, итгэл найдвар нь даруу төлөв, талархах сэтгэлтэй хосолбоос бусдад аз жаргал бэлэглэх эх үүсвэр болно гэдэгтэй та санал нийлэх үү? Бурханы Үйл хэрэгт үйлчлэхээр зориглон босохдоо бид шинэ Өдөр буюу хүн төрөлхтнийг нэгтгэх тэр Өдөр хаяанд ирсэн тухай баярт мэдээг тээж яваа гэдгээ ямагт санаж явцгаая. Бахауллагийн айлдвар зүрх сэтгэлд маань эгшиглэх болтугай:

“Үйл хийдэг хүмүүс жаргалтай; ухаарч ойлгодог хүмүүс жаргалтай; тэнгэр хийгээд газар дээрх хамаг бүхнээс хөндийрч үнэнээс зуурч авсан тэр хүн чухам жаргалтай.”²⁵

ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. *Бахауллагийн сургаалын дээжис* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1983, 2017 оны хэвлэл), CLIII, 5-р догол мөр, 369-р нүүр.
2. Дээрхийн адил, CXXXII, 3-р догол мөр, 326-р нүүр.
3. Бахаулла, *Эрдэнийн нуугдмал үгс* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2003, 2012 оны хэвлэл), Араб хэл дээрх но. 2, 3-р нүүр.
4. *Бахауллагийн сургаалын дээжис*, CVI, 1-р догол мөр, 241-р нүүр.
5. Дээрхийн адил, CIX, 2-р догол мөр, 243-р нүүр.
6. Бахаулла, *Эмэгтэйчүүд: Бахаулла, Абдул-Баха, Шоги Эффенди болон Дэлхийн Шударга Ёсны Ордоны сургаалын түүвэр*, Дэлхийн Шударга Ёсны Ордоны дэргэдэх Судалгааны Хэлтсээс эмхэтгэснээр (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1986, 1997 оны хэвлэл), но. 53, 26-р нүүр.
7. *Эрдэнийн нуугдмал үгс*, Араб хэл дээрх но. 11, 6-р нүүр.
8. *Бахауллагийн сургаалын дээжис*, CLIII, 5-р догол мөр, 370-р нүүр.
9. Дээрхийн адил, CXXIX, par. 1, p. 316.
10. Дээрхийн адил, XLIII, par. 9, p. 109.
11. Абдул-Бахагийн 1911 оны 11-р сарын 19-нд хэлсэн үгнээс, *Парист айлдсан айлдварууд* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2006, 2016 оны хэвлэл), но. 32.2, 121-р нүүр.
12. *Эрдэнийн сургаал үгс*, Перс хэл дээрх но. 12, 26-р нүүр.
13. Дээрхийн адил, Перс хэл дээрх но. 14, 26-р нүүр.
14. Дээрхийн адил, Араб хэл дээрх но. 15, 7-р нүүр.
15. Дээрхийн адил, Перс хэл дээрх но. 32, 33-р нүүр.

16. Бахаулла, *Бахайн Ертөнц: Тэргүүн боть, 1925-1926* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1926, 1980 оны хэвлэл), 42-р нүүр.
17. *Тэнгэрлэг Хайртын Дуудлага: Бахауллагийн шидэт Сургаалын түүвэр* (Хайфа: Бахайн Дэлхийн Төв, 2018), но. 2.12, 17-р нүүр.
18. *Хойд Америкийн Бахайчуудад хандан Абдул-Бахагийн нээсэн Тэнгэрлэг Төлөвлөгөөний Бичиг* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 1993, 2006 оны хэвлэлт), но. 13.6, 95-96-р нүүр.
19. *Бахауллагийн сургаалын дээжис, XXXIV*, 8-р догол мөр, 91-р нүүр.
20. *Абдул-Бахагийн сургаалын түүвэр* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2010, 2015 оны хэвлэл), но. 40.3, 118-19-р нүүр.
21. Дээрхийн адил, но. 40.3, 119-р хуудас.
22. 1912 оны 5-р сарын 11-нд хэлсэн үгнээс, *Энх тайвны тунхаг бичиг: Абдул-Бахагийн 1912 онд АНУ болон Канад улсад айлчлахдаа айлдсан айлдварууд*. (Уильметт: Bahá'í Publishing, 2012), 2-р догол мөр, 153-р нүүр.
23. *Абдул-Бахагийн сургаалын түүвэр*, но. 206.13, 356-57-р нүүр.
24. Абдул-Бахагийн 1911 оны 11-р сарын 21-нд хэлсэн үгнээс, *Парист айлдсан айлдварууд*, но. 34.8, 133-р нүүр.
25. Бахаулла, *Чонын Хөвүүнд илгээсэн захидал* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1988, 2016 оны хэвлэл), 139-р нүүр.



Сэтгэл сэргээсэн харилцан яриа

Зорилго

Харилцан яриандаа оюун санааны зарчмуудыг
танилцуулах чадварыг олж авах

1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Энэ номын эхний бүлэгт бид Бурханы Үгийг бусадтай хуваалцах үед авдаг хэмжээлшгүй их баяр жаргалын талаар өгүүлсэн билээ. Үйлчлэхүйн замаар замнахад Бахауллагийн Үүдэл нээлтээс олж авсан ойлголтоо найз нөхөд болон танил хүмүүстэйгээ ярилцах боломж бидэнд маш их гардаг. Утга учиртай, сэтгэл сэргээсэн харилцан яриа өрнүүлэхэд хувь нэмрээ оруулах нь бидний хөгжүүлэх шаардлагатай чадваруудын хамгийн чухал нэг нь юм. Үүнд нэмэр дөхөм болох нь энэ болон дараачийн бүлгийн зорилго юм. Мөн боломж бололцоо нь бүрдсэн цагт оюун санааны зарчмуудыг харилцан яриандаа хэрхэн ашиглах ба уг чадвараа хэрхэн хөгжүүлэх талаар суралцах болно. Бичил хороо, сум дүүрэг, тосгон юм уу бичил хороонд эрч хүчтэй нийгэмлэг байгуулах системтэй үйл ажиллагаа, хүчин чармайлтын нэг нь тодорхой нэгэн сэдвээр цуврал яриаг эхлүүлэн, тогтвортой үргэлжлүүлэх талаар эргэцүүлэн бодоход дараагийн бүлэг хөтлөх юм.

Дараа дараагийн хэсгүүдэд юу хийх вэ гэвэл, төрөл бүрийн сэдвээр хэд хэдэн тодорхойлолт судлах бөгөөд тэдгээр нь сургаалаас яг эшлэн аваагүй ч гэсэн Абдул-Бахагийн Илгээлтүүд болон Түүний яриа айлдваруудад тулгуурласан бөгөөд Түүний яриандаа ашигладаг байсан олон үг хэллэгийг багтаасан болно. Та нэг бүрчлэн хэд хэдэн удаа уншаад, санааг нь дараалалд оруулан тодорхойлоод, эдгээр сэдвээ бүрэн дүүрэн илэрхийлж чаддаг болтлоо бүлэг дотроо өөр хоорондоо ээлжлэн, чангаар ярьж дадлага хийгээрэй. Боломж гарах Шүтлэгийн сургаалыг багшлах яриагаа улам сайжруулан хөгжүүлж, чөлөөтэй илэрхийлж сурахад энэ дасгал дадлага таныг бэлтгэх юм.

Та энэ бүлэгт Сургаалаас үргэлжлүүлэн цээжлэх нь дамжиггүй, учир нь сургаал үгс гэдэг хүмүүний зүрх сэтгэл болон хүсэл мөрөөдөлд нэвтрэх увдистай бөгөөд та харилцан яриандаа Сургаалаас эшилбэл сонсож буй хүнд гүн гүнзгий нөлөө үзүүлдэг. Харилцан яриандаа Сургаалаас эш татахад мэргэн ухаан хэрэгтэй. Юу шаардлагатай вэ гэвээс хэм хэмжээ буюу сургаалаас эш татах ба Шүтлэгийн сургаалыг өөрийн үгээр тайлбарлахын тэнцвэрийг хадгалах ёстой. Энэхүү тэнцвэрийг хадгалахын тулд Сургаал үгсийг уншиж судлахад цаг зав, эрч хүчээ харамгүй зориулж, эдгээр нь таны ухаан бодол, мэдрэмжийг төлөвшүүлэхэд нөлөөлөх боломжийг олгох хэрэгтэй.

2 ДУГААР ХЭСЭГ

Таны судлах эхний сэдэв нь Соён гэгээрүүлэгчтэй байх хүн төрөлхтний шаардлага хэрэгцээтэй холбоотой юм.

Оршихуйн тухай бодон эрдэс бодис, ургамал, амьтан болон хүний аймгийг анхааран ажваас энэ бүгдэд соён гэгээрүүлэгч хэрэгтэй гэдэг нь харагддаг.

Цэцэрлэгт хүрээлэнд цэцэрлэгч хэрэгтэй. Арвин ургац хураахын тулд тариалангийн талбай тариаланчтай байх хэрэгтэй. Хэрвээ хүнийг эзгүй хээр газар ганцааранг нь үлдээвэл зэрлэг амьтан шиг амьдрах болно. Харин эрдэм боловсрол эзэмшвэл гайхамшигтай дээдийн амжилтад хүрнэ. Соён гэгээрүүлэгч үгүй бол соёл иргэншил гэж үгүй.

Боловсрол бол материаллаг, хүмүүний болон оюун санааны гэсэн гурван янз байдаг. Материаллаг боловсрол бол бие махбодын хөгжилтэй холбоотой. Хүмүүний боловсрол бол соёл иргэншил болон хөгжил дэвшлийн тухай боловсрол юм. Энэ нь төр засаг, нийгмийн эмх журам, нийгмийн хамгаалал, худалдаа үйлдвэрлэл, урлаг соёл болон шинжлэх ухаан, агуу шинэ нээлтүүд болон бүтээн байгуулалтууд орно. Оюун санааны боловсрол нь тэнгэрлэг төгс чанарыг эзэмшихэд оршино. Энэ бол жинхэнэ боловсрол юм, учир нь үүний тусламжтайгаар хүний оюун санааны буюу эрхэм дээд мөн чанар хөгждөг.

Хөгжин дэвшихийн тулд хүн төрөлхтөнд материаллаг, хүмүүний болон оюун санааны аль аль боловсролыг олгож чадах тодорхой эрх мэдэл бүхий Соён Гэгээрүүлэгч шаардлагатай. Хэрэв ямар нэгэн хүн, “Надад төгс оюун ухаан заяасан болохоор надад ийм соён гэгээрүүлэгч хэрэггүй” гэж хэлэх юм бол, тэрээр мэдээжийн зүйлийг үгүйсгэж байгаа хэрэг болно. Энэ нь яг л хүүхэд, “Надад боловсрол хэрэггүй, би өөрийн оюун ухаан, сэтгэн бодох чадвараа ашиглан өөрөө төгс төгөлдөр байдалд хүрч чадна” гэж хэлэхтэй адил болно.

Хүн төрөлхтөнд ямагт ийм төгс соён гэгээрүүлэгч хэрэгтэй байсан бөгөөд тэр соён гэгээрүүлэгч нь хүн өөрийнхөө бие махбодыг тэжээн, эрүүл мэндтэй холбоотой асуудлаа зохицуулахад нь тусалж, эрдэм мэдлэг эзэмшин шинэ нээлт бүтээл хийхэд нь зоригжуулж, хамгийн чухал нь сүнсний жинхэнэ амьдралыг түүнд шингээж өгдөг. Эгэл жирийн хүн хэзээ ч ийм аварга зүйлүүдийг бүтээж чадахгүй. Гагцхүү Бурханы Тодруулагч нар л эдгээрийг биелүүлэх чадалтай.

1. Дээрх хэсгийг бүлэг дотроо хэд хэдэн удаа уншиж, агуулгыг нь сайн ойлгоход бие биедээ тусална уу. Та нар уг хэсгийн санаануудыг бие биеэсээ дэлгэрэнгүй асууж, өөрийн үгээр тайлбарлан ярих дадлага хийнэ үү.
2. Дараа нь, сая судалсан сэдвээ яриандаа хэрхэн шигтгэн оруулж болох талаар бүлэг дотроо хэлэлцээрэй. Найздаа боловсрол нь гурван янз байдаг хэмээн гэнэт яриад эхлэх нь утгагүй л дээ. Гэхдээ дээрх сэдвийг ярианыхаа аль хэсэгт оруулбал тохиромжтойг бодох нь зүйтэй. Энэхүү сэдвийг нийгэм дэх ёс суртахууны доройтол эсвэл дэлхий ертөнцийн сайн сайхан байдлын төлөө юу хийж болох тухай хэлэлцэх үед дурдаж болно. Найз нөхөд, гэр бүлийн гишүүд

болон танилынхаа хүрээнд олон янзын сэдвээр хэрхэн ярьдгаа эргэцүүлээрэй. Ярианы явцад тэдний анхаарлыг татахуйц сэдвийн хүрээнд дээрх санаанаас шигтгэж болохоор байна уу? _____

3. Сая судалсан сэдвээр хүмүүстэй яриа өрнүүлж байх явцад олон асуултууд урган гардаг. Хэрэв хэн нэгэн танаас “Таны яриад байгаа тэр Соён гэгээрүүлэгч нар чинь хэн юм бэ?” гэж асуувал та юу гэж хариулах вэ? _____
- _____
- _____

4. Хүн төрөлхтөнд Соён гэгээрүүлэгчийн шаардлага хэрэгцээний тухай Бахауллагийн Сургаалаас хэд хэдэн эшлэлийг толилуулав. Эдгээр эшлэлүүдийг тунгаан бодож аль нэг эшлэлийг цээжлээрэй. Боломж тохироо бүрдсэн үед өөрийн яриандаа цээжилсэн Сургаалаас эш татах боломжтой.

“Бүх хүмүүс ямагт өсөн хөгжих соёл иргэншлийг урагшлуулахын төлөө бүтээгдсэн билээ.”¹

“Цорын ганц үнэн Бурхан (Түүний алдар бадартугай) Өөрийгөө хүмүүст нээсний Зорилго нь тэдний дотоод жинхэнэ сэтгэлийнх нь уурхайд нуугдмал орших эрдэнийн чулуунуудыг ил гаргахад оршино.”²

“Бурхан Өөрийн Зөнч мэргэдийг давхар зорилготой илгээдэг билээ. Эхнийх нь, хүмүүний үрсийг мунхаг харанхуйгаас чөлөөлж, үнэн ухаарлын гэрэл гэгээ өөд хөтлөн дагуулахад оршино. Хоёр дахь зорилго нь, хүн төрөлхтний энх тунх, амгалан аж амьдралыг баталгаажуулж, ийм байдалд хүрэх арга замыг хангаж өгөхөд оршдог.”³

“Хүмүүст үеийн үед, ямар ч нөхцөлд өөрсдийг нь ухуулан сэнхрүүлэх, удирдан чиглүүлэх, зааварлан сургах нэгэн хэрэгтэй байдаг билээ.”⁴

3 ДУГААР ХЭСЭГ

Дараах цогцолбор нь Бурханыг гагцхүү Түүний Тодруулагч нараар дамжуулан таньж болно гэдэг талаар тайлбарлаж байгаа бөгөөд найз нөхөдтэйгөө энэ тухай ярилцахад тус болно.

Хязгааргүй орчлон ертөнцийг бодоод үз дээ. Энэ орчлон ямар нэгэн Бүтээгчгүйгээр бүтээгдсэн байх боломжтой юу? Эсвэл Бүтээгчийнхээ мөн чанарыг бүтээсэн зүйл нь танин мэдэх боломжтой юу? Хэрвээ бид бүхий л бүтээлийг ажиглавал доод түвшнийх нь дээд түвшнийхээ хүч чадлыг таньж мэдэх боломжгүй гэдгийг ойлгоно. Тиймээс хад чулуу юм уу мод яаж ч хөгжлөө гээд харах болон сонсох чадварыг хэзээ ч төсөөлж чадахгүй. Амьтад хэзээ ч хүний мөн чанарыг таньж чадахгүй бөгөөд, хүний оюун санааны хүчийг ухамсарлаж чадахгүй. Тийм бүтээл өөрийнхөө Бүтээгчийн мөн чанарыг яаж таньж ойлгох билээ?

Бид Бурханыг хэзээ ч мэдэж ойлгохгүй ч Түүнийг танин мэдэх гэсэн оролдлогоо бид орхиогүй. Үеэс үед онцгой Оршихуй болох Бурханы Тодруулагч дэлхий дээр залран ирдэг. Төгс төгөлдөр, буян хишиг, сүр жавхлан зэрэг бүхий л шинжүүд Бурханд хамаардаг бөгөөд эдгээр шинж чанарууд гагцхүү Ариун Тодруулагч нарт илрэн үзэгдэх агаад яг л өнгөлж зүлгэсэн толинд туссан нарны тусгалтай адил юм. Толинд нар тусна гэдэг нь нар доошлоод толин дотор оршино гэсэн үг биш юм. Үүний нэгэн адил, Бурхан ариун диваажингаас оршихуйн энэ ертөнцөд ирдэггүй билээ. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл: Бурханы алдар нэр, шинж чанар, төгс төгөлдрийн тухай хүн төрөлхтний олж мэдсэн, сурч ойлгосон бүхэн Түүний Ариун Элч нарт тодрон үзэгддэг.

Сэдвээ бүлэг дотроо хэд хэдэн удаа уншсаны дараа агуулгатай холбоотой асуултыг харилцан бие биеэсээ асуун хариулж, чөлөөтэй ярих дасгал хийгээрэй.

1. Сая мэдэж авсан ойлголтоо харилцан яриандаа хэрхэн энгийн байдлаар танилцуулж болох талаар бүлэг дотроо ярилцаарай. Жишээлбэл, Бурхан оршдог тухай эсвэл амьдралын зорилго зэрэг хэлэлцүүлгийн үеэр та амархан танилцуулах боломжтой. Гэр бүл, найз нөхөдтэйгөө ярилцах үеэр өөр ямар сэдэв болон асуултууд эдгээр санааг хуваалцах боломжийг олгох вэ?

-
2. Сая судалсан сэдвийн санааг танилцуулах боломж таны найзууд дунд олдлоо гэж бодъё. Тэдний нэг нь танаас “Бурханы тухай Түүний Тодруулагч нараар дамжуулан олж мэддэг зүйлс юу юм бэ?” гэж асуувал та юу гэж хариулах вэ?

-
-
-
3. Дээрх сэдэвтэй холбоотой Бахауллагийн Сургаалаас нэг эсвэл хэд хэдийг цээжилж болох юм. Ингэснээр та уг сэдвээр найзуудтайгаа ярилцах явцдаа эш татах боломжтой болно.

“Үнэний Нарнаас урган гарсан эдгээр гэрэлт Оршихуйг таньж мэдэн, тэдэнд хүрэхээс өөр замаар бүхний Үүсэл болох Түүнийг таньж мэдэх, Түүнд хүрэх арга үгүй.”⁵

“Бурханы Тодруулагч Хүмүүн хэзээд Бурханы төлөөлөгч ба хүслийг нь дамжуулагч байдаг билээ. Тэрээр үнэнхүү Бурханы нэн төгс Цол өргөмжлөлийн Үүрийн Туяа, Түүний өргөмжит Шинж чанаруудын Үүрийн цолмон билээ.”⁶

“Түүнчлэн Бурханы эдгээр Тодруулагч нарын алиных нь ч үр бүтээл, үйлдэл бүр, үгүй ээ, тэдэнд хамаарах бүхэн, ирээдүйд тэдний илэрхийлэх бүхэн нь Бурханаас гаралтай, Бурханы Хүсэл таалал болон Зорилгын тусгал юм гэдэгт итгэл дүүрэн байгтун.”⁷

4 ДҮГЭЭР ХЭСЭГ

Шашны нэг нэгдмэл байдал нь олон нийтийн сонирхдог сэдэв бөгөөд доорх санаанууд танд олон тохиолдолд хэрэг болох болно:

Бид ямар дэнлүүнээс гэрэлтэж буйгаас үл хамааран гэрэл гэгээг хайрлах ёстой. Ямар цэцэрлэгт ургаж байгаагаас үл хамааран бид сарнай цэцгийг хайрлах хэрэгтэй. Бид үнэнийг, эх сурвалж нь ямар байхаас үл харгалзан эрэлхийлж байх учиртай. Бид ямар эх үүсвэрээс гаралтайг нь үл хамааран үнэнийг эрэлхийлэх ёстой. Нэг дэнлүүнд л уягдах нь өөр дэнлүүнээс цацрах гэрэл гэгээг үнэлэхэд бидэнд саад болно. Үнэнийг эрэлхийлэхийн тулд бид өөрсдийн буруу таамаг үзэл болон атгаг сэжиг үзлээс чөлөөлөгдөх хэрэгтэй. Хэрэв бидний аяга

өөрийгөө гэсэн үзлээр дүүрэх аваас түүнд амьдралын рашаан ус хийх зай байхгүй болно.

Шашин бол дэлхий ертөнцийн гэрэл. Энэ бидний замыг чиглүүлж, мөнхийн аз жаргалын үүдийг бидэнд нээж өгдөг. Бид бүхий л агуу шашнуудын сургаалыг догма номлол, сохроор даган дуурайх явдлаас ангижран, юунд ч баригдалгүй шинжлэн судалбал бүгд нэгэн эх үүсвэртэй гэдэг үнэнийг олж мэдэх нь дамжиггүй. Тэд бүгд л Бурханы мэдлэгээс үүсэлтэй. Тэд хүмүүний ертөнцийг хөгжүүлэхийг тэмүүлсэн байдаг билээ.

Мэдээж эдгээр шашнууд нийгмийн хуулиуд болон сургаалууд нь тухайн шашны он тоолол болон газар нутгийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байсан нь ойлгомжтой. Хэдий тийм боловч мөн чанартаа бүх шашин бол нэг юм. Тэд бүгд сүсэг бишрэл, мэдлэг, итгэл, шударга ёс, сүсэг бишрэл, дээд зорилго, найдвартай зан, Бурханыг хайрлах хайр болон энэрэнгүй сэтгэлийг хөгжүүлдэг. Мөн түүнчлэн цэвэр ариун байдал, ангижрал, даруу төлөв зан, хүлцэнгүй, тэсвэр тэвчээр, тууштай байдлыг зааж сургадаг. Эдгээр хүмүүний зан чанарууд ойлголт Эрин бүхэнд шинэчлэгдсээр ирсэн.

Атгаг үзэл болон сохроор даган дуурайх явдал нь шашны нэг нэгдмэл байдлыг олж харахад саад болж байгаа нь үнэхээр харамсалтай. Бурханы хүн төрөлхтөнд хайрласан удирдамж бол үнэн бөгөөд үнэнд хуваагдал гэж үгүй учир нь үнэн бол нэг юм. Бид өөрсдийн буруу таамаг үзлээс ангижран үнэнийг бие даан эрэлхийлэх аваас бидний эрлийн эцэст эв нэгдэл байх болно. Шашин биднийг нэгтгэж, хүмүүсийн дунд хайр нөхөрлөлийн холбоог тогтоодог. Хэрэв шашин нь дайсагнал, тэмцлийн шалтгаан болох аваас ийм шашин байгаагүй нь дээр.

1. Энэхүү сэдвийг бүлэг дотроо хэд хэдэн удаа уншиж, түүнд гарч буй санаатай холбоотой асуултуудыг бие биеэсээ асуун өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх дасгалыг өмнөх хэсгийн адил хийгээрэй.
2. Судалсан сэдвийн агуулгыг ялангуяа хүмүүсийн байнгын ярианы сэдэв болсон шашны сөргөлдөөний тухай харилцан ярианд хэрхэн уялдуулан танилцуулж болох талаар бүлэг дотроо хэлэлцэнэ үү. Эсвэл хэдэн найз нөхөдтэйгөө суртал ухуулгад авталгүй үнэнийг бие даан эрэлхийлэх тухай ярьж байх явцад танилцуулж болох юм. Та найз нөхөд, хөршүүд, хамт ажиллагсад болон танилуудтайгаа саяхан өрнүүлсэн харилцан яриагаа эргэн бодно уу. Эдгээр санааг ярилцаж болох илүү үр өгөөжтэй өөр ямар асуудлууд байж болох вэ? ____

3. Дээрх сэдвийг харилцан яриандаа хуваалцсаны дараа хэн нэгэн танаас “Бүх шашинд нийтлэг ямар үнэн байдаг вэ?” гэвэл юу гэж хариулах вэ?

4. Бахауллагийн Сургаалаас эш татсан эдгээр үгнүүдээс нэг юм уу хоёрыг цээжлэхийг танд санал болгож байна:

“Ямар ч үндэстэн ястан байсан, ямар ч шашин шүтлэг байсан, бүгд нэг л тэнгэрийн Эх үүсвэрээс онгод шавхан, нэг л Бурханы дор оршиж байгаа гэдэгт эргэлзэх зүйлгүй.”⁸

“Бүхий л шашны сүсэгтэн нартай найрамдал, нөхөрлөлийн сэтгэлээр харьц.”⁹

“Бурханы Шүтлэг ба Түүний Шашныг амьдруулсан үндсэн зорилго нь болбоос хүмүүн төрөлхтний ашиг сонирхлыг сахин хамгаалж, эв нэгдлийг нь хөхиүлэн дэмжихэд... оршино”.¹⁰

“Бурханы шашин бол хайр ба эв нэгдлийн төлөө байдаг тул түүнийг дайсагнал, тэмцэл зөрчлийн шалтгаан бүү болгогтун.”¹¹

5 ДУГААР ХЭСЭГ

Таны судлах дараагийн сэдэв бол шинжлэх ухаан ба шашин хоорондын уялдаа холбоо юм.

Шашин нь шинжлэх ухаантай нийцэх ёстой. Бурханаас бидэнд өгсөн бэлэг бол үнэн гэж юу болохыг ухаарахад туслах учир шалтгааныг заяасан явдал юм. Шинжлэх ухаан, шашин хоёулаа учир шалтгааны хэм хэмжээтэй нийцэх ёстой. Тиймээс энэ хоёр бие биетэйгээ зохицон уялдах учиртай. Эдгээр нь хүмүүний оюун ухааныг асар өндөрт дүүлэхэд туслах хос жигүүр агаад чухам энэ жигүүрийн ачаар хүн төрөлхтөн дүүлэн нисэж чадна. Ганц жигүүр хангалтгүй шүү дээ.

Шинжлэх ухаан бол Бурханаас өгсөн буян хишиг билээ. Энэ нь бодит ертөнцийн хуулиудыг нээж, байгалиас бидэнд тулгарах хязгаарлалтуудыг даван туулах боломжийг бидэнд өгдөг. Шинжлэх ухааны төхөөрөмжийн тусламжтайгаар энгийн нүдэнд харагдах боломжгүй зүйлсийг бид харж, агшин зуур асар хол газартай холбогдон харилцан ярих боломжтой болсон. Шинжлэх ухаан нь одоог өнгөрсөнтэй холбож, ирээдүйд учрах зүйлийг тайлахад тусалдаг. Аливаа ард түмний хөгжил дэвшил нь шинжлэх ухааны ололт амжилтаас шууд хамаардаг.

Бурханы шашин шүтлэг бол үнэнийг хөхүүлэн дэмжигч, мэдлэгийг тэтгэгч, хүн төрөлхтнийг гэгээрүүлэгч юм. Шашин үгүй бол шинжлэх ухаан нь материализмыг хөгжүүлэх хэрэгсэл болж эцэст нь сүйрэлд хүрдэг. Харин шашин нь шинжлэх ухааныг үгүйсгэх аваас мухар сүсэг төдий болон хувирдаг. Шашин, шинжлэх ухаан хоёр уялдан нийцэж чадваас хүн төрөлхтөнд учраад буй заналхийлэл, гай зовлон, өвчин зэрэг нь төгсгөлд хүрнэ.

1. Өмнөхийн адил сэдвийг догол мөр бүрээр нь хэд хэдэн удаа бүлэг дотроо уншиж, агуулгыг өөрийн үгээр чөлөөтэй илэрхийлдэг болтлоо нэг нэгэндээ асуулт асуун ярилцаарай.
2. Хэн нэгэн танаас дараах зүйлсийг асуувал хэрхэн хариулах вэ: “Шашин бол өнгөрсөн цагийн зүйл; шинжлэх ухаан ганцхан хүн төрөлхтний өмнө тулгараад буй олон асуудлыг шийдвэрлэнэ”. Энэ асуулт шашин бол мухар сүсэг төдий зүйл биш, гэхдээ шинжлэх ухаантай нийцээгүй тохиолдолд мухар сүсэг болдог бол харин шинжлэх ухаан шашин үгүй бол материализмын хэрэгсэл болон сүйрэлд хүргэдэг гэсэн ойлголтыг тодорхой болгоход тустай байх болов уу? Энэ бүхний талаар ямар жишээ татан ярьж болох вэ?

3. Бахауллагийн Сургаалаас авсан дараах эшлэлүүдээс нэг эсвэл хэд хэдийг цээжлэхийг санал болгож байна:

“Хүчирхэг Бурханаас хүмүүнд заяасан эдгээр хишиг ивээлийн дотроос нэн тэргүүний зүйл гэвэл ухаарлын хишиг болой... Энэхүү хишиг нь хүнд аливаа юмс үзэгдлийн үнэн байдлыг тунгаан ойлгож, үнэн зөв зүйлд тэмүүлж, хорвоо орчлонгийн нууцыг тайлах хүчийг олгож байгаа билээ.”¹²

“Хорвоог тольдон харж, хэсэгтээ тунгаан бод. Тэрээр нүдний чинь өмнө номоо дэлгэн, дотор нь Бүхнийг Мэдэгч, Бүтээгч Эзний чинь Үзгээрээ сийлсэн бүхнийг нээж өгдөг бөлгөө.”¹³

“Мэдлэг оюун бол хүмүүний амьдралынх нь жигүүр, өгсөх шат нь билээ. Түүнийг олж авах нь хүн бүрийн үүрэг бөлгөө.”¹⁴

6 ДУГААР ХЭСЭГ

Хүн төрөлхтний эв нэгдэл бол өнөө цагт аль ч газрын хүмүүсийн сэтгэлийг хөнддөг тул олон хүн энэхүү сэдвээр тантай ярилцахдаа таатай байх болно.

Мэлмийг баясгах сайхан цэцэрлэгт өнгө өнгийн цэцэгс алаглан найгаж олон янзын үнэр ханхлуулна. Цэцэгс нь хэдийгээр хоорондоо ялгаатай боловч цэцэг бүр нэг л хураар ундаалагдаж, нэг л нарны илчийг авдаг. Энэ нь хүн төрөлхтний хувьд ч адил юм. Хүн төрөлтөн бол олон янзын үндэстэн ястан, олон өнгөөс бүтдэг билээ. Гэвч бүгд нэг л Бурханаас гаралтай, бүгд нэг л эх үүсэлтэй. Хүмүүний гэр бүлийн ялгаа нь эвтэй найртай байхын эх үүсвэр бөгөөд яг л хөгжимд олон янзын нот хамтдаа нийлж төгс сайхан эгшиг үүсэгдэг шиг.

Оршин амьдрахын тулд эв нэгдэл хэрэгтэй. Хайр бол амьдралын гол эх үүсвэр билээ. Материаллаг ертөнцөд элемент хэсгүүд нь хоорондоо таталцах хүчээр нэгдэн нягтарсан байдаг. Таталцлын хууль нь үзэсгэлэнт сайхан цэцгийг бүрдүүлсэн элементүүдийг хооронд нь нэгтгэдэг. Гэвч таталцлын хүч үгүй болбол цэцэг задарч, оршин тогтнохоо болино. Хүн төрөлхтөн ч гэсэн адил. Таталцал, эв найртай байж, эв нэгдлийг эрхэмлэх нь хүн төрөлхтнийг хооронд нь нэгтгэж байдаг хүчнүүд юм.

Бахаулла дэлхийн бүх ард түмнийг нэгтгэх загварыг зохион бүтээсэн билээ. Бид ард түмнүүдийг эв нэгдлийн энэ хүрээнд багтаахын төлөө хүчин чармайх хэрэгтэй. Бид өөр гарал үүсэл, үндэстэн ястан, шашин шүтлэг, үзэл бодолтой хүмүүстэй учрахад эдгээр ялгааг өөр хоорондоо саад тотгор болгох ёсгүй юм. Бид тэднийг хүн төрөлхтний үзэсгэлэнт цэцэрлэг дотор ургаж байгаа өөр өнгийн сарнай цэцэгс хэмээн үзэж, тэдний дунд нь байгаадаа баярлах ёстой юм.

1. Өмнөх хэсгүүдийг судалсны адил өөрийн эргэн тойрныхонтойгоо хэрхэн харилцан яриа өрнүүлж болох талаар ярилцана уу. Хүмүүст түгээмэл байдаг ямар бодол санаануудад тулгуурлан дээрх санааг хуваалцах боломжтой вэ?

-
-
-
2. Хүн төрөлхтний нэг нэгдмэл байдлын тухай харилцан яриа нь танай нийгэмлэгийн эв нэгдэлд чухал хэмээх ойлголтын тухай хэлэлцүүлэг өрнүүлж болох юм. Үүнд хүн бүр хэрхэн хувь нэмрээ оруулж болох талаар та хэдэн үг хэлнэ үү? _____
-

3. Та өөрийн найз нөхөдтэйгөө энэхүү сэдвээр ярилцаж байхдаа хуваалцаж болох эшлэлүүдийг доор толилуулсан тул түүнээс нэг эсвэл хэд хэдийг цээжлэхийг хичээгээрэй:

“Эв нэгдлийн асар бослоо. Бие биеэ үл таних хүмүүс мэтээр бүү үзэгтүн. Та нар бол нэг л модны үр жимснүүд, нэг л мөчрийн навчис болой.”¹⁵

“Эв нэгдлийн гэрэл бүх л дэлхийг гэрэлтүүлэх чадалтай билээ.”¹⁶

“Нүүр царайгаа эв нэгдлийн зүг чиглүүлж, түүний гэрэл гэгээг өөртөө тусгагтун. Эвлэлдэн нэгдэж, Бурханы төлөө та нарын дунд тэмцэл зөрчлийг үүсгэсэн тэр зүйлийг үндсээр нь хуу татан хаяцгаа.”¹⁷

“Эв нөхөрлөл, сайны ерөөл ба эв нэгдлийг хөхүүлэн дэмжих тийм зүйлийг уйгагүй дагах нь хүмүүнд зохилтой.”¹⁸

7 ДУГААР ХЭСЭГ

Шударга ёс бол ихэнх хүмүүсийн анхаарлыг ихэд татах бас нэгэн асуудал тул энэ талаарх хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулахад танд туслах болно.

Хүмүүсийн чадавх хоорондоо харилцан адилгүй байдаг нь хүмүүний оршин тогтнохын нэгэн үндэс юм. Тиймээс бүх хүмүүс тэнцүү байх боломжгүй билээ. Гэвч хүний ажил хэрэг бүхэлдээ шударга ёсны зарчмаар зохицуулагдах ёстой. Шударга ёс нь ариун бөгөөд хүн нэг бүрийн эрхийг сахин хамгаалах ёстой. .

Шударга ёс бол хязгааргүй даян дэлхийн чанар юм. Энэ нь хүмүүний амьдралын бүх төвшинд үйлчлэх ёстой. Нийгмийн гишүүн нэг бүр соёл иргэншлийн ач тусыг хүртэх ёстой, яагаад гэвэл хүн бүр хүн төрөлхтний бие цогцсын нэгэн эрхтэн юм. Энэ бие цогцсын нэг эрхтэн өвдөж, зовсон бол бусад бүх эрхтэн нь

бас зовно. Энэ биеийн нэг гишүүн зовж шаналж байхад бусад бүх гишүүд нь амар тайван байх боломжтой гэж үү? Өнөөдөр нийгэмд харилцан уялдаа, тэгш хэм дутагдаж байгаа учир эмх замбараа алга байна. Хүн төрөлхтний гэр бүлийн бүхий л гишүүд сайн сайхан амьдарч, аз жаргалтай байх тэр нөхцлийг хангах хууль зарчим шаардлагатай.

Шударга ёс, шагнал шийтгэл гэсэн хоёр багана дээр тулдаг юм. Итгэл бишрэлгүй, Бурханы гэсгээн цээрлүүлэлтээс эмээдэггүй төр засаг шударга бус хууль хэрэгжүүлдэг. Дарангуйллаас сэргийлье гэвэл шагнал хүртэхийг тэмүүлэх, шийтгүүлэхээс эмээх хоёр байх шаардлагатай. Хууль тогтоогч, хуулийг хэрэгжүүлэгчид өөрсдийн шийдвэрийн оюун санааны үр дагаврын талаар бодолцож байх хэрэгтэй. Албан тушаалтан хүн өөрийнхөө үйлдлийн төлөө дараачийн амьдралд ч хариуцлага хүлээх, гаргасан аливаа шийдвэр нь Тэнгэрлэг Шударга Ёсны жинлүүрээр шүүгдэх болно гэдгийг мэдсэн бол дарангуйлан захирахаас зайлсхийх нь дамжиггүй.

1. Дээрх санаануудыг чөлөөтэй илэрхийлж сурсныхаа дараа, дээрх санааг нь ямар сэдвээр ярилцах үед хуваалцвал үр дүнтэй байх талаар ярилцаарай.

2. Шударга бус байдал хэзээ ч арилахгүй гэдэгт итгэдэг хүнд та юу гэж хэлэх вэ?

3. Дараах сургаалууд нь Бахауллагийн Сургаалаас авсан шударга ёсны тухай бөгөөд та түүнээс урам аван цээжлэхийг хүсэх нь дамжиггүй.

“Шударга ёс бол хүмүүсийн гэрэл гэгээ, Түүнийг дарангуйлал мөлжлөгийн сөрөг салхиар бүү унтраагтун. Шударга ёсны зорилго болбоос хүмүүсийн дунд эв нэгдэл бий болоход оршино.”¹⁹

“Шударга ёсны гэрэлтэй ямар ч гэрлийг зүйрлүүлэхийн аргагүй. Дэлхий ертөнцийн зохион байгуулалт хийгээд хүн төрөлхтний амгалан тайван байдал түүнээс шалтгаална.”²⁰

“Ертөнцийг хүмүүжүүлэгч тэр зүйл нь Шударга ёс юм, учир нь Шударга ёс нь шагнал, шийтгэл гэсэн хоёр баганыг тулдаг болой. Энэ хоёр багана бол дэлхий ертөнцийн амьдралын эх үүсвэр болой.”²¹

8 ДУГААР ХЭСЭГ

Баян хоосны ялгаа өдөр ирэх тусам улам нэмэгдэж байгаа бөгөөд доорх өгүүлэмж танд, нөхөдтэйгөө энэ болон холбогдох сэдвээр ярилцахад хэрэг болно.

Өнөөгийн нийгэмд харилцан ойлголцол, найрсаг харилцаа дутагдаж байгаагийн улмаас нийгмийн нэг хэсэг нь ая тухтай, тансаг амьдран ихэд сэтгэл хангалуун явж байхад нөгөө хэсэг нь идэх хоол, орох оронгүй зутарч байна. Зарим нь хэмжээлшгүй баян байхад зарим нь туйлын ядуу амьдарч байна.

Нийгмийн хууль тогтоомжийг цөөн хэдэн хүн асар ихээр хөрөнгөжиж, бусад нь хоосон хоцрохгүй байхаар бодолцон боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Энэ нь бүгд тэгш байх ёстой гэсэн үг биш, учир нь хүмүүсийн төрөлхийн чадамж харилцан адилгүй. Гэсэн ч жигшин зэвүүцэм хэт чинээлэг байдалтай зэрэгцэн орших сэтгэл гонсойм ядуу зүдүүг арилгах боломжтой. Капиталист хүн хөрөнгөтэй байх нь зүйн хэрэг юм бол ажилчин хүн амьдралаа авч явахад хангалттай хөрөнгөтэй байх нь бас зүйн хэрэг. Бид туйлын ядуурлыг олж харсан л бол хаа нэгтээ дарангуйллыг ч олж харах болно.

Асуудлын гол нь Тэнгэрлэг шударга ёс хүмүүний амьдралын бүхий л үед илрэх ёстойд байгаа юм. Эдийн засгийн нөхцөл байдал нь үндэс сууриндаа тэнгэрлэг шинж чанартай бөгөөд зүрх сэтгэл болон оюун санааны ертөнцтэй холбоотой байдаг. Чинээлэг хүмүүс баялгаасаа хуваалцдаг байх ёстой; тэд зүрх сэтгээлээ зөөллөж, оюун бодлоо энэрэнгүй болгон төлөвшүүлэх хэрэгтэй. Чинээлэг хүмүүсийг эдийн засгийг тэгшитгэн зохицуулах алхмуудыг дуртайяа хийдэг болтол нь хайр сэтгэл давамгайлж, хүмүүс зүрх сэтгэлээрээ нягт холбогдох хэрэгтэй. Нийгэмд туйлын ядуурал байхад асар их хөрөнгөтэй байгаагаа шударга бус бөгөөд хууль бус гэдгийг тэд ухаарах учиртай. Ингэсэн цагт л тэд ая тухтай амьдрахад нь хангалттай хөрөнгө авч үлдэн бусад баялгаа сайн дураараа хуваалцах юм.

1. Мэдэгдлийг бүлгээрээ уншиж судлаарай. Ихэнх хүн ажил хөдөлмөр, цалин хөлс, орон байр гэх мэт эд баялаг, ядууралтай холбоотой олон асуудал толгойдоо тээж явдаг. Энэ сэдэвт гарсан санаанууд чухам ямар ямар сэдвээр ярилцах үед өгөөжтэй байх бол?

2. Дээрх санаануудаас хуваалцахыг чинь сонсоод хэн нэгэн хүн “Та хөрөнгөтэй хүмүүс татварын тухай хуулийг ойлгож дэмжин, төлөх ёстойгоо сайн дураараа төлнө гэх гээд байна уу? Та яагаад тэгж бодож байна вэ?” гэвэл та юу гэж хариулах вэ?

3. Бахауллагийн Сургаалаас авсан эшлэлүүдээс нэгийг эсвэл хэд хэдийг цээжлэхийг танд зөвлөе:

“... өөрсдөдөө болон бусдад ашиг шим хайрлах сайн сайхан, гайхамшигт үр жимсээ өгөх ёстой. Аяа, ухаарлыг ологч хүмүүс ээ! Хүн бүхэн ямарваа нэгэн ур ухаан, ажил мэргэжил эзэмших үүрэгтэй, чухам үүнд л баян байхын нууц оршино.”²²

“Харц чинь нигүүлсэл рүү чиглэх аваас өөрт ашигтай бүхнийг орхиж, нийт хүн төрөлхтөнд тустай зүйлээс барьж ав. Харц чинь шударга ёс руу чиглэх аваас өөртөө зориулж сонгосон тэр зүйлийг өрөөл бусдад зориулж сонгохтун.”²³

“Өрөөл бусдыг өөрөөсөө илүүд үздэг хүн адислагдсан болой.”²⁴

“Ямар ч сайн үйл ул мөргүй арилж байгаагүй бөгөөд арилах ч үгүй. Учир нь сайн үйлс бол аливаа үйлдэл хийдэг хүмүүсийн тусын тулд Бурханд хадгалаатай байгаа эрдэнэс болой.”²⁵

“... хэмжээ хязгаараас хэтэрч, үрэлгэн хүмүүсийн тоонд орохгүй байхад анхаар.”²⁶

9 ДҮГЭЭР ХЭСЭГ

Ялгаварлан гадуурхах үзлийн тухай хэлэлцүүлэгд оролцоход тань нэмэр болох зарим нэгэн санааг доор толилуулав.

Шашин шүтлэг, арьс өнгө, хүйс, үндэс угсаа, эдийн засгийн хувьд ялгаварлан гадуурхах үзэл нь хүн төрөлхтний бүтцийг үгүй хийдэг бөгөөд Бурханы зарлигт харш билээ. Мянга мянган жилийн турш хүн төрөлхтөн аль нэг хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй дайн дажин, цус асгаруулалтын улмаас зовж шаналсаар ирсэн. Ялгаварлан гадуурхах үзэл байгаа цагт хүн төрөлхтөн хэзээ ч амар заяа үзэхгүй.

Бурхан энэрэл хайр, эв нэгдлийг бий болгох зорилгоор л Өөрийн Элч нарыг илгээдэг билээ. Тэнгэрийн бүхий л ном судар бол хайрын бичээс юм. Тэдгээр нь салж хагацах шалтгаан болоод байгаа л бол үр шимээ өгөхөө байсан гэсэн үг. Тиймээс, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах нь нэн ялангуяа Бурханы хүсэл зарлигт харш юм.

Улс үндсээр нь ялгаварлан гадуурхах явдлыг яагаад ч зөвтгөх аргагүй. Учир нь дэлхий бол нэг л газар, нэг л улс орон. Улс орнуудыг заагладаг хил хязгаар бол хийсвэр; тэдгээрийг Бурхан тогтоогоогүй. Хүмүүс мөрөн голыг хоёр улсыг зааглах хилийн зурвас болгож, тус тусынхаа талд нэр оноож өгдөг. Гэтэл тэр мөрөн гол нь аль алинд нь заяагдсан байгалийн судал. Хүмүүсийг байгалийн баялгаас болж дайтахад хүргэдэг зүйл бол хоосон төсөөлөл, мунхаглал биш гэж үү?

Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах нь мухар сүсгээс өөр юу ч биш. Хүний арьсны өнгө бол тухайн хүний өвөг дээдсийн байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицсоны үр дүн төдий. Зан чанар л хүн төрөлхтний жинхэнэ шалгуур. Төгс байдал арьсны өнгөнөөс огт хамаарахгүй. Бурханы өмнө хүлээн зөвшөөрөгдөх зүйлс бол итгэл үнэмшил, сэтгэлийн цэвэр ариун байдал, сайн үйлс бөгөөд магтууштай сайхан үг яриа билээ.

Эмэгтэй хүмүүс урт удаан хугацааны турш эрэгтэй хүмүүсийн үгээр явсаар ирсэн. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ялгаа бодит ертөнцөд л хамаатай болохоос биш Оюун санааны ертөнцөд тэд тэгш эрхтэй. Бурхны нүдэнд эрэгтэй, эмэгтэй гэх ялгаа үгүй. Тэрээр бүх хүнд оюун ухаан, мэдрэхүй заяасан. Нандин сайхан зан чанаруудыг хөгжүүлэх чадвар бүх хүнд бий. Аливаа хүнийг хүйсээр нь ялгаварлан гадуурхах үндэслэл өнөө цагт байхгүй.

Хуучин Гэрээнд өгүүлснээр Бурхан “Хүнийг Өөрийнхөө дүр төрхөөр бүтээцгээе” хэмээн айлдсан байдаг. Энэ нь эмэгтэй хүмүүст ч мөн адил хамаарах нь тодорхой. Хүн Бурханы дүрээр бүтээгдсэн; өөрөөр хэлбэл бурханлаг зан чанарууд хүний мөн чанарт тусгалаа олж, илрэн харагддаг. Энэ нь нийт хүн төрөлхтөнд хамаарна. Зөвхөн нэг өнгө, үндэс угсаа эсвэл улс орны хүмүүс л Бурханы төрхөөр бүтээгдсэн гэх нь ямар байж боломгүй хэрэг вэ? Чинээлэг

хүмүүс л Түүний дүрээр бүтээгдсэн эсвэл нийгэмд өндөр байр суурь эзлэх явдлыг Бурханд ойртох шалгуур гэж үзэх нь ямар утгагүй хэрэг вэ? Хүн төрөлхтөн ялгаварлан гадуурхах үзлээ таягдан хаяж Хаант улсад байдаг ёс суртахууныг олж авахаас нааш гэгээрэлд хүрч үл чадна.

1. Энэ мэдэгдлийг уншиж судалсныхаа дараа найз нөхөд, хөршүүдийн чинь хөндөж ярьсан асуудлыг гадуурхах үзлийг халах замаар шийдвэрлэж болохыг бодож үзээрэй.

2. Дээрх санаануудаас хуваалцахыг чинь сонсоод хэн нэгэн хүн “Бид ялгаварлан гадуурхах үзэлтэй гэдгээ мэдэхгүй явж байж болох уу?” гэж асуувал та юу гэж хариулах вэ?

3. Энэ сэдвийн талаар ярилцаж байх үед Бахауллагийн Сургаалаас авсан дараах эшлэлүүдийг хуваалцах боломж танд олдож магадгүй:

“Дэлхий бол чухамхүү нэг улс орон, хүн төрөлхтөн бол түүний иргэд.”²⁷

“Хорвоо дээрх бүх зулзаган мод нэг л Модноос, бүх дусал нэг л Далайгаас гаралтай бөгөөд амьд бүхэн нэг л Бурханы ачаар оршин тогтдог билээ.”²⁸

“Өнөөдөр өөрийгөө бүхий л хүмүүн төрөлхтний тусын тулд зориулсан тэр хүнийг ёстой хүн гэж хэлж болно.”²⁹

“Сайн сайхан зан чанарын гэрэл нь нарны гэрэл болон түүний цацрах туянаас ч илүү.”³⁰

“Хүний ялгаа нь гоёл зүүсгэл эсвэл эд баялагт бус, харин журамт үйл хийгээд үнэн зөв ойлголтод оршдог билээ.”³¹

“Ямар ч нөхцөлд мухар сүсгийн шүтээнүүдийг бут нэргэж, хүмүүсийн хий хоосон төсөөллийн хөшгийг тас татахад чинь Бурхан нигүүлсэнгүй тусламж үзүүлэх болтугай.”³²

“Хүмүүсийн дотроос хамгийн их төөрч будилсан хүмүүс гэвэл ямагт дэмий хоосон маргаанд оролцож, ахан дүүсийнхээ дээр гарах гэж эрмэлздэг хүмүүс болой.”³³

10 ДУГААР ХЭСЭГ

Нөхөдтэйгөө ярилцаж байхдаа та эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш байдлын тухай дараах өгүүлэмжид гарсан санааг ашиглах боломжтой:

Бодит нар гэрэл гэгээ, халуун илчээрээ хорвоо дэлхий дээрх бүхий л зүйлийн мөн чанарыг дэлгэн харуулдаг. Модонд далд буй үр жимс модны мөчир дээр нарны дулаан илчний ачаар боловсордог. Үүний нэгэн адил Үнэний наран оюун санааны тэнгэр огторгуйд хамаг хурцаараа гэрэлтэхдээ урьд хожид үзэгдэж байгаагүй мөн чанарыг ил гаргаж ирдэг. Тийм ч учраас энэ эрин үед эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байх зарчим хүлээн зөвшөөрөгдөж эдүүгээ бодит үнэн болоод байна.

Бурханы мэлмийд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд ямар ч ялгаа үгүй хэмээн Бахаулла тун тодорхой айлдсан билээ. Олон зууны турш үргэлжилсэн тэгш бус байдал эрэгтэй хүмүүсийн давуу байдлын үр дүн биш, харин эмэгтэйчүүдэд бүхий л нөөц чадавхаа хөгжүүлэх тэгш боломж олгоогүйгээс болсон хэрэг. Хэдий гадуурхагдаж байсан ч гялалзсан амжилтад хүрсэн олон олон эмэгтэйчүүдийн амьдрал түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн нь бий.

Тэдгээр эмэгтэйчүүдийн нэг бол Персийн яруу найрагч Тахира юм. 1800-аад оны эхээр, эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээ бүрэн захирагддаг байсан улсад төрсөн тэрээр Бурханы шинэ Үүдэл нээлтийг хүлээн зөвшөөрсөн анхны эмэгтэй юм. Шинэ Өдрийн үүр гэгээрэхийг үзээд тэрээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх цаг иржээ гэдэгт баттай итгэсэн бөгөөд энэ үнэнийг тунхаглахад хамаг хүчээ зориулжээ. Түүний мэдлэг оюун, уран яруу илтгэх чадвар нь тэр үеийн эрдэм номд төгс нэвтэрсэн хүмүүсийг алмайруулан гайхшируулдаг байв. Харгис хаан, мунхаг бардам санваартнууд бүгд өөрийнх нь эсрэг байсан ч тэрээр үнэнийг хэлж ярихаасаа огт эмээдэггүй байж. Эцэст нь тэрээр баттай хүлээн авсан Үйл хэргийнхээ төлөө алтан амиа өгсөн юм.

Бурханы хүсээгүй зүйлд итгэх нь мунхаглал бөгөөд мухар сүсэг юм. Өнөө цагт эмэгтэйчүүд сурч боловсрон, хүний үйл ажиллагааны бүх салбарт эрэгтэйчүүдтэй ижил байр суурь эзлэх бүхий л боломжийг эдэлдэг байх ёстой. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрх тэгш байдал нь энэ болон оюун санааны

ертөнцөд бодит байдал болохоос нааш хүн төрөлхтөн жинхэнэ утгаараа хөгжин дэвшиж чадахгүй.

1. Энэ мэдэгдлийг бүлгээрээ уншиж судлан доторх санаануудыг илэрхийлж сурах дасгал хийгээрэй. Та эдгээр санаанаас хуваалцах нь үр өгөөжтэй байж болохуйц яриа нөхөдтэйгөө ойрд хийсэн үү? Ямар асуудлаар ярилцсан бэ?

2. Эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй ижил байр суурь эзлээсэй гэвэл өнөөгийн нийгэмд газар аваад буй ямар үзэл бодол, хандлагыг өөрчлөх хэрэг гарах бол?

3. Бахауллагийн Сургаалаас авсан хэдэн эшлэл дор толилуулсныг та цээжилж болох юм.

“Бурханы нүдэнд эмэгтэй, эрэгтэй хүмүүс ямагт эрх тэгш байсаар ирсэн бөгөөд цаашид ч байсаар байна.”³⁴

“Би та нарыг нэг л хумхын тоосоор бүтээсний учрыг чи мэдэхгүй гэж үү? Хэн ч өөрийгөө бусдаас дээгүүр бүү тавиасай гэсэндээ тэр.”³⁵

“Энэ л Өдөр тэнгэрлэг нигүүлслийн Мутар бүх ялгааг арилгасан билээ. Бурханы зарц нар болон Түүний шивэгчид нэг түвшинд буй хэмээн үзнэ.”³⁶

11 ДҮГЭЭР ХЭСЭГ

Таны судлах ёстой сүүлчийн сэдэв бол бүх нийтийн боловсролын тухай юм:

Боловсролыг хөхиүлэн дэмжих нь манай цаг үеийн хамгийн чухал хэрэгцээ юм. Аливаа улс гүрэн боловсролыг чухал асуудлынхаа тоонд оруулаагүй цагт цэцэглэн хөгжих боломжгүй. Аливаа ард түмэн уруудан доройтож буйн үндсэн шалтгаан бол мэдлэгийн хомсдол юм.

Боловсрол нялх балчир наснаас эхлэх учиртай. Эцэг эхийн үүрэг, хүүхдээ хүмүүжүүлэх, зан чанарыг нь оюун санааны болон ёс суртахууны зарчимд нийцүүлэн төлөвшүүлэх, мөн түүнчлэн урлаг, шинжлэх ухаанд сургахын төлөө чадах бүхнээ хийхэд оршино. Ээжүүд бол хүн төрөлхтний анхны сурган хүмүүжүүлэгчид; үр хүүхдэдээ тэд мэдлэг оюунаараа ундаалан өсгөдөг. Хүүхэд бүр сурч боловсрох ёстой; уг асуудалд үл ойшоож хэрхэвч болохгүй. Эцэг эх нь хүүхдийнхээ сургалтын зардлыг бүрэн гаргах боломжтой бол гаргах л хэрэгтэй. Үгүй бол тухайн хүүхдийн сургалтын зардлыг нийгэмлэгээс даах ёстой.

Боловсрол хүн бүрийн амжилтад хүрэх хүслийг бадраан хөгжүүлэх учиртай. Бид хүний төгс төгөлдөр чанарт татагдан, түүнд тэмүүлдэг байх ёстой. Бид оюун санаагаараа ялгарч чин сэтгэл, үнэнч зан, хүн төрөлхтний төлөөх үйлчилгээ, энэрэл хайр, шударга ёс гэх зэрэг нандин зан чанаруудаараа танигдахын төлөө хичээх ёстой. Бид энх тайван, эв нэгдлийг сурталчлах, сурч боловсрох явдлыг дэмжих хүчин чармайлтаараа бусдаас ялгарахыг эрмэлзэх ёстой.

1. Мэдэгдлийг бүлгээрээ уншиж судалсныхаа дараа, нөхөд чинь боловсролтой холбоотой ямар асуудалд санаа зовж явдгийг олж тогтоох гээд үз. Дээрх санаанууд тэдний асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?

2. Бахауллагийн Сургаалаас авсан доорх эшлэлүүдээс нэг эсвэл хэд хэдийг цээжлэхийг зөвлөө:

“Хүн эрдэм мэдлэг эсвэл ур чадваргүй хоцорно гэдэг хүсэх зүйл биш. Учир нь тэрээр үр жимсээ өгдөггүй нүцгэн мод лугаа адил байх юм.”³⁷

“Газар дэлхийн ард түмэн, улс үндэстнүүдийг соён гэгээрүүлэхийн тулд оюун ухаан, хүсэл зоригоо зориул...”³⁸

“Урлаг, гар урлал, шинжлэх ухаан нь оршихуйн ертөнцийг сайжруулж, дэвшин дээшлэхэд нь дөхөм болдог билээ.”³⁹

“Үнэн хэрэгтээ эрдэм мэдлэг бол хүний хувьд жинхэнэ эрдэнэ бөгөөд алдар суу, буян хишиг, аз жаргал, хөгжил дэвшил, баяр цэнгэлийн эх булаг юм.”⁴⁰

12 ДУГААР ХЭСЭГ

Энх тайван бол хүн бүрийн бодолд байдаг сэдэв юм. Энх тайвныг тогтоох явдал нь нэн яаралтай бөгөөд амин чухал. Өмнөх хэсгүүдэд гарсан зарчмуудын талаар хэсэг бодсон та одоо даян дэлхийн энх тайвны талаар эргэцүүлэн бодох нь зүйтэй хэмээн үзэж байгаа байх.

Засгийн газрууд, дайныг арилгах дорвитой алхам хийх эсэхээс олон зүйл шалтгаалах нь мэдээж. Маргааныг шийдвэрлэж зэвсгийг хорогдуулах улс төрийн гэрээ хэлэлцээрүүд нь улс орнууд хоорондын олон төрлийн хамтын ажиллагааны нэгэн адил энх тайванд хүрэхэд чухал ач холбогдолтой. Энэ бүх арга хэмжээ хэдий чухал ч гэлээ, өмнө нь хэлэлцсэн зарчмуудыг дэлхий даяар тогтоохгүй л бол энх тайванд хүргэхгүй. Бид “Хүмүүс бодит байдлыг судалж, үнэн бол чухамдаа нэг гэдгийг ухаараахгүй л бол олон зуун жилийн дайсагнал цаашид ч үргэлжлэхгүй гэж үү?” хэмээн өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Бид бүгд гарал нэгтэй. Бурхан биднийг бүгдийг нь харж хамгаалан Элч нараараа дамжуулан соён гэгээрүүлдэг. Тэдний сургаал бичвэр хайр, нөхөрлөлийн нэгэн суурин дээр тогтдог билээ. Шашны нэгдмэл байдлыг хүлээн зөвшөөрсөн цагт л шашны сөргөлдөөн намжиж, итгэл үнэмшлийн гэгээ энх тайванд хүрэх замыг гэрэлтүүлнэ. Цаашлаад бид “Мунхаг харанхуйн мананг арилган, энх тайванд хүрэхэд томоохон саад болдог бүхий л төрлийн өрөөсгөл үзэл нь эндүү ташаа болохыг харуулахын тулд шинжлэх ухаан, шашин хоёр гар нийлэх хэрэггүй гэж үү?” гэж өөрсдөөсөө асуух хэрэгтэй. Дэлхийн өнцөг булан баян хоосны хэт ялгааг арилгаагүй цагт даян дэлхийд энх тунхыг тогтоож болно гэж үү? гэдэг бас нэг асуулт. Түүнчлэн эмэгтэйчүүд, хүний үйл ажиллагааны бүхий л салбарт эрэгтэйчүүдтэй адил тэгш эрхтэйгээр орж ирдэг болохоос нааш түүхийн томоохон үеийг тодорхойлсоор ирсэн хүчирхийлэл нь амар амгалан байдал, хөгжил цэцэглэлтээр солигдохгүй. Ирээдүй хойч үе бүх нийтээрээ эдгээр зарчмын дагуу хүмүүжин боловсрох ёстой, эс тэгвээс энх тайванд хүрэх бүх итгэл найдвар тасрах болно. Та, хүн төрөлхтний ирээдүйн төлөө сэтгэл зовниж явдаг бусад хүмүүстэй хуваалцах зорилгоор Бахауллагийн дараах үгийг цээжилж болох юм:

“Хүн төрөлхтний сайн сайхан аж байдал, энх тайван, аюулгүй амгалан байдал нь хүн төрөлхтний дунд бат бөх эв нэгдэл тогтохоос нааш биелшгүй билээ.”⁴¹

ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. *Бахауллагийн сургаалын дээжис* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1983, 2017 оны хэвлэлт), СІХ, 2-р догол мөр, 243-р нүүр.
2. Дээрхийн адил, СХХХІІ, 1-р догол мөр, 325-р нүүр.
3. Дээрхийн адил, ХХХІV, 5-р догол мөр, 89-р нүүр.
4. *Бахауллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1988, 2005 оны хэвлэлт), но. 11.1, 161-р нүүр.
5. Бахаулла, *Китаб-и-Иган: The Book of Certitude* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2003, 2018 оны хэвлэлт), 151-р догол мөр, 131-р нүүр.
6. *Бахауллагийн сургаалын дээжис*, ХХVІІІ, 2-р догол мөр, 77-р нүүр.
7. Дээрхийн адил, ХХІV, 1-р догол мөр, 66-р нүүр.
8. Дээрхийн адил, СХІ, 1-р догол мөр, 246-р нүүр.
9. Дээрхийн адил, ХLІІІ, 6-р догол мөр, 106-р нүүр.
10. Дээрхийн адил, СХ, 1-р догол мөр, 244-р нүүр.
11. *Бахауллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 15.4, 220-р нүүр.
12. *Бахауллагийн сургаалын дээжис*, ХСV, 1-р догол мөр, 219-20-р нүүр.
13. *Бахауллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 9.13, 141-р нүүр.
14. Дээрхийн адил, но. 5.13, 51-р догол мөр.
15. *Бахауллагийн сургаалын дээжис*, СХІІ, 1-р догол мөр, 247-48-р нүүр. 16. Ibid., СХХХІІ, 3-р догол мөр, 326-р нүүр.
17. Дээрхийн адил, СХІ, 1-р догол мөр, 246-р нүүр.
18. *Бахуллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 7.20, 90-р нүүр.
19. Дээрхийн адил, но. 6.25, 66-67-р нүүр.
20. Бахауллагийн сургаалаас ШогИ Эффендигийн эш татсанаар, *Тэнгэрлэг Шударга ёс Айсуй* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2006, 2018 оны хэвлэлт), 42-р догол мөр, 41-р нүүр.
21. *Бахуллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 3.23, 27-р нүүр.

22. Бахаулла, *Эрдэнийн нуугдмал үгс* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2003, 2012 оны хэвлэлт), Перс хэл дээрх но. 80, 51-р нүүр.
23. *Бахуллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 6.19, 64-р нүүр.
24. Дээрхийн адил, но. 6.37, 71-р нүүр.
25. Бахаулла, *Хукуку'лла – Бурханы Эрх: Бахаулла болон Абдул-Баха нарын Сургаал, мөн ШогИ Эффенди болон Даян Дэлхийн Шударга Ёсны Ордны нэрийн өмнөөс бичсэн захидлуудаас авсан эшлэлийн эмхэтгэл*, ДДШЁО-ны Судалгааны Хэлтсээс эмхэтгэсэн (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 2007), но. 16, 16-р нүүр.
26. *Бахауллагийн сургаалын дээжис*, CXVIII, 2-р догол мөр, 283-р нүүр.
27. Дээрхийн адил, CXVII, 1-р догол мөр, 282-р нүүр.
28. Бахауллагийн сургаалаас ШогИ Эффендигийн эш татсанаар, *Амлалт өдөр айсуи* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1996, 2018 оны хэвлэлт), 279-р догол мөр, 187-р нүүр.
29. *Бахауллагийн сургаалын дээжис*, CXVII, 1-р догол мөр, 282-р нүүр.
30. *Бахауллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 4.11, 36-р нүүр.
31. Дээрхийн адил, но. 6.3, 57-р нүүр. 32. Дээрхийн адил, но. 6.3, 58-р нүүр.
33. *Эрдэнийн нуугдмал үгс*, Перс хэл дээрх но. 5, 23-24-р нүүр.
34. Бахаулла, *Эмэгтэйчүүд: Бахаулла, Абдул-Баха, ШогИ Эффенди болон Даян Дэлхийн Шударга Ёсны Ордны сургаалаас авсан эшлэлүүд*, ДДШЁО-ны Судалгааны Хэлтсээс эмхэтгэсэн (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1986, 1997оны хэвлэлт), но. 54, 26-р нүүр.
35. *Эрдэнийн нуугдмал үгс*, Араб хэл дээрх но. 68, 20-р нүүр.
36. Бахаулла, *Эмэгтэйчүүд сэдэвт эмхэтгэл*, но. 3, 3-р нүүр.
37. Бахаулла, *Бүхий л талаар төгс: Бахайн Сургаалын эшлэлүүд*, ДДШЁО-ны Судалгааны Хэлтсээс эмхэтгэсэн (Лондон: Бахайн Хэвлэлийн Газар, 1981, 1989 оны хэвлэлт), но. 5, 2-р нүүр.
38. *Бахауллагийн сургаалын дээжис*, CLVI, 1-р догол мөр, 378-р нүүр.
39. Бахаулла, *Чонын Хөвүүнд илгээсэн захидал* (Уильметт: Бахайн Хэвлэлийн Газар, 1988, 2016 оны хэвлэлт), 26-р нүүр.
40. *Бахауллагийн Китаб-и-Агдасын дараа нээсэн Бичгүүд*, но. 5.13, 52-р нүүр.
41. *Бахауллагийн сургаалын дээжис*, CXXXI, 2-р догол мөр, 324-р нүүр.



Гүнзгийрүүлэх сэдвүүд

Зорилго

Оюун санааны хувьд ач холбогдол бүхий
сэдвээр ярилцах зорилгоор найз нөхөд,
хөршүүдээрээ айлчлах дадлыг хөгжүүлэх

1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Энэ гурав дахь бүлэг нь өмнөх бүлгийн нэгэн адил утга учиртай, сэтгэл сэргэм яриа өрнүүлэх боломжийг бидэнд олгох чадавхуудын тухай юм. Хоёр дахь бүлэг бид оюун санааны зарчмуудад хандсанаар харилцан яриагаа дараагийн түвшинд аваачих олон жишээг авч үзсэн. Энэ хэсэгт бид нийгэмлэгийн амьдралын гол сэдвүүдийг найз нөхөд, хөршүүдийнхээ хамт судлах зорилгоор гэрээр айлчлах тухай ярилцах болно.

Дэлхийн өнцөг булан орших тосгод болон бичил хороонд хэсэг нөхөд тогтмол зохиогддог мөргөлийн цуглаан, хүүхдүүдэд оюун санааны боловсрол олгох сургалт, өсвөр насны залуусын уулзалт, сургалтын дугуйлан, залуучуудад зориулсан зуслан сургалт, төрөл бүрийн кампанит ажил гээд харилцан уялдаа бүхий олон үйл ажиллагаанд идэвхтэй оролцож яваа. Үйл ажиллагааны энэ загвар тухайн газар хэрэгжиж, үйлчлэхүйн үйлсэд өөрийгөө зориулах хүмүүсийн тоо улам нэмэгдэхийн хэрээр тухайн бичил хорооны цөм баг улам тэлж чадавхаждаг. Тосгон эсвэл хорооныхоо олон айл өрхүүдээр айлчлах системт хөтөлбөр нь нийгэмлэгийг бүтээх босгох үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Ийм айлчлалын үеэр олон сэдвийг хөндөж ярьдаг. Жишээлбэл, Бахайн хүүхдийн хичээлийн багш нь боловсролтой холбоотой сэдвээр ярилцах зорилгоор сурагчдынхаа эцэг эхчүүдтэй гэрээр нь очиж уулзаж байх хэрэгтэй. Удирдагч болон сургагчид, хүний амьдралын хамгийн сайхан үед олддог боломж, тулгардаг асуудлын талаар ярилцах зорилгоор өсвөр насныхан болон залуучуудын гэрээр ижил төстэй айлчлал хийдэг байх ёстой. Өрхийн гишүүдтэй, Шүтлэгийн талаарх мэдлэгийг нь гүнзгийрүүлэх сэдвээр ярилцах нь мөн адил чухал болох нь харагддаг. Эдгээр айлчлалын нийгэмлэг доторх нөхөрсөг харилцаанд үзүүлэх нөлөөг үнэлэхийн аргагүй юм.

2 ДУГААР ХЭСЭГ

Энэхүү бүлгийг үзэж судлахын тулд бид дээр дурдсан үйл явц өрнөж буй төсөөллийн бичил хороонд айл өрхүүдээр зочлох үед өрнөж болох ярианы төрлүүдийг судлах контекст болгон ашиглах юм.

Александра бол их сургуулийн гуравдугаар дамжааны оюутан бүсгүй. Тэрээр бидний төсөөлж буй бичил хороонд аав, ээж, оюутан ахынхаа хамт амьдардаг. Тэр дөрөв болон бичил хороонд нь саяхан нүүж ирсэн залуухан гэр бүл долоо хоног бүр уулзан хамтдаа мөргөн залбирч, ойр хавьд нь 8000 орчим хүний дунд зохиогддог үйл ажиллагааны явцын талаар зөвлөлдөн ярилцдаг. Энэ мөргөлийн цуглаанд нь өөр гурван хүн үе үе оролцож, өөрийн үйлчлэхүйн талаар төдийгүй нийгэмлэгийг бүтээн босгох үйл явцын талаар системтэйгээр бодож эхлээд байгаа. Тэд бол зургаан сарын өмнө хичээллэж эхэлсэн хүүхдийн хичээлийн багш, мөн Александрагийн ахын (багад нь бүлгийн удирдагч хийдэг байсан) тусламжтайгаар өсвөр насныхны бүлгийг удирдан чиглүүлж, аав ээжийнд нь тогтмол ирдэг 17 насны хоёр залуу юм.

Бидний авч үзэх эхний яриа нь Алехандра болон хөршүүдийнхээ дунд ихээхэн нэр хүндтэй Санчезынхны гэр бүлийн хооронд өрнөх юм. Санчезынхан бол охид хөвгүүдээ өсгөн хүмүүжүүлээд, одоо Алехандрагийн гэрээс хэдхэн гудамжны цаана тусдаа амьдардаг жар гарч яваа эхнэр нөхөр хоёр юм. Ноён, хатагтай Санчез нар бичиг үсэгт тайлагдсан хэдий ч албан ёсны боловсрол гэхээр зүйл эзэмшээгүй. Тэд өргөн олонд хүндлэгддэг болсон нь өгөөмөр сэтгэл, буянт үйлсээр дүүрэн амьдралаас олж авсан мэргэн ухаантай нь холбоотой юм. Тэд Бахайн сургаалын талаар мэддэг болоод хэсэг хугацаа өнгөрсөн ч саяхнаас л нухацтай судлахаар шийджээ. Мөн долоо хоногийн өмнө тэд Алехандрагийн аав ээжид нийгэмлэгт нэгдэн орох хүсэлтэй байгаагаа дуулгажээ. Тэднийг угтан авах цуглааныг хэдийн төлөвлөсөн байгаа аж. Түүнээс гадна Алехандра тэднийхээр хэдэн долоо хоногийн турш тогтмол зочилж, Шүтлэгийн талаарх мэдлэгээ гүнзгийрүүлэхэд нь нэмэр болох хэд хэдэн сэдвийг тэдэнтэй хуваалцахаар болоод байгаа. Түүний хийсэн айлчлалын тэмдэглэлтэй танилцсанаар та эдгээр сэдвүүдийг үзэж судлахын зэрэгцээ ярианых нь динамикийг эргэцүүлэх боломжтой болох юм.

3 ДУГААР ХЭСЭГ

Алехандра ноён, хатагтай Санчез нартай хийх анхны яриагаа доор толилуулсан Бурханы мөнхийн Гэрээсийн сэдвийн товч тайлбар дээр үндэслэхээр төлөвлөжээ.

Бүхнийг бүтээгч нь Цорын ганц, Зүйрлэшгүй, Дангаар Оршигч Бурхан билээ. Бахаулла бидэнд айлдахдаа, Бурханы мөн чанарыг хүний оюун ухаарах аргагүй, учир нь хязгаартай нь хязгааргүйг ойлгож үл чадна гэсэн байдаг. Хүмүүсийн Түүний талаарх ойлголт бол ердөө өөрсдийнх нь төсөөлөл юм. Бурхан бол хүн биш, Тэрээр орчлон ертөнцөөр нэг тархсан энгийн хүч ч биш. Бидний оршихуйн Эх Сурвалжийг тодорхойлоход заавал ашиглах ёстой үгс болох Тэнгэрлэг Эцэг, Тэнгэрлэг Хүч, Агуу Сүнс гэх мэт нь Түүний алдар нэр, шинж чанаруудыг хүний хэлээр л илэрхийлж байгаа хэрэг бөгөөд Түүнийг дүрслэхэд огт хангалтгүй.

Эрдэнэсийн нуугдмал үгсэд ийн өгүүлсэн байдаг:

“Аяа, Хүмүүний үр! Би бүтээлийг чинь хайрладаг болохоор чамайг бүтээсэн юм. Иймээс Намайг хайрлаж яв. Тэгэх ахул Би чамайг нэрээр чинь дуудаж, зүрх сэтгэлийг чинь амин сүнсээр дүүргэж чадмуй.”¹

Энэ эшлэлд Бахаулла биднийг хайрлах Бурханы хайр бол бидний оршин тогтнож буйн гол шалтгаан гэжээ. Биднийг хамгаалж, тэтгэж, амин сүнсээр дүүргэдэг энэ хайрыг бид ямагт мэдэрдэг байх учиртай. Бид зовсон ч, жаргасан ч, гутарсан ч, баярласан ч Бурхан биднийг хайраараа үргэлж өлгөйдөн байдгийг санах ёстой.

Бурхан биднийг Хайраараа бүтээснээр бидэнтэй Гэрээс байгуулсан гэдгийг бид Бахайн Сургаалаас олж мэддэг. “Гэрээс” гэдэг үг нь хоёр ба түүнээс олон хүний хооронд байгуулсан гэрээ, тохирсон амлалт гэсэн утгатай. Мөнхийн Гэрээнд өгүүлснээр, Хамгаас Өгөөмөр Бүтээгч биднийг хэзээ ч хөсөр хаядаггүй бөгөөд үе үе аль нэг Тодруулагчаараа дамжуулан Өөрийн Хүсэл ба Зоригийг бидэнд таниулдаг.

“Тодруулах” гэдэг үйл үг урьд хожид үзэгдээгүй зүйлийг ил болгох, нээн харуулах гэсэн утгатай. Бурханы Тодруулагчид нь Бурханы Үгийг бидэнд нээж өгдөг онцгой Хүмүүс юм. Бурханы Хүслийн дагуу хэрхэн амьдарч, жинхэнэ аз жаргалд хэрхэн хүрэхийг бидэнд зааж сургадаг даян дэлхийн Соён гэгээрүүлэгчид юм. Эдгээр Тодруулагчдын дунд Абрахам, Кришна, Моисей, Зороастр, Будда, Христ, Мухаммед болон энэ эрин үеийн Бурханы Ихэр Тодруулагч болох Баб, Бахаулла нар багтдаг билээ.

Ийнхүү мөнхийн Гэрээсээр Түүний хүлээсэн үүрэг ямагт биелсээр ирсэн билээ. Бид бүхэн өөрсдөөсөө асуух ёстой чухал асуулт бол “Би Гэрээсээр хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх вэ?” юм. Шашны бүх судраас бидний олж мэдсэн хариулт бол “Бурханы Тодруулагчийг хүлээн зөвшөөрч, Түүний сургаалыг дагаснаар” юм. Энэ хариултаас үзэхэд Бурханыг таньж мэдэн, шүтэн бишрэх нь бидний амьдралын утга учир гэдэг нь илт байна. Заавал үйлдэх богино мөргөлд бид ийн тунхагладаг билээ:

“Бурхан минь ээ! Таныг танин мэдэж, шүтэн биширч яваг хэмээн Та намайг бүтээсэн билээ. Өчүүхэн би хүч мөхөс харин Та хамгаас хүчтэй, би үгээгүй ядуу харин Та хамгаас баян болохыг энэ мөчид би гэрчилнэм.

Танаас өөр Бурхан байхгүй. Та бол Зовсон цагт Аврагч, эгнэгт Дангаар Оршигч билээ.”²

Бурханыг бид Түүний Тодруулагчдаар дамжуулахгүй л бол таньж мэдэх аргагүй тул бидний хувьд амьдралынхаа зорилгод хүрэх цорын ганц арга бол Тэднийг хүлээн зөвшөөрч, Сургаалыг нь дагах явдал юм. Дэлхий дахинд энх тайван, шударга ёс тогтоно хэмээн бүхий л Ариун Судар дахь амлалт биеллээ олж буй эрин үед амьдарч байгаадаа талархах сэтгэлээр бидний зүрх сэтгэл бялхан байна. Бахаулла ийнхүү айлдсан байдаг:

“Энэ бол Бурханы нэн төгс буян хишиг хүмүүст түгсэн Өдөр, Бурханы нэн хүчирхэг гоо жавхлан хамаг амьтанд цацагдсан Өдөр болой. Дэлхий ертөнцийн хүн ард бүгдээрээ хоорондын зөрчил тэмцлээ арилган эвлэрэлдэж, төгс эв нэгдэл, энх тунхаар Бурханы хайр халамжийн Модны сүүдэр дор орших ёстой.”³

Бид түүхээ цааш нь үргэлжлүүлэхийн өмнө та дээрх тайлбарыг уншиж танилцан, бүлгийнхээ бусад хүмүүстэй догол мөр бүрээр нь тунгаан бодох хэрэгтэй. Та бүхэн, хүн бүр санаагаа чөлөөтэй илэрхийлж чаддаг болтол нэг нэгэндээ асуулт тавьж, хамтдаа хариулж болох юм. Эшлэлүүдийг сайн сурах нь нэн чухал, учир нь энэ төрлийн хэлэлцүүлгийн үеэр Сургаалын хэсгүүдээс заавал хуваалцаж байх шаардлагатай. Дараах дасгалууд танд, энэ хэсэгт гарсан санаанууд болон эшлэлүүдийн утгыг тунгаан бодоход тус болно.

1. Та хэн нэгэн хүнд Бурханы мөн чанарыг таньж мэдэх аргагүй гэдгийг хэрхэн тайлбарлах вэ? Дээр толилуулсан эхний догол мөр танд нэмэр болох учиртай.

2. Бурхан бидний яагаад бүтээсэн бэ? _____

3. “Гэрээ” гэдэг үг ямар утгатай вэ? _____

4. Бурхан хүн төрөлхтөнтэй байгуулсан Мөнхийн Гэрээндээ ямар амлалт өгсөн бэ? _____

5. Бидний амьдралын зорилго юунд оршдог вэ? _____

6. Бид Бурханыг хэзээ ч таньж мэдэх боломжгүй юм бол “амьдралын маань утга учир Бурханыг таньж мэдэхэд оршино” гэдэг нь ямар утгатай вэ? _____

7. “Тодорхойлох” гэдэг үг ямар утгатай вэ? _____

8. Бурханы Тодруулагчдаас нэрлэнэ үү: _____

9. Бид Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд юу хийх шаардлагатай вэ?

10. Дараах өгүүлбэрүүдийг гүйцээнэ үү:

a. Энэ бол Бурханы _____ хүмүүст түгсэн Өдөр.

b. Энэ бол Бурханы _____ хамаг амьтанд цацагдсан Өдөр.

c. Энэ өдөр бид хоорондын зөрчил тэмцлээ _____, төгс эв нэгдэл, энх тунхаар _____

11. Бахаулла дэлхийн ард түмнүүдээс юу хийхийг хүссэн бэ? _____

4 ДҮГЭЭР ХЭСЭГ

Алехандра ноён, хатагтай Санчезтай хуваалцахаар бэлдсэн сэдвийнхээ талаар л бодож байгаа юм биш. Алехандра тэр хоёртой дотно нөхөрлөнө хэмээн найдаж байгаа. Тэрээр ялгаварлан гадуурхах үзэл, дээрэнгүй хандлага аль аль нь ямар хортой болохыг хувийн туршлагаасаа сайн мэдэх тул тийм хандлага гаргахаасаа мэдээж болгоомжилно; түүний дээд боловсрол нь ч даруу төлөв занд нь нөлөөлсөнгүй. Түүний сэтгэл зүрхэнд Санчезынхныг хайрлаж хүндлэх сэтгэлээс өөр юу ч үгүй аж. Тэрээр эхний сэдвээ хэрхэн тайлбарлах тухайгаа эргэцүүлэн бодож байхдаа энэ бол хэдэн долоо хоногийн турш үргэлжлэх ярианы эхлэл гэдгийг өөртөө сануулж байлаа. Санаагаа дэс дарааллаар нь ойлгомжтой илэрхийлэх нь чухал хэдий ч үе үе зогсож хоёр хөгшний хэлэх үгийг сонсож байх ёстой гэдгээ тэрээр ойлгож байв. “Би сандарч л болохгүй... тэгэх л юм бол өөрөө ярьсаар байгаад харилцан яриа өрнөх боломжийг хааж орхино” гэж тэрээр өөртөө хэлэв. Алехандра айлчлалынхаа тухай энэ мэтээр хэсэг бодлоо. Хэрэв та түүний оронд байсан бол доорх бодлуудын алийг нь зөв зүйтэй гэж үзэх байсан бэ?

_____ Санчезынханд Шүтлэгийн талаар зааварлаж, заасан бүхнийг минь мэдэж авч буйд анхаарах нь миний үүрэг.

_____ Энэ сайхан хүмүүстэй хамт цагаа өнгөрүүлж, ариун Сургаалаас хуваалцана гэдэг ямар адислагдсан, буян хишигтэй хэрэг вэ?

_____ Энэ айлчлал чухал гэдгийг мэдэж байна л даа. Гэхдээ л их цаг орохгүй байгаасаа гэж найдаж байна. Учир нь би өөр хийх ажилтай.

_____ Миний хуваалцах эшлэлүүд энэ хоёрт хүндэднэ. Энгийн санаа ганц нэгийг дурдаад явчихъя. Тэднийг хайрлан хүндэлж байгаагаа харуулах л чухал.

_____ Санчезынхны насан дээр юм сурах боломжгүй.

_____ Би Санчезынхны гэрээр зочилж, тэдэнтэй сэдвийнхээ талаар ярилцаж эшлэлүүдээ тунгаан бодохыг тэсэн ядан хүлээж байна.

_____ Тэр хоёр уншиж чадах юм чинь би зөвхөн сэдвээ танилцуулчхаад, эшлэлүүдийг бие даан судлаарай гээд өгчихье.

_____ Сэдвээ танилцуулж байх явцдаа би үе үе зогсож эшлэлүүдээ тэдэнтэй хамт судалж ярилцана.

_____ Би сэдвээ, дунд нь огт зогсохгүйгээр танилцуулсныхаа дараа тэр хоёроос асуулт байгаа эсэхийг нь асууна.

Ийм айлчлалд бэлдэж байхдаа бодох эсвэл бодох ёсгүй зүйлс юу байж болох вэ?

5 ДУГААР ХЭСЭГ

Алехандрагийн Санчезынхныд хийсэн эхний айлчлал сайхан болж байна. Гэрийн эзэд түүнийг сандарч байгааг хараад элэгсэг дотно байдлаараа тайвшрууллаа. Тэд Алехандраг анхааралтай сонсон ярианд идэвхитэй оролцохдоо эшлэлүүдэд онцгой анхаарал хандуулах аж. Яриа дуусах алдад багахан “гацаа” үүсэв. Ноён Санчез “Бахайн нийгэмлэгт элсэн орсноороо би Христосыг мартаж байгаа хэрэг үү?” хэмээн асууж Алехандраг бүр гайхшруулж орхив. Алехандра хариултыг нь мэдэж байсан ч томьёолж хэлэхэд хугацаа хэрэгтэй байв. Ноён Санчез инээмсэглээд “Бахайн сургаалын талаар олж мэдсэнээсээ хойш би Христийг улам ихээр хайрлах болсон гэж бодож байгаа шүү” гэсэн нь Алехандрад тус болов. Алехандра түүний хэлсэн дээр нэмэрлэн “Дэлхий даяар маш олон хүн ингэж боддог. Тэдний Моисей, Христ, Кришна, Будда, Зороастр, Мухаммед нарыг хайрлах хайр Бурханы нэгдмэл чанар, шашны нэгдмэл байдал болон хүн төрөлхтний эв нэгдлийн тухай Бахауллагийн сургаалын ачаар улам хүчтэй болдог юм.” гэж хэлэв.

Ямар зан чанар, хандлага гаргаж байж Алехандрагийн айлчлал ийм үр өгөөжтэй болох тухай бүлгээрээ хэлэлцэх нь танд нэмэр болох болно. Тэдгээр зан чанарууд дотроос хамгийн чухал нь даруу төлөв зан. Бүх даруу байдлын үндэс бол Бурханы өмнө даруу төлөв байх явдал. Чухам эндээс л Түүний бүтээлүүдийн өмнө даруу

номхон байх явдал эхэлдэг. Даруу төлөв байх нь Бурхан болон Түүний Тодруулагчдын тухай ярих үед хамгаас чухал. Та Бахауллагийн дараах үгсийг тунгаан, цээжлэхийг хичээх хэрэгтэй.

“Хаана ч цугласан, хэнтэй ч уулзсан, Бурханд хандах хандлагатаа, Түүнийг магтан мандуулахдаа Бурханы хайрт хүмүүс хөлөн дор нь гишгэгдэж буй шорооны эс ширхэг бүр тэдний үнэнч сэтгэлийн гүнийг илчлэхүйц тийм туйлын даруу хүлцэнгүй байх ёстой... Хөл доорх газар шороо тэдэнд хандан: Би та нараас хавьгүй дээр буй заа. Тариаланчийн нуруун дээр минь тохсон энэ их ачааг би ямар их тэвчээртэй үүрч буйг хараач. Бүхий л гоо жавхлангийн Эх булаг болсон Бурхан Өөрийн буян хишгийг хамаг амьтанд дамжуулан хүртээхийг надад итгэмжлэн даатгасан билээ. Өөрт оногдсон нэр төр, эрх мэдэл болон бүх л орчлон дэлхийг тэтгэдэг хязгааргүй их баялагтаа би эрдэж бардалгүй хүмүүсийн хөл дор гишгэгдэхдээ хэчнээн даруу хүлцэнгүй, тэсвэр тэвчээртэй байгааг харагтун...” гэж хэзээ ч хэлэхээргүй тийм төрх байдлыг тэд олж эзэмшвэл зохино.”⁴

Дээр өгүүлсэнчлэн, элэг нэгтнүүдийнхээ өмнө даруу төлөв байх нь Бурханы өмнө даруу номхон байхаас эхэлдэг. Зарим нэгэн сэдвийн талаарх ойлголт, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор найз нөхөр, хөршийнхөө гэрээр зочлохдоо бид яг ийм даруу байдалтай байдаг. Ярианыхаа үеэр бид бодол санаагаа Бурханы зүг хандуулан, өөрсдийнхөө болон эргэн тойронд байгаа бүх хүмүүсийн оюун бодол, зүрх сэтгэлийг гэрэлтүүлж хайрла хэмээн Түүнээс гуйдаг. Энэ зорилгоор цээжилж болох мөргөлөөс эш татан авсан хэсгүүд олон байдгаас цөөн хэдийг энд толилуулав:

“Бидний сэтгэл зүрхийг гэрэлтүүлэн гийгүүлж, бидэнд гярхай нүд болон соргог чих заяаж хайрла.”⁵

“Бурхан минь! Хязгааргүй буян хишгээ хүртээж, Өөрийн удирдамжийн гэрэл гэгээг цацруулж хайрла.”⁶

“Чинхүү ухаарлын үүд хаалгыг нээж, итгэл бишрэлийн гэрлийг цацруулж хайрла.”⁷

“Бурхан минь! Бидний мэлмийг гэрэлтүүлж хайрла, чингэснээр бид Таны гэрэл гэгээг олж хардаг болно.”⁸

“Бүхий л бие сэтгэлээрээ Танд хандан, Таны тэнгэрлэг эв нэгдлийн энэ мөчлөгт, Таны хүсэлд харш бүхнээс намайг хамгаалж хайрла хэмээн Танаас зүрх сэтгэл, оюун бодол, үг хэлээрээ хичээнгүйлэн залбиран гуйнам...”⁹

6 ДУГААР ХЭСЭГ

Санчезынхны гэрээр зочилж, мөнхийн Гэрээний сэдвээр тэдэнтэй ярилцсандаа Алехандра ихэд сэтгэл хангалуун байгаа ажээ. “Миний дараачийн айлчлал тэдний хувьд Бахауллагийн амьдралын тухай мэдлэгээ дээшлүүлэх сайхан боломж болох юм байна” хэмээн тэрээр бодлоо. Тэрээр доорх илтгэлийг ашиглах юм:

Бахаулла 1817 оны 11-р сарын 12-нд Персийн нийслэл Тегеран хотноо мэндэлжээ. Тэрээр бага байхын л ер бусын шинж чанаруудыг харуулж байсан тул эцэг эх нь Түүнийг аугаа хувь тавилан хүлээж байгаа гэдэгт итгэлтэй байв. Эзэн хааны дэргэд сайдын алба хашдаг байсан Бахауллагийн эцэг Хүүдээ хязгааргүй хайртай нэгэн байж. Нэг шөнө тэрээр Бахауллаг хөлгүй их далайд сэлэх агаад Түүний биеэс гэрэл цацран тэнгис далайг гийгүүлж байна хэмээн зүүдэлжээ. Түүний тас хар үс тал тал тийш хөвж байна гэнэ. Олон түмэн загас Түүнийг тойрон цуглах агаад бүгд нэг нэг ширхэг үснээс зуурсан байж. Загас жараахай олон байвч Бахауллагийн толгойноос ширхэг ч үс унасангүй гэнэ. Түүнийг юунд ч үл баригдан чөлөөтэй хөдлөхөд бүгд араас нь дагах аж. Бахауллагийн эцэг, мэргэн ухаанаараа алдаршсан нэгэн хүнээс зүүдийг нь тайлж өгөхийг хүсжээ. Мэргэн хүн түүнд: “Зах хязгааргүй их далай бол оршихуйн ертөнц юм. Бахаулла тэр ертөнцөд хэний ч туслалцаагүйгээр бүрэн эрхээ тогтооно. Олон түмэн загас жараахай бол Түүний дэлхийн ард түмнүүдийн дунд дэгдээх үймээн самууныг илэрхийлж байгаа хэрэг. Тэрээр Бүхнийг Чадагч Бурханы найдвартай хамгаалалтад байх тул энэ үймээн самуун Түүнд ямар ч хор болохгүй” гэжээ.

Арван гурав, дөрвөн настайдаа Бахаулла саруул ухаан, эрдэм мэдлэгээрээ эзэн хааны ордонд хэдийн алдаршсан байж. Эцэг нь Түүнийг хорин хоёртойд нас барахад, засгийн газар Түүнд эцгийнх нь албан тушаалыг санал болгосон юм. Гэвч Бахауллад төрийн хэрэгт оролцох бодол байгаагүй тул Тэрээр Бурханы заасан замаар замнахаар эзэн хааны ордныг орхин явжээ. Дарлагдсан, өвдөж шаналсан, ядуу зүдүү хүмүүст цагаа зориулж байсан Тэрээр төд удалгүй шударга ёсны төлөө тэмцэгч гэдгээрээ олонд танигдах болов.

Бахаулла хорин долоон настайдаа, хүн төрөлхтний удаан хүлээсэн энх тайван, эв нэгдэл, шударга ёсыг авчрах Бурханы Тодруулагч залран ирэх Өдөр буюу шинэ Өдрийн үүр хаяарч буйг тунхаглан байсан Бабын зарим Сургаалаас тусгай элчээр дамжуулан хүлээн авсан юм. Бахаулла Бабын Илгээлтийг шууд л хүлээн зөвшөөрч, хамгийн идэвхт шавь нарынх нь нэг болов. Персийн ард түмнийг захирч байсан эрхмүүд аминч үзлийнхээ улмаас харалган болж Бабын дагалдагсдыг онц хэрцгийгээр хахин хавчиж эхэлсэн юм. Тэд сурвалжит угсаа гаралтай Бахауллаг ч өршөөсөнгүй. Баб Өөрийгөө тунхагласнаас найман жил, Түүнийг баатарлагаар амиа алдсанаас хоёр жилийн дараа Бахаулла Хар Нүх хэмээх гянданд хоригдов. Хүзүүнд нь зүүсэн төмөр гинж даахын аргагүй хүнд

байсан тул Тэрээр толгойгоо ч өргөж дийлдэггүй байв. Бахаулла энд аймшигт зовлон зүдүүр дунд бүтэн дөрвөн сарыг өнгөрүүлсэн юм. Гэсэн ч чухам энэ гянданд хоригдож байхад нь Бурханы Ариун Сүнс Түүний зүрх сэтгэлийг дүүргэж, бүх эрин цагийн Амлагдсан Нэгэн болохыг нь Түүнд илчилсэн юм. Чухам энэ л гяндан дотроос Бахауллагийн Наран мандаж бүхий л хорвоо ертөнцийг гийгүүлсэн билээ.

Хар Нүхэнд дөрвөн сар хоригдсоныхоо дараа Бахаулла хамаг хөрөнгөө хураалгаж, гэр бүлийнхээ хамтаар цөллөгт илгээгдэв. Өвлийн тэсгим хүйтэнд тэд Персийн баруун уулсыг даган тухайн үеийн Оттоманы эзэнт гүрний нэг хот буюу өнөөгийн Ирак улсын нийслэл Багдад хотыг зорив. Хувь тавилант тэр хотыг зорин цас мөсөн дундуур хэдэн зуун километр замыг явган туулахдаа амссан зовлон зүдүүрийг нь үгээр илэрхийлэхийн аргагүй.

Бахауллагийн алдар нэр Багдад болон тэр бүс нутгийн бусад хотуудаар тархаж, хүмүүс цөлөгдөн ирсэн Хоригдлоос адис хүртэхээр гэрийнх нь үүдэнд улам олноороо ирдэг болов. Тэдний дунд Түүний алдар сууд атаархах хүмүүс цөөнгүй байсны нэг нь Бахауллагийн хайр халамжид амьдарч ирсэн Түүний эцэг нэгт дүү Мирза Яхья юм. Мирза Яхья хорон явуулгаараа Бабын дагалдагсдыг хооронд нь хагаралдуулж Бахауллагийн сэтгэлийг гонсойлгож байв. Нэг шөнө, Бахаулла хэнд ч хэлэлгүйгээр гэрээсээ гарч Курдистаны уулсыг зорьжээ. Тэрээр тэнд ганцаар даяанчлан сууж бясалган залбирдаг байв. Тэрээр нэг жижгэвтэр агуйд сууж энгийн хоол хүнсээр хооллож байв. Тэр нутагт Түүний угсаа гарал, дуудах алдрыг мэдэх хүн огт байгаагүй. Гэсэн ч нутгийн хүмүүс “Нэргүй Нэгэн” хэмээх Бурханаас заяасан мэдлэгтэй агуу Гэгээнтний тухай ам дамжин ярьцгаах болов.

Түүний ууган хүү Абдул-Баха, тэр Ариун Хүмүүний тухай дуулмагцаа хайрт Эцгээ таньсан байна. Ингээд Бахаулла Багдад хотод буцаж ирээч хэмээн захидал бичиж тусгай элчээр явуулсныг Эцэг нь хүлээн авснаар хоёр жил үргэлжилсэн хагацал нь эцэс болов.

Бахаулла эзгүй байх хооронд Бабчуудын нийгэмлэгийн нөхцөл байдал ихээхэн доройтсон байж. Бахаулла Курдистаны уулсаас эргэн ирж Багдад хотод долоон жил болохдоо Бабын хавчигдаж төөрөлдсөн дагалдагсдын урам зоригийг сэргээн бадраалаа. Тэрээр агуу байр сууриа хараахан зарлан тунхаглаагүй байсан хэдий ч Түүний хүчтэй, мэргэн үгс улам олон Бабчуудын сэтгэлийг татаж, нийгмийн бүхий л давхаргын хүмүүст хүндлэл хайр төрүүлж байв. Мухар сүсэгт хэт автсан исламын шашны санваартнууд Бахаулла өргөн олонд ямар хүчтэй нөлөөлж буйг харж тэвчсэнгүй. Тэд эрх баригчдад хандан, Персийн засгийн газрыг Оттоманы эзэнт гүрний зарим түшмэдтэй нэгдэн Бахаулла эх орноос нь алс хол Константинопль руу цөллөх хүртэл дахин дахин гомдол мэдүүлсээр байв.

1863 оны 4-р сар Багдад хотын оршин суугчдын хувьд гуниг харууслаар дүүрэн сар байлаа. Тэдний чин сэтгэлээсээ хайрладаг болсон Нэгэн хотыг нь орхин, хаашаа ч юм явах гэж байв. Бахаулла явахынхаа өмнөхөн хотын захад нэгэн цэцэрлэгт асар майхнаа босгож Өөртэй нь салах ёс хийхээр хуран цугласан олныг арван хоёр өдрийн турш хүлээн авсан юм. Бабын дагалдагсад тэрхүү цэцэрлэгт хүрэлцэн ирэхдээ сэтгэлээр ихэд унасан байж. Тэдний зарим нь Бахауллаг дараагийнх нь цөллөгөд дагалдан явж... ихэнх нь ард үлдэж байлаа. Гэвч Бурхан энэ үйл явдлыг уйтгар гунигаар дүүргэхийг хүссэнгүй. Түүний хязгааргүй нигүүлслийн хаалга үүд томоор нээгдэж Бахаулла, Бабын зөгнөсөн Нэгэн буюу Бурханы тодруулах ёстой Нэгэн гэдгээ ойр дотнынхоо хүмүүст зарлан тунхаглав. Хүмүүсийн уйтгар гуниг хязгааргүй баяр хөөрөөр солигдон сэтгэл нь сэргэж, зүрхэнд нь Түүний энэрэл хайрын гал бадрал. Дэлхийн өнцөг булан дөрөвдүгээр сард тохиодог энэ арван хоёр өдрийг Ризваны Баяр, Бахауллагийн дэлхийг хамарсан Үйл хэргээ тунхагласны ойн баяр болгон тэмдэглэдэг билээ.


Константинополь бол Оттоманы эзэнт гүрний төв байсан бөгөөд энд ч бас, дөрөвхөн сарын дотор, Бахауллагийн саруул ухаан, нандин зан чанарууд олны сэтгэлийг эзэмдэж эхлэв. Мухар сүсэгт хэт автсан санваартнууд “Тэрээр Константинополь хотод цаашид үлдэж болохгүй” гэж үглэсээр, эрх баригчдыг Түүнийг Адранополь руу цөл хэмээн ятгаж чадлаа. Адранополь хотод дөрвөн жил хагас амьдрахдаа Бахаулла дэлхийн хаад ноёд, төрийн тэргүүн нарт хандан Илгээлт захидал бичиж, тэднийг дарангуйллаа зогсоож ард түмнийхээ сайн сайхны төлөө бие сэтгэлээ зориулахыг уриалж байв. Дайснууд нь Түүнийг хамгийн хатуугаар шийтгэх арга бодож олов. Тэд Түүнийг гэр бүлийнх нь хамт тухайн үед эзэнт гүрний хамгийн хатуу гяндан-хот гэгддэг байсан Акка руу цөлөхөөр болов. Бурханы Өөрийнх нь эхлүүлсэн төлөвлөгөөг зогсоож чадна гэдэгтээ бардсан дорой ухаантай тэдгээр хүмүүс “Тэрээр тэр гяндан-хотын хатуу ширүүн нөхцөлд лав үрэгдэнэ” хэмээн бодож байлаа.

Бахауллагийн Аккад туулсан зовлон шаналлыг тоочихын аргагүй их юм. Тав тухтай амьдрахад хэрэгтэй бүхэн дутагдаж, дайснууд нь Түүнийг өдөр шөнөгүй хүрээлэн байлаа. Гэвч хорих нөхцөл нь аажмаар өөрчлөгдөв. Акка хотын оршин суугчид болон засгийн газар, хотод нь цөлөгдөн ирсэн хөөрхий хэдэн Бахайчуудыг гэм буруугүй гэдэгт итгэсэн байна. Түүний Агуу байр суурийг бүрэн ойлгоогүй ч хүмүүс энэ ер бусын Хүмүүний энэрэл хайр, мэргэн ухаанд дахин сэтгэл татагдаж эхэллээ. Есөн жилийн дараа гяндан хотын үүд хаалга Бахаулла болон Түүний дагалдагсдын өмнө нээгдэв. Түүний хайрт Хүү Абдул-Баха, Эцэгтээ хотын хэрмийн гадна амьдран суух сайхан байр олов. Хожим нь Тэрээр хөдөө нутагт нэгэн байшин түрээсэлдэг болсон бөгөөд тэнд Бахаулла амьдралынхаа үлдсэн арван гурван жилийг харьцангуй энх тунх, амар тайван өнгөрүүлсэн юм. Тэр байшинг өнөөгийн бид Бахжи дахь Харш гэдгээр нь мэддэг

бөгөөд чухам тэнд Бахаулла 1892 оны 5-р сард Өөрийн сүр жавхлан, алдрын оргил үед таалал төгссөн юм.

Бахаулла даян дэлхийн энх тунх, эв нэгдлийн туг далбааг өндөрт мандуулж Бурханы Үгийг нээсэн билээ. Атаат дайснууд нь Түүний эсрэг хүчээ нэгтгэсэн ч Тэрээр ялалт байгуулсан билээ... яг л Тегераны харанхуй гянданд гав гинжтэй байхад нь Бурхан амласан ёсоор. Бахауллагийн Сургаал, Түүнийг амьд ахуйд нь мянга мянган хүний зүрх сэтгэлийг сэргээсэн бөгөөд өнөөдөр ч дэлхий даяар түгсээр байгаа билээ. Хүн төрөлхтнийг нэг Үйл хэрэг, нэг Шүтлэгт нэгтгэх туйлын зорилгодоо хүрэхэд нь Түүнд юу ч саад болж чадахгүй.

Бахауллагийн амьдралын тухай дээрх түүх харьцангуй урт юм. Доорх дасгалууд руу орохоосоо өмнө энэ түүхийг догол мөр бүрээр нь уншиж судлан, агуулгыг сайтар сурч, чөлөөтэй ярьдаг болтлоо нэг нэгэндээ асуулт тавих хэрэгтэй. Доорх газрын зураг танд Бахауллагийн цөллөгийн замыг, мөн замд тохиолдсон үйл явдлуудыг эргэн санахад тус болно.



1. Дээрх түүхийг үндэслэн Бахауллагийн амьдралын гол гол үйл явдлуудыг дарааллаар нь бичих нь танд тус болно байх.

2. Бахауллагийн амьдралын сэдвээр ярилцах үед үйл явдлын дэс дарааллаас гадна онцлон тэмдэглэвэл зохих хэд хэдэн ойлголт бий. Хүн төрөлхтнийг хайрлах хайрынхаа төлөө Түүний туулсан зовлон зүдүүрийг мөн хэдий эсэргүүцэл тэмцэлтэй тулгасан ч Түүний Шүтлэг ямар их агуу ялалтуудыг байгуулсан тухай эргэцүүлэн бодох нь онц ач холбогдолтой юм. Эдгээр үг бидний оюун бодол, зүрх сэтгэлд хоногшин үлдэх болтугай.

“Хүн төрөлхтөн өөрийн хүлээснээс тайлагдаасай гэсэндээ Өнө Эртний Гоо үзэсгэлэн гав гинжинд дөнгөлүүлж, бүхий л дэлхий ертөнц жинхэнэ эрх чөлөөг олоосой гэсэндээ Тэрээр энэхүү хүчирхэг Цайзад хоригдохыг зөвшөөрсөн билээ. Дэлхийн бүх ард түмнүүд үүрдийн жаргалыг олж, баяр баяслаар бялхаасай гэсэндээ Тэрээр зовлон зүдүүрийн аяганаас ёроолд нь хүртэл уусан билээ. Энэ бол Нигүүлсэнгүй, Хамгаас Энэрэлт Эзэн тэнгэрийн тань энэрэл хайр болой. Та нарыг дэвжин дээшлээсэй гэсэндээ Бид доромжлол үзэж, та нарыг хөгжин цэцэглээсэй гэсэндээ үй түмэн хэцүү бэрхийг амсах болсон юм, аяа, Бурханы Эв нэгдэлд итгэгч нар аа. Өөрсдийгөө Бурхантай эн зэрэгцүүлж тавьсан хүмүүс дэлхий ертөнцийг шинэтгэн төвхнүүлэх гэж залран буусан Түүнийг хамгийн алс холын хотод хүчээр суулгах болсон буйг харагтун!”¹⁰

Бахауллагийн туулсан зовлон зүдүүрийн талаар ярихдаа Түүнийг, дайснуудынхаа эрхэнд орсон сул дорой нэгэн байсан мэтээр дүрслэхээс болгоомжлох хэрэгтэй. Тэрээр хүн төрөлхтнийг чөлөөлөхийн тулд гав гинж зүүхийг Өөрөө зөвшөөрсөн билээ. Түүний амьдрал хэдий зовлон шаналлаар дүүрэн ч гэлээ, мөн чанартаа бол ялалтын түүх юм. Бахауллагийн амьдралын тухай олж мэдсэн зүйл дээр үндэслэн Түүний туулсан зовлон, байгуулсан ялалтын талаар сургагчийнхаа тусламжтайгаар товч илтгэл бэлдэнэ үү. Доорх асуултууд танд тус болно.

- a. Бахаулла яагаад гав гинжинд дөнгөлөгдөхийг зөвшөөрсөн бэ? _____

- b. Бахаулла яагаад шоронд хоригдохыг зөвшөөрсөн бэ? _____

- c. Бахаулла яагаад зовлон шаналлын аяганаас уух болсон бэ? _____

- d. Бахаулла яагаад доромжлол амсахыг зөвшөөрсөн бэ? _____

- e. Бахаулла яагаад ийм их хэцүү бэрхийг туулсан бэ? _____

- f. Бахаулла сул дорой болохоороо л зовж зүдрэхийг зөвшөөрсөн үү? _____

- g. Бахаулла дайснуудынхаа өмнө сул дорой байгаагүй юм бол яагаад зовж зүдрэхийг зөвшөөрсөн бэ? _____

7 ДУГААР ХЭСЭГ

Алехандрагийн Санчезын гэрт хийж буй хоёр дахь айлчлал эхнийх шигээ сайхан болж байна. Санчезынхан Бахауллагийн амьдралын талаар бага зэрэг мэддэг ч Алехандрагийн илтгэлээс илүү ихийг мэдэж авч байгаадаа баяртай байгаа бөгөөд Түүнийг хэрхэн зовж зүдэрч явсныг сонсоод тэдний сэтгэлд хүрсэн нь илт байлаа. “Бурханы Тодруулагч нар эрх мэдлийн араас шунан хөөцөлдөгч нарын гарт үргэлж зовж зүдэрдэг бололтой” хэмээн хатагтай Санчез эргэцүүлэн бодов. Бахаулла, хүн

төрөлхтний сайн сайхны төлөө, биднийг дарангуйллаас ангижран мөнхийн жаргалд хүрээсэй гэсэндээ зовлон амссан тухайгаа өгүүлснийг (энэ эшлэлийг та өмнөх хэсгээс мэдэх билээ) тэдэнтэй хуваалцах цаг нь боллоо гэж Алехандра үзэв. Энэ өдрийн яриа гурван найзын сэтгэлийг ихэд хөдөлгөж байгаа аж.

Алехандра дараагийн айлчлалынхаа талаар эргэцүүлэн бодохдоо Абдул-Бахагийн тухай ярилцах нь зөв юм хэмээн үзээд дараах зүйлсийн талаар ярихаар шийдэв:

Бахауллагийн ууган Хүү, Абдул-Баха нь хүн төрөлхтний түүхэн дахь хамгийн хосгүй хүн бөгөөд Түүнтэй эн зэрэгцэх хүнийг бид өмнөх шашны алинаас ч нь олж харахгүй. Тэрээр аль хүүхэд байхын л Эцгийнхээ тэнгэрлэг байр суурийг хүлээн зөвшөөрч Түүний цөллөг, зовлон зүдүүрээс нь хуваалцаж байв. Абдул-Бахагийн анхаарал халамжийн дор Бахаулла, таалал төгссөнийхөө дараа, Бахайн нийгэмлэгийг үүрд орхисон юм. Бахаулла, Өөрийн хамгийн аугаа Үүдэл нээлт төдийгүй хорвоо дэлхийг мэргэн ухаан, эрдэм мэдлэгээрээ удирдан чиглүүлж, гэрэлтүүлэн гийгүүлэх Хүүгээ бидэнд заяаснаар хүн төрөлхтөнд ямар хязгааргүй их ивээл хайрласныг үнэлэхийн аргагүй билээ.

Бид Абдул-Бахагийн амьдрал, айлдварыг судалж мэдсэнээр энэ Эрин үед эзэлж буй өвөрмөц байр суурийнх нь талаар ойлголттой болдог. Энэ байр суурьтай холбоотой гурван чухал зүйлийг бид санаж явууштай. Нэгдүгээрт, Абдул-Баха бол Бахауллагийн Гэрээсийн Төв. Бахаулла дагалдагч нартайгаа гэрээ байгуулж, зүрх сэтгэлээ тэрхүү төв рүү чиглүүлж, түүнд үнэнч байхыг уриалсан юм. Абдул-Баха Гэрээслэлдээ, Өөрийг нь таалал төгссөний дараа бүх хүний хандах ёстой төвөөр Үйл хэргийн Асран тэтгэгч, Шоги Эффендиг томилсон билээ. Өнөөдөр энэ төв нь Бахауллагийн зарлиг хийгээд Абдул-Баха, Асран тэтгэгч нарын заавраар байгуулагдсан Шударга Ёсны Ордон юм. Гэрээс нь Бахайн нийгэмлэгийн эв нэгдлийг хангаж, хагарч бутрахаас хамгаалдаг билээ.

Хоёрдугаарт, Абдул-Баха бол Бахауллагийн сургаалыг ямагт үнэн зөв тайлбарлаж хэлдэг Тайлбарлагч билээ. Үүдэл нээлт нь өргөн уудам, Сургаалынх нь утга санаа гүн гүнзгий тул Онгод юуг нь Өөрөө хөглөж байх тайлбарлагчийг ардаа үлдээх нь зүйн хэрэг хэмээн Бахаулла үзжээ. Ийнхүү хүн төрөлхтөн Абдул-Бахагийн бичсэн олон Илгээлт бичиг, мөн Түүний айлдсан айлдваруудын эхэд буй тайлбаруудыг үзэж судлах замаар Бахауллагийн сургаалыг ойлгох боломжтой болов. Абдул-Бахагийн дараа Асран тэтгэгч Бахауллагийн сургаалын Тайлбарлагч болж, тайлбар хийх ажлыг гүйцээсэн бөгөөд Түүний Эрин цагийн үлдсэн хугацаанд Бахауллагийн сургаалыг тайлбарлах эрх хэнд ч байхгүй.

Өнгөрсөн цагийн бүх шашнууд Ариун Судар номоо өөр өөрөөр тайлбарлаж байсны улмаас хагаралд орсон юм. Тэгвэл энэ Эрин цагт Бахауллагийн

сургаалын утгын талаар эргэлзээ төрөх үед хүмүүс Абдул-Баха, Асран тэтгэгч нарын өгсөн тайлбарт ханддаг болсон билээ. Эргэлзсэн хэвээр байх аваас Даян Дэлхийн Шударга Ёсны Ордонд хандаж тодруулга авах боломжтой. Тиймээс, сургаалын утгын талаар санал зөрөлдөх шаардлага үгүй болж, Шүтлэгийн нэгдмэл байдал хадгалагдан үлдэж байгаа юм.

Гуравдугаарт, Абдул-Баха бол Эцгийнхээ Сургаалын төгс Үлгэр жишээ билээ. Бид ийм төгс төгөлдөрт хэзээ ч хүрч чадахгүй ч Түүнийг цаг ямагт сэтгэлдээ тээж, Түүнийг үлгэр дуурайл болгохыг хичээх хэрэгтэй. Хайрын тухай сургаал уншиж байхдаа бид Абдул-Бахагийн жишээг бодож үзвэл энэрэл хайр, сайхан сэтгэлийн мөн чанарыг олж харна. Цэвэр ариун байдал, шударга ёс, баяр хөөр, өгөөмөр сэтгэлийн тухай уншиж байхдаа бид Түүний амьдралыг эргэцүүлбэл энэ бүх зан чанар Түүнд хамгийн төгс хэлбэрээр цогцлон байсныг олж харна.

Абдул-Бахагийн амьдралыг онцлох зүйл бол мэдээж Түүний үйлчилгээ юм. Абдул-Баха гэдэг нэр “Бахайн зарц” гэсэн утгатай бөгөөд Тэрээр Өөрт нь хамаарах бүхий л нэр дотроос чухам энэ нэрдээ илүү дуртай байсан ажээ. Абдул-Бахагийн хэлсэн дараах үг бол Түүний үйлчлэх чин хүсэл эрмэлзлийн илэрхийлэл юм:

“Миний нэр Абдул-Баха. Миний мэргэшил бол Абдул-Баха. Миний бодит чанар бол Абдул-Баха. Миний магтуу бол Абдул-Баха. Адист Төгс жавхлангийн зарц байх минь Миний гайхамшигт гялалзсан титэм, бүх л хүн төрөлхтөнд үйлчлэх буян минь миний мөнхийн шашин... Абдул-Бахагаас өөр нэр алдар, цол өргөмжлөл, дурсамж, магтаал надад үгүй, цаашид ч үгүй байх болно. Энэ бол миний эрхэм хүсэл. Энэ бол миний агуу их тэмүүлэл. Энэ бол миний үүрдийн амьдрал. Энэ бол Миний ашид мөнхийн алдар.”¹¹

Алехандрагийн дараагийн удаа Санчезынхантай хуваалцах гэж буй зүйл бол хамгийн ер бусын хүмүүний тухай танилцуулга төдий юм; Абдул-Бахагийн энэ Эрин үед эзэлж байсан байр суурийг тэд цаашид улам ихээр хүндлэн талархах болно. Үйлчлэхүйн замаар замнахад чинь Түүний үлгэр жишээг санан дурсаж, Түүний хэлсэн үгийг эргэцүүлэн бодох боломж олон гарна. Өмнөх бүлгээр та Түүний зарим айлдварыг уншиж танилцсан бөгөөд Түүний, Илгээлт бичгүүддээ болон олон нийтэд хандаж хэлсэн үгэндээ дурдсан санаануудыг Түүний арга барилаар илэрхийлж сурахыг та бүхнээс хүссэн. Түүний байр суурийн талаарх ойлголт мэдлэгээ бэхжүүлэхийн тулд дээр дурдсан гол гол зүйлүүдийг бүлгийнхээ бусад гишүүдтэй ярилцан, чөлөөтэй илэрхийлэх дадлага хийх хэрэгтэй. Эш татсан үгийг эргэцүүлэн бодох нь үйлчлэхүйн замаар замнахад чинь урам зориг өгөх болно.

8 ДУГААР ХЭСЭГ

Алехандра Санчезын гэрт айлчилж очдог болсон цагаасаа л тэдэнд бичил хороондоо нийгэмлэг байгуулах явцад бат үнэмшилтэй, идэвхтэй оролцдог болоход нь ямар сэдвээр ярилцвал тустай байх бол хэмээн боддог болжээ. Нэг талаас мөргөл, сүнсний мөн чанар, Бурханыг тууштай хайрлах хайр зэрэг сэдвүүд бий; учир нь тэдгээр хүмүүсийн оюун санааных нь чадвар чадамжийг байнга бэхжүүлж байх хэрэгтэй. Нөгөөтээгүүр, аажмаар хөгжиж буй нийгэмлэгийн талаар төсөөлөлтэй болж, хувь нэмэр оруулах боломжтой гэдгийг мэдэх нь чухал. Санчезынхантай Абдул-Бахагийн байр суурийн талаар ярилцаж байхдаа Алехандра дараачийн уулзалтаа ямар сэдвээр хийх хэрэгтэйгээ ойлголоо. “Шүтлэгийн зорилго хүмүүсийг нэгтгэхэд оршдог гэдгийг тэд сайн мэднэ. Тиймээс одоо бид нэгдмэл нийгэмлэгийг хэрхэн бий болгож, хэрхэн авч явах тухай ярилцах нь зүйтэй.

Алехандра дөрөв дэх уулзалтаа, тухайн бичил хороонд хэдэн нөхдийн явуулж буй үйл ажиллагааны тухай ярьж эхлүүлээ. Бидний, улам олуулаа болохын хэрээр хүлээх үүрэг бол бодол санаа, үг хэл, үйлдлээрээ улам нэгдмэл байх явдал юм” гэж тэрээр тайлбарлаад “Та хоёр зөвшөөрвөл, өнөөдөр бүгдээрээ эв нэгдлийн сэдвийг судалцгаая” гэв.

“Нийгэмлэгийн маань хөгжилд эв нэгдэл ямар чухал болохыг би ойлгож байна” гэж хатагтай Санчез хэлэв.

“Бид эв нэгдлийн талаарх Бахауллагийн сургаалыг анх сонсоод л Түүний сургаалд татагдсан юм шүү дээ” гэж ноён Санчез нэмж хэлэв.

Би хэдэн санаа сонгож, тэдгээрт тохирох эшлэл олсон. Та нар дургүйцэхгүй бол, тэдгээрийг нэг нэгээр нь авч үзэцгээе” гэж Алехандра хэллээ.

Алехандрагийн бэлдсэн санаануудыг дор жагсаасан болно:

- Нийгэмлэг маань эв нэгдэлтэй байгаасай гэвэл хүн нэг бүр маргалдаж зөрөлдөхөөс зайлсхийх шаардлагатай. Энэ талаар Бахаулла ийн айлдсан байна: **“Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, маргаан, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ. Бурханы хүч, Түүний бүрэн эрхт тусламжаар эдгээрээс зайлсхийж, хүмүүсийн зүрх сэтгэлийг хооронд нь Нэгтгэгч, Бүхнийг мэдэгч, Бүхнээс мэргэн ухаантан Бурханы Алдар нэрээр нэгтгэн холбогтун.”**¹²
- Бид нийгэмлэгийнхээ хүн бүрийг хайрлах ёстой, тэр нь Бурханыг гэх бидний хайрын тусгал байх учиртай. Абдул-Баха хэлэхдээ:

“Төгс эв нэгдэлтэй бай. Бие биедээ хэзээ ч бүү уурлаж бай... Амьд бүхнийг тэдний төлөө бус, Бурханы төлөө энэрэн хайрла. Тэднийг Бурханы төлөө

хайрлах аваас та нар хэзээ ч уурлаж бухимдан, тэвчээр алдахгүй. Хүн төрөлхтөн төгс биш. Хүн алдаа дутагдал бий; хүмүүсийг өөрсдийг нь бодох аваас та нар ямагт сэтгэл дундуур явах болно. Харин Бурханыг бодох аваас тэднийг хайрлаж, тэдэнд сайхан сэтгэлээр хандах болно; учир нь Бурханы ертөнц бол төгс төгөлдөр, энэрэл нигүүлслийн ертөнц билээ.”¹³

- Бид нэг нэгнээ хайрлаад байхад л бидний хооронд хурцадмал байдал үүсэх юм бол бид Абдул-Бахагийн энэ зөвлөгөөг нэн даруй санах хэрэгтэй:

“Сэтгэл зүрхнийхээ бодол санааг хайр ивээл ба эв нэгдэлд зориулагтун хэмээн би та нарын хүн үүрэг болгож байна. Дайн дажны тухай бодол төрөх аваас түүнийг энх тайвны тухай илүү хүчтэй бодлоор эсэргүүцэгтүн. Үзэн ядах сэтгэл улам хүчтэй хайрлах сэтгэлийн дор унтрах ёстой. Дайн дажны үзэл санаа нь эв эе, сайн сайхан байдал, энх тунх ба баяр жаргалд эвдрэл сүйдэл авчирдаг болой.

Хайрлах сэтгэл нь ах дүүгийн барилдлагаа, энх тайван, эв найрамдал ба аз жаргалын эх үүсвэр юм.”¹⁴

Уур бухимдлаа барихыг хичээгээд ч түүндээ автан бусадтай зөрчилдөх юм бол бид Бахауллагийн энэ үгийг санах хэрэгтэй:

“Та нарын дунд аливаа санал зөрөлдөөн үүсэх аваас Намайг өмнөө зогсож буйгаар төсөөлж Миний нэрийг бодоод, Миний тодрон гэрэлтэх Үйл хэргийг гэх хайрынхаа төлөө бэлэг болгон нэг нэгнийхээ алдаа дутагдлыг бүү анзаар.”¹⁵

Бусдын алдаа дутагдлыг үл тоон магтууштай зан чанарт нь төвлөрч, хов жив ярихаас зайлсхийн оюун санааны хувьд сахилга баттай байх нь эв нэгдлийг сахин хамгаалах хамгийн үр дүнтэй арга юм. Бид нэг нэгнээ хайрлаж байгаа цагт хов ярихыг тэвчих амархан. Бид хайрладаг хүмүүсийнхээ алдаа дутагдлыг үл анзааран, тэднийг гэм бурууд харалган нүдээр харах нь тийм ч хэцүү биш гэдгийг санаж явах нь зүйтэй. Энэ талаар Абдул-Баха ийн хэлжээ:

“Төгс бус нүд төгс бусыг л олж хардаг. Алдаа дутагдалд харалган нүд хүмүүсийн Бүтээгчийг л олж хардаг. Тэрээр тэднийг бүтээсэн бөгөөд тэднийг сурган бүхнээр хангаж, тэдэнд ур чадвар, амь амьдрал, хараа, сонсгол заяадаг; тиймээс тэд бол Түүний аугаа байдлын шинж тэмдэг юм. Та бүхэн нэг нэгнээ хайрлан эелдэг хандаж, ядуусыг халамжилж, сул доройг хамгаалж, харанхуй мунхаг хүмүүсийг сургаж хүмүүжүүлэх учиртай.”¹⁶

Бахаулла биднийг ийн уриалжээ:

Аяа, Миний сэнтий нэгтэн! Муу муухайг бүү сонс, муу муухайг бүү үз, өөрийгөө бүү гутаа, санаа бүү алд, мэлмэрүүлж бүү уйл. Муу муухайг сонсохгүй гэвээс муу муухайг бүү яригтун, алдаа дутагдлаа нэмэхгүй гэвээс бусдын алдаа дутагдлыг хэтрүүлж бүү ярь. Өөрийн гутамшгийг дэлгэхгүйн тулд бусдад гутамшгийг бүү хүс. Хоромхон зуурын богино амьдралдаа хир толбогүй цэвэр саруул ухаантай, чин ариун сэтгэлтэй, цэгээн тунгалаг бодолтой, гэгээн цагаан бодь мөртэй явагтун. Чингэвээс эрх чөлөө, баяр баясгаланг эдлэн зуурдын эгэл биеэ орхин, шидэт диваажинд дэвшин орж, эгүүрдийн жаргалын оронд мөнх залрах болой.

Тэрээр мөн ийн айлджээ:

“Аяа, Цагаачлагчид! Намайг дурсаж байхын тулд чамд Би хэл заяасан, түүгээр гүтгэлэг чалчиж бүү бузарла. Хэрэв “би” гэсэн үзлийн гал чамайг эзэмдвэл бусдын бус өөрийн алдаа дутагдлыг сана. Учир нь та нарын хэн нь ч гэсэн бусдыг мэдэхээсээ илүү өөрийгөө сайн мэдэх буюу.”¹⁸

Эв нэгдэл гэдэг нь зөвхөн маргаж зөрчилдөхгүй байхыг хэлэхгүй, хайр сэтгэлийг зөвхөн үгээр илэрхийлээд байж болохгүй. Бидний нэг нэгнээ гэх хайр нийгмийн төлөөх үйлчилгээ болон хувирч; бид ажил үйлсээ хамтын ажиллагаа, харилцан туслалцах сэтгэлээр явуулж байгаа цагт л бид жинхэнэ эв нэгдэлтэй гэдгээ батлан харуулж чадна. Абдул-Баха биднийг ийн уриалсан билээ:

“Агшин зуур ч болов бүү амсхий, хоромхон зуур ч болов бүү тухлан суу; түүний оронд нөхөд дотроосоо нэг хүнд үнэнчээр үйлчилж, нэг зүрхийг баяр баяслаар бялхуулахын тулд чин сэтгэлээсээ хөдөлмөрлө. Энэ бол жинхэнэ буян бөгөөд үүгээр Абдул-Бахагийн магнай гэрэлтдэг билээ. Үүнд надтай хамтарч түнш минь бологтун.”¹⁹

Тэрээр мөн ингэж хэлжээ:

“Хүн төрөлхтний хамгийн эрхэм хэрэгцээ бол хамтын ажиллагаа, харилцан ойлголцол юм. Хүмүүсийн хооронд нөхөрлөл, эв нэгдлийн холбоо хэдий чинээ бат бөх байна хүний үйл ажиллагааны бүхий л салбарт бүтээлч сэтгэлгээ, ололт амжилт төдий чинээ хүчтэй байна.”²⁰

Нийгэмлэгээс явуулдаг үйл ажиллагааны амжилтын түлхүүр нь бүхий л асуудлаар илэн далангүй, халуун дулаанаар зөвлөлдөн ярилцах явдал юм. Бид зөвлөлдөх явцдаа аливаа асуудлыг шийдвэрлэх аргуудаа нэгтгэж, үйл ажиллагаандаа ямар чиглэл баримтлах ёстойгоо олж хардаг. Зөвлөлдөх явцад бид бодол санаагаараа нэгдэж; тэрхүү нэгдмэл санаа, үзэл бодлоороо нийгэмлэгээ цаашид үр дүнтэй хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж гаргадаг. Хоорондоо зөвлөлдөж ярилцдаг хүмүүсийн талаар Абдул-Баха ийн айлдсан байдаг:

“Хамтдаа зөвлөлдөн ярилцдаг хүмүүст тавигддаг гол шаардлага бол цэвэр ариун сэдэл, гал халуун сэтгэл, Бурханаас бусад бүхнээс хөндийрөх явдал, Түүний Тэнгэрлэг Анхилам үнэрт татагдах сэтгэл, Түүний хайртай хүмүүсийн дунд хүлцэнгүй, даруу номхон байх явдал, тэсвэр хатуужил, мөн Түүний Өргөмжит Босгонд үйлчлэх явдал юм. Тэдэнд эдгээр эрхэм шинж чанаруудыг олж авахад нь найрсгаар туслах аваас далд орших Баха-н Хаант улсаас тэдэнд ялалт хайрлах юм.”²¹

Нэгдмэл санаа бодлыг нэгдмэл ажил хэрэг болгохгүй л юм бол биеллээ олохгүй. Нэгдмэл байдалтай ажиллана гэдэг нь бид бүгд нэг ижил зүйл хийнэ гэсэн үг биш. Харин ч эсрэгээрээ, нэгдмэл үйл ажиллагаа нь нийгэмлэгийн гишүүдийн төрөл бүрийн авьяас чадварыг бүрэн дүүрэн дайчилдаг юм. Бид хэдий цөөхүүлээ ч улам хүчтэй болж дэлхийн хамгийн том, хамгийн хүчирхэг байгууллагуудын хүрч үл чадаагүй тэр өндөрлөгт хүрч чадна.

“Ариун сүнснүүд тэнгэрлэг хүчинд тулгуурлан, оюун санааны эдгээр чанаруудыг өөртөө агуулан босож, хөл нийлүүлэн эгнээ эгнээгээрээ жагсах бүрд тэдгээр сүнс нэг бүр мянган сүнс лугаа адил байж, тэр хүчирхэг далайн бургилах давлагаа Хурмастын чуулган лугаа адил байх юм.”²²

Дээрх агуулгыг анхааралтай уншиж, бүлгийнхэнтэйгээ нэг бүрчлэн ярилцсанахаа дараа энэ сэдвийг, өмнөх гурван сэдвийн адилаар, чөлөөтэй танилцуулах дадлага хийхэд нэг нэгэндээ туслаарай. Доорх дасгалууд дадлага хийхэд тань тус болно.

1. Дараах өгүүлбэрүүдийг гүйцээнэ үү:

- a. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд _____ тэмцэл, маргаан, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.
- b. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, _____, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.
- c. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, маргаан, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах _____.
- d. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, маргаан, хүйтэн цэвдэг, _____ гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.

- e. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, _____, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.
- f. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, маргаан, _____ хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.
- g. Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, маргаан, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү _____ хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.

2. Хоёр дахь эшлэлд Абдул-Баха бидэнд ийн хэлсэн:

- a. Бид төгс _____ амьдрах ёстой.
- b. Бид _____ хэзээ ч _____ ёсгүй.
- c. Бид бүх хүмүүсийг тэдний төлөө бус, _____ энэрэн хайрлах учиртай.
- d. Тэднийг Бурханы төлөө хайрлах аваас бид хэзээ _____ эсвэл _____
- e. Хүн төрөлхтөн _____ биш.
- f. Бид _____ нь бодох аваас бид ямагт _____ явах болно.
- g. Харин _____ бодох аваас бид хүмүүсийг _____, тэдэнд _____

3. Гурав дахь эшлэлд Абдул-Баха бидэнд хэлсэн үг бол:

- a. Бид сэтгэл зүрхнийхээ бодол санааг _____ ба эв нэгдэлд зориулах ёстой.
- b. Дайн дажны тухай бодол төрөх аваас бид түүнийг _____ эсэргүүцэх ёстой.
- c. Үзэн ядах сэтгэлийг _____ унтрааж болно.

- d. Дайн дажны үзэл санаа нь _____, _____,
_____ ба _____ эвдрэл сүйдэл авчирдаг
болой.
- e. Хайрлах сэтгэл нь _____, _____,
_____ ба _____ эх үүсвэр юм.
4. Та болон нийгэмлэгийн бусад хүмүүсийн хооронд санал зөрөлдөөн бий болж
буйг хараад та юу хийх ёстой вэ? _____

5. Танай нийгэмлэгийг эв нэгдэлд эергээр нөлөөлдөг оюун санааны сахилга
батын талаар тайлбарлана уу: _____

6. Эдгээрийн аль нь эв нэгдэлд ээлтэй вэ?
____ Бусдын алдаа дутагдлыг олж харах
____ Бусдын алдаа дутагдлыг үл хэрэгсэх
____ Хэн нэгэн хүний алдаа дутагдлын талаар найздаа ярих
____ Хэн нэгнийг муухай харагдуулахын тулд болсон явдлыг
мушгин гуйвуулж эсвэл дэвэргэж ярих
____ Бусдын алдаа дутагдлын талаар бодож явах
7. Бид яагаад зарим хүнийг алдаа гаргасных нь төлөө шүүмжилдэг байж, өөр хүн
яг ижилхэн алдаа гаргахад нь дуугүй өнгөрдөг вэ? _____

8. Хүмүүс нэг нэгнээ араар нь муулж ярьдаг нөхцөлд эв нэгдэлтэй байх
боломжтой юу? Яагаад үгүй гэж? _____

9. Хэн нэгний талаар худал ярих нь мэдээж буруу. Тэгвэл хүнийг хийсэн зүйлийнх нь төлөө шүүмжилж болох уу? _____

10. Хов ярих, бусдыг араар нь ярих, бусдыг шүүмжлэх нь хоорондоо ямар ялгаатай вэ? _____

11. Хов жив хөөцөлдөх, бусдыг муулах, байнга шүүмжлэх нь нийгэмлэгт ямар нөлөөтэй вэ? _____

12. Эдгээр зуршлаас бид хэрхэн салж болох вэ? _____

13. Бид хүмүүсийн талаар, тэднийг яг хажууд байгаа юм шиг бодож ярьвал юу болох вэ? _____

14. Хүүхдүүдийн өмнө бусдыг муулж ярих нь тэдэнд ямар нөлөө үзүүлэх вэ? _____

15. Хов жив хөөцөлдөж, бусдыг муулах хандлага хаанаас үүдэлтэй вэ? _____

16. Бахаулла бидэнд хэлэхдээ: “Хэрэв “би” гэсэн үзлийн гал чамайг эзэмдвэл _____ бус _____. Учир нь та нарын хэн нь ч гэсэн _____ илүү _____ мэдэх буюу” гэсэн билээ.
17. Хайрыг зөвхөн үгээр илэрхийлдэггүй. Тэгвэл өөр юу хэрэгтэй вэ? _____

18. Эв нэгдэл, хайрын тухайд Абдул-Баха биднийг ийн уриалсан билээ: “Агшин зуур ч болов бүү _____, хоромхон зуур ч болов бүү _____, түүний оронд нөхөд дотроосоо нэг хүнд _____, нэг зүрхийг _____ төлөө _____.
19. Мөн Тэрээр: “Хүн төрөлхтний хамгийн эрхэм хэрэгцээ бол _____ болон _____ юм. Хүмүүсийн хооронд _____, _____ холбоо хэдий чинээ бат бөх байна хүний үйл ажиллагааны бүхий л салбарт _____, _____ төдий чинээ хүчтэй байна” гэж хэлсэн билээ.
20. Нийгэмлэгийн үйл ажиллагааны амжилтын гол түлхүүр нь юу вэ? _____

21. Зөвлөлдөж ярилцдаг хүмүүсийн талаар Абдул-Баха: “Хамтдаа зөвлөлдөн ярилцдаг хүмүүст тавигддаг гол шаардлага бол _____, _____, _____, Түүний хайртай хүмүүсийн дунд _____, _____, мөн Түүний Өргөмжит Босгонд _____ юм. Тэдэнд эдгээр эрхэм шинж чанаруудыг олж авахад нь найрсгаар туслах аваас Баха-н Хаант улсаас тэдэнд _____ юм.” хэмээн айлдсан билээ.
22. Эв нэгдлийн хүчний талаар Абдул-Баха бидэнд: “Ариун сүнснүүд _____ тулгуурлан, _____ өөртөө

агуулан босож, _____ эгнээ эгнээгээрээ жагсах тэдгээр сүнс
нэг бүр _____ лугаа адил байж, тэр хүчирхэг далайн
бургилах давалгаа _____-ны _____ лугаа
адил байх юм.” хэмээн айлдсан билээ.

9 ДҮГЭЭР ХЭСЭГ

Санчезынхны гэрт дөрөв дэх удаагаа зочлохдоо Алехандра, тэднийхээс холгүй орших нэгэн ахлах сургуульд суралцах хугацаандаа өвөө эмээгийнхээ амьдрахаар ирээд буй ач охин Беатристай нь танилцсандаа баяртай байлаа. Беатрис эв нэгдлийн сэдвийг сонирхон тэдний ярианд идэвхтэй оролцоно. Яриа дуусах алдад хатагтай Санчез амтат бялуу, кофегоор бүгдийг дайлав. Энэ үед Алехандра Беатристай илүү сайн танилцан, түүнтэй маргааш өдөр уулзаж бичил хороонд нь өрнөж буй нийгэмлэг бүтээн босгох ажлын талаар ярилцахаар тохиролцов. Алехандра “Энэ охин үндсэн цуврал сургалтыг сонирхох байх. Би түүнд эхний номыг үзэж судлахад нь тусалж болох юм. Дараа нь тэр хүүхдийн хичээл эхлүүлэх эсвэл энэ бичил хороонд өсвөр насныхны бүлэг байгуулахад минь тусалж магад. Охин, өөрийг нь удирдагч болоход нь бэлдэх тавдугаар номыг ахиулан судлахын хэрээр өсвөр насныхны бүлгийг бага багаар хариуцдаг болж болох юм” хэмээн дотроо бодлоо. Алехандра залуучуудад зориулсан хэд хэдэн уулзалтад оролцож байсан билээ. Тодорхой дараалсан сэдвээр зохиогдсон эдгээр уулзалтын үр дүнд олон залуус институтийн үйл явцад оролцдог болсон юм. Алехандра Беатристай уулзаж ярилцахдаа санаануудаа чухам энэ дарааллаар танилцуулахаар болов. Тэдний яриа ийн эхлэх юм:

Бид бүгдээрээ дэлхийг илүү сайн сайхан болоосой хэмээн хүсэж явдаг. Бүх нийтийн энх тайван тогтож, хүн төрөлхтөн эвтэй найртай амьдрах ирээдүйг бид тэсэн ядан хүлээж байна. Тийм ирээдүй мөрөөдөл төдий биш. Тийм ирээдүйг, улам олон хүн дэлхий ертөнцийн сайн сайхны төлөө оруулахаар хүчин чармайлт гаргахын хэрээр цогцлоох бүрэн боломжтой. Зүрх сэтгэлийнхээ гүнд бид бүгдээрээ нийгэмдээ үйлчлэхийг хүсдэг. Бидэнд юу хэрэгтэй вэ гэвэл нийгмийн сайн сайхны төлөө амь биеэ хайрлахгүй үйлчлэх чадвараа хөгжүүлэх явдал юм.

Хүн төрөлхтний төлөөх үйлчилгээг бодохдоо бид хамтдаа туулж буй үйлчлэхүйн замыг төсөөлж болох юм. Энэ зам бүх хүнд нээлттэй. Бид өөрсдийн сонголтоор энэ замд хөл тавьж, өөр өөрийн хурдаар урагшилдаг. Энэ замыг бид ганцаараа туулдаггүй; бид нөхөдтэйгөө мөр зэрэгцэн үйлчилж, хамтдаа суралцаж, нэг нэгэндээ хань болж явдаг. Бидний хийсэн алхам бүр баяр хөөр, өөртөө итгэх итгэлийг дагуулж, бидний гаргасан хүчин чармайлт бүр тэнгэрээс баталгааждаг.

Беатрист сонссон бүхэн нь таалагдаж, танилцуулгын дараа идэвхтэй яриа өрнөв. Энд түр зогсон хоёр андын хооронд өрнөж буй яриаг эргэцүүлэн бодоцгооё. Алехандра, Беатрисыг институтийн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор түүнтэй нухацтай ярилцахаар шийдэв. Институтээс цуврал сургалт явуулж буйг дуулгаад, тэрхүү сургалтад Беатрисыг зүгээр л урих нь яагаад хангалтгүй байх байсан бэ?

10 ДУГААР ХЭСЭГ

Алехандра, Беатрис хоёрын яриа хоёр цаг орчим үргэлжилж байна. Алехандрагийн шинэ андтайгаа хуваалцах нэмэлт санааг доор толилуулав. Тэр зогсолтгүй яриагүй гэдэг нь мэдээж. Тэд ихэнх цагаа доорх догол мөрүүдэд дурдсан санааг хэлэлцэж өнгөрүүлэв.

Бид залуу, бид эрч хүчтэй, бид урам зоригтой. Хүмүүс биднийг огт бодох, санах юмгүй гэж боддог. Гэтэл бид эсрэгээрээ, хүн төрөлхтөн хүнд байдалд ороод байгаад санаа зовж, нийгэмд дорвитой өөрчлөлт гараасай хэмээн хүсдэг. Бид бас өөрсдийн амьдралын тухай буюу боловсрол, ажил төрөл, найз нөхөд, гэр бүлийн тухай бодох хэрэгтэй. Бид том болохын хэрээр улам их хариуцлага үүрдэг болж; эцэг эхчүүд маань биднээс улам ихийг хүлээдэг. Заримдаа би олон үүрэг хариуцлагынхаа талаар бодохоос л сэтгэлээр унах шиг болдог. Тэр үед би Бахауллагийн сургаалаас цээжилсэн нэгэн эшлэлийг санахыг хичээдэг: “Хүний амьдралд өөрийн гэсэн хавар цаг байдаг бөгөөд тэр нь гайхамшигтай сүр жавхаагаар дүүрэн. Залуу нас бол хүч чадал, эрч хүчээр онцлог бөгөөд хүмүүний амьдралын хамгийн сайхан цаг гэгддэг билээ.”

Миний чамтай хуваалцмаар байгаа зүйл гэвэл дэлхийн өнцөг булан, манайх шиг нийгэмлэгүүдэд олон залуус эрч хүч, оюун ухаан ба оюун санаагаа хөгжүүлж, нийгмийг өөрчлөхөд хувь нэмэр оруулах хоёр талт зорилгод чиглүүлэх боломжтой гэдгийг мэддэг. Уг зорилгын хоёр хэсэг хоорондоо холбоотой. Бид ур чадваруудаа хөгжүүлснээр бусдад улам үр дүнтэй үйлчилж, нэг нэгэндээ

тусалж дэмжсэнээр бид хувь хүнийхээ хувьд өсөж, өөрт буй зан чанаруудыг улам бэхжүүлдэг юм.

Миний дээр дурдаад өнгөрсөн үйлчлэхүйн замын тухай санаа чухам энд л орж ирж байгаа юм. Энэ замыг туулах нь бидний, амьдралдаа зүгээр л нэмчих зүйл биш; энэ нь бидний хийдэг бүхий л зүйлийг утга учиртай болгож өгдөг. Нийгэмлэгтээ үйлчлэх нь бидэнд боловсролынхоо зорилгыг илүү ухаарч, ирээдүйн талаарх бодлоо цэгцэлж, гэр бүлийнхээ сайн сайханд хувь нэмэр оруулахад шаардлагатай зан чанаруудаа хөгжүүлэхэд тус дөхөм болдог. Түүнчлэн бидний үерхэл нөхөрлөлийг бэхжүүлэхийн зэрэгцээ биднийг эрч хүчээ өчүүхэн зүйлсэд дэмий үрэхээс сэргийлдэг.

Бид оюун санааны болон оюун ухааныхаа хөгжлийн талаар бодож байхдаа, бидэнд маш олон хүч нөлөөлж байдгийг мартах ёсгүй. Мэдлэг, шударга ёс ба хайрын хүч гэх мэт тэдний зарим нь биднийг зөв тийш чиглүүлдэг тул бид тэдгээр хүчтэй нийцэж сурах хэрэгтэй. Материаллаг үзэл, аминч үзлийн хүч гэх мэтээс эсрэг зүйл хийж, тэдгээр хүчийг эсэргүүцэж байх ёстой. Бид аливаад төгс төгөлдөр байхын төлөө хичээж, бидний хичээл зүтгэл тэнгэрлэг баталгаа адислагдана гэдэгт итгэл төгс байх ёстой.

Хүчирхийлэл, ядуурал, зовлон зүдүүрт ертөнцийг энх тунх, элбэг дэлбэг, эвтэй найртай ертөнц болгон хувиргах гээд нийгмийг хувьсган өөрчлөхөд оруулах өөрийн хувь нэмрийн тухай бодохдоо бид материаллаг төдийгүй оюун санааны хөгжил дэвшлийг бодолцох хэрэгтэй. Бид оюун санааны хувьд ахиц дэвшил гаргахгүй л бол материаллаг хөгжилд бүх нийтээрээ хүрэх боломжгүй. Энэ хоёр зэрэгцэн явж байж л дэлхий илүү сайн сайхан болно. Миний цээжилсэн өөр нэгэн эшлэл бол: “Материаллаг соёл иргэншил дэнлүү лугаа байдаг бол оюун санааны соёл иргэншил тэрхүү дэнлүүний гэрэл лугаа адил. Материаллаг болон оюун санааны соёл иргэншил нэг болох аваас бидэнд гэрэл, дэнлүү хоёулаа байх бөгөөд үр дүн нь төгс болох юм.”

Бид үйлчлэхүйн замаар алхаж явахдаа олон хүнтэй ажиллаж сурдаг; ялангуяа хүүхдүүд болон өсвөр насныхантай ажиллаж тэдэнд мэдлэг, ур чадвар, оюун санааны зарим зан чанараа хөгжүүлэхэд нь тусалдаг. Бид бас нийгэмлэгийнхээ эв нэгдэлд анхаарлаа хандуулж сурдаг. Нийгэмлэгийн хөгжилд хувь нэмрээ оруулах хүсэлтэй хувь хүн, гэр бүл болон албан байгууллагууд хамтарч ажиллах хэрэгтэй. Тэд хамтын алсын хараа, зорилгыг бий болгож, аливаа зөрчилдөөнийг ардаа орхих хэрэгтэй.

Тиймээс бид залуугаасаа бусадтай эвтэй харьцах чадварт суралцах нь чухал. Бид найз нөхөд болцгоож, нэг нэгэндээ хийж буй ажилд нь тус болж, оруулсан хувь нэмрийг хүлээн авч, урамшуулан дэмжиж, давуу талуудыг нь олж харж,

харилцан зөвлөгөө өгч, гаргасан амжилтанд нь баярлаж байх хэрэгтэй. Үйлчилгээийн замаар замнахдаа бид хамтдаа ажиллаж, үйлдлээ эргэцүүлэн бодож, зөвлөлдөн ярилцаж, суралцах ёстой.

Өнгөрсөн хэдэн арван жилийн хугацаанд Бахайн нийгэмлэг нь дэлхийн бараг бүх улс оронд нэгэн өвөрмөц сургалтын байгууллага үүсгэн байгуулах явдалд амжилт гаргаад байгаа билээ. Институт гэгддэг эдгээр байгууллага нь бидний нийгэмлэгт үйлчлэх чадавхыг бэхжүүлэх зорилготой цуврал сургалтыг зохион явуулдаг юм. Эдгээр сургалтын материалыг үзэж судалснаар бид үйлчлэхүйн замаар урагшлахад шаардагдах оюун санааны ойлголт болон практик чадварыг олж авдаг. Эдгээр сургалтын материалыг ахиулан судлахын хэрээр бидний илүү нарийн цогц даалгавар гүйцэтгэх чадвар дээшилдэг. Энэ хугацаанд биднийг, биднээс илүү туршлагатай хүмүүс дагалдан халамжилдаг бөгөөд яваандаа бид ч бас туршлага нимгэн нөхдөө дагалдан халамжилж эхэлдэг юм. Бид анхнаасаа л өөрийн боловсрол болон нийгэмлэгийн төлөөх үйлчилгээг хариуцан авч, хувь хүний болон нийгмийн өөрчлөлтийг түүчээлдэг юм.

Түүчээ байна гэдэг нь аливааг бодлоготойгоор хийх, хичээл зүтгэл гаргах, алхам тутамдаа мэдлэг олж авч, нэвтрүүлэх хүсэлтэй байхыг хэлнэ. Түүчээ нь ашиг тусыг идэвхгүй хүлээн авагч биш, харин ахиц дэвшилд идэвхтэй хувь нэмэр оруулагч юм. Түүчээ байхын тулд аливаа санаачилгыг бүтээлчээр бөгөөд сахилга баттайгаар гаргаж сурах хэрэгтэй. Институтийн сургалтууд бидэнд нийгэмлэгийг бүтээн босгох үйл явцыг түүчээлэх чадавхаа бэхжүүлэхэд тус дөхөм болдог.

Дээрх санаануудыг эргэцүүлэн бодоход хэдэн хором гаргах хэрэгтэй. Энэ хэсгийн эхэнд дурдсанчлан, Алехандра санаануудаа ар араас нь танилцуулаад орхих биш, харин Беатрист тэдгээрийг тунгаан бодож, ярианд идэвхтэй оролцох хангалттай боломж олгох тал дээр анхаарах юм. Догол мөр бүрийг бүлгээрээ хэлэлцэж, санаагаа илэрхийлж сурсныхаа дараа та ярилцлага, Алехандра Беатрист Рухи институтын зарим сургалтын талаар мэдээлэл өгч, түүнийг нэгдүгээр номыг судлахаар урих хэмжээнд хүрсэн эсэх талаар бодож үзээрэй. Та Алехандрагийн оронд байсан бол юу хэлэх байснаа доорх зайнд бичнэ үү. Та нэг, хоёрдугаар ном болон тэдгээрийн хүрээнд хийх шаардлагатай үйлчилгээг яаж тайлбарлах вэ? Дараа дараагийн номд гардаг үйлчилгээ буюу хүүхэд, залуучуудад оюун санааны боловсрол олгох сургалт явуулах, өсвөр насныхны бүлгийг удирдагчын хувьд удирдан чиглүүлэх зэрэг үйлчилгээний тухай товч мэдээлэл өгөх нь Беатрист, ирээдүйд тэр ямар үйлчилгээ хийж болох талаар төсөөлөлтэй болоход нь туслах нь гарцаагүй. Алехандра Беатрисыг нэгдүгээр номыг судлахаар урихдаа хэдэн үг нэмж хэлэхтэй адил танай бүлгийн сургагч, энэ хоёр үйлчилгээний талаар хэдэн өгүүлбэр бичихэд тань тусална.

This image shows a blank sheet of white paper with horizontal blue or grey ruling lines, typical of notebook paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

12 ДУГААР ХЭСЭГ

Алехандрагийн Санчезынхны гэрт хийх цуврал айлчлал хэдэн долоо хоногийн турш үргэлжилж байгаа аж. Мөргөлийн ач холбогдлын талаар ярилцах явцад урган гарсан хэд хэдэн сэдэв болох сүнсний амьдрал, оюун санааны зан чанарын төлөвшил, Бурханы хууль болон айлдваруудыг дагаж мөрдөх явдал, Түүнийг гэх хайрандаа тууштай байх талаар ярилцах боломж тэдэнд гарлаа. Нэг удаа тэд Засаг Захиргааны Журмын институтууд, тэр дундаа Орон Нутгийн болон Үндэсний Оюун Санааны Чуулгуудын талаар бага зэрэг ярилцлаа. Дараа дараагийн уулзалтын агуулгыг авч үзэх шаардлага үгүй. Бидний төсөөлж байгаа шиг цуврал уулзалтад оролцож буй хүмүүст байнга төрдөг хоёр асуулт бий. Эхнийх нь нийгэмлэгээс зохион байгуулдаг уулзалт цуглааны онцлог, хоёр дахь нь санхүүгийн эх үүсвэртэй холбоотой юм. Бид уулзалт цуглаан тодруулбал 19 Хоногийн Баярын сэдвийг энэ хэсэгт, санхүүтэй холбоотой сэдвийг дараачийн хэсэгт тус тус авч үзэх болно.

19 Хоногийн Баярын талаарх ярилцлага дараах санаанууд дээр тулгуурлах боломжтой.

- Бахайн нийгэмлэгт аливаа цуглааныг мөргөл үйлдэх, суралцах, тусгай өдрүүдийг тэмдэглэх, нийгэмлэгийн үйл ажиллагаа болон нийгэмд чиглэсэн үйлчилгээний талаар зөвлөлдөх, хийх ажлынхаа төлөвлөгөөг хэлэлцэх гээд янз янзын зорилгоор зохион байгуулдаг юм. Бахаулла дараах амлалтыг өгсөн байдаг:

“Амь амьдрал, Үйл хэргээ барин өчсүү! Бурханы анд нөхөд цуглан, Эзэн тэнгэрээ магтан мандуулсан дуу хоолойгоо цуурайтуулж буй тэр гэр орныг хүрээлэн үнэнч сүсэгтнүүд хийгээд адист сахиулсан тэнгэрүүдийн сүнс тойрон эргэлдэх болой.”²³

- Бурханы Үгийг нөхөдтэйгөө хамт сонсох нь зүрх сэтгэлийг баяр хөөрөөр бялхуулж, эв нэгдлийн улам бэхжүүлдэг. Бахаулла бидэнд хандан ийн уриалсан байдаг:

“Анд нөхөд аль ч нутаг оронд байсан хамтдаа цугларч цэцэн мэргэн, уран яруу үг хэлээр ярьж, Бурханы айлдваруудаас уншиж байвал зохилтой; учир нь хайрын галыг асаан бадраадаг нь Бурханы Үгс билээ.”²⁴

Абдул-Баха ийн бичсэн байдаг:

“Тухайн улс орон үнэний гэрлээр гэрэлтэж, тухайн газар нутаг Ариун Сүнсний баталгаагаар тансаг диваажин болон хувирч болзошгүй тул хуран цуглаж тэнгэрлэг Сургаалаас уншиж, уянгалуулан дууд. Учир нь, энэ цаг үе бол Бүхий л Алдар Нэрсийн Эзний эрин зуун бөгөөд хүмүүний ертөнцийн эв нэгдлийн эгшиг Өрнө, Дорно дахины сонорыг мялааж байна.”²⁵

- Бахайн бүх уулзалт дотроос 19 Хоногийн Баярыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Бахайн хуанли нь тус бүр арван есөн хоногтой арван есөн сараас бүрддэг бөгөөд газар Бахайчууд, Бахауллагийн зарлигдсан ёсоор сард нэг удаа цуглардаг билээ:

“Дан усаар дайлах байсан ч, сард нэг удаа баяр хий хэмээн та нарт зарлигдсан. Учир нь Бурхан хорвоогийн болон тэнгэрийн аль аль аргаар хүмүүсийн зүрх сэтгэлийг холбохыг зорьсон билээ.”²⁶

- 19 Хоногийн Баяр гурван хэсэгтэй. Эхнийх нь мөргөлийн хэсэг бөгөөд энэ хэсэгт хүмүүс мөргөл үйлдэн Ариун Сургаалын хэсгүүдээс уншдаг. Хоёр дахь хэсэг бол нийгэмлэгийн үйл ажиллагааны талаар ярилцаж зөвлөлдөх хэсэг юм. Гурав дахь нь чөлөөт хэсэг.

- 19 Хоногийн Баярын мөргөлийн хэсэг ямар ач холбогдолтойг Абдул-Бахагийн дараах айлдвараас мэдэх билээ:
- **“Өнө эртний Гоо Үзэсгэлэнгийн үнэнч зарц нар аа! Аль ч үед, аль ч эрин цагт шашны баярыг дурлан таашааж, Бурханы хайрт шавь нарт зориулж ширээ засахыг магтууштай хэрэгт тооцдог байсан билээ. Энэ нь шашны баярыг ихэд тэмдэглэдэг болсон өнөө цагт, хамгийн өгөөмөр зуунд, юутай ч зүйрлэшгүй энэ эрин цагт бүр ч хамаатай. Учир нь шашны баяр Бурханд сүсэглэн мөргөж, Түүнийг алдаршуулан дуулах цугларалтын тоонд зүй ёсоор ордог бөгөөд энд ариун мөртүүд, тэнгэрлэг яруу найраглал, магтаал эгшиглэх бөгөөд сэтгэл догдлон тогтож үл чадна.”²⁷**
- Баярын зөвлөлдөх хэсэгт, баярт хүрэлцэн ирсэн анд нөхөд хол ойрын Бахайн нийгэмлэгүүдийн үйл ажиллагааны тайланг сонсож, нийгэмлэгийнхээ хэрэг явдал болон нийгмийн сайн сайханд оруулсан хувь нэмрийнхээ талаар зөвлөлдөж, Даян Дэлхийн Шударга Ёсны Ордноос хүлээн авсан удирдамжийг уншиж танилцан, төлөвлөгөөнд нь гарсан ахицын талаар эргэцүүлэн бодож, Шүтлэгийн Инститүүцүүдэд хандаж санал хүсэлтээ тавьдаг. 19 Хоногийн Баярын үеэр өрнөдөг зөвлөлдөөнүүд нэн чухал, учир нь тэдгээрийн ачаар хүн нэг бүр дэлхийн Бахайн нийгэмлэгийн хэрэг явдалд оролцох боломжтой юм.
- Баярын чөлөөт хэсгийн тухайд гэвэл энэ бол хүмүүс хоорондоо нөхөрлөн, хүндлэн дайлах цаг. Энэ үеэр дуу хөгжим тавьж, сэтгэл хөдөлгөм яриа өрнүүлж, хүүхдүүд ямар нэгэн үзүүлбэр үзүүлж болдог. Товчхондоо, сайтар бодож сонгосон, хүмүүст хүндлэл баярыг зэрэг төрүүлэхүйц соёлын илэрхийллээр 19 Хоногийн Баярын энэ хэсгийг баяжуулж болдог.
- 19 Хоногийн Баяр бол Бахайн Засаг захиргааны Журмын нэн чухал онцлог чанар юм. Энэ нь мөргөлийн, захиргааны (зөвлөлдөх) болон нийгмийн гээд нийгэмлэгийн амьдралын бүхий л талыг өөртөө нэгтгэж өгдөг. Эдгээрийг энэ тэнцүү онцлон тэмдэглэх нь зүйтэй; учир нь 19 Хоногийн Баяр амжилттай болох эсэх нь энэ гурван бүрэлдэхүүн хэсгийн тэнцвэрт байдлаас хамаардаг юм. 1989 оны 8-р сард бичсэн захидалдаа Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон ийн хэлсэн байдаг:
- **“Бахаулагийн Дэлхийн Энх Журам хүмүүний нийгмийн бүхий л нэгжийг хамардаг; амьдралын оюун санаа, захиргаа болон нийгмийн үйл явцыг нэгтгэдэг; хүмүүний бүхий л хэлбэрийн илэрхийллийг шинэ соёл иргэншил цогцлооход чиглүүлж өгдөг юм. 19 Хоногийн Баяр энэ бүх талыг нийгмийн бүр үндэс сууриас нь хамардаг. Хөдөө тосгон, хот сууринд болдог энэ баяр бол Бахайн нийт гишүүд нь болсон институт юм. Энэ нь эв нэгдлийг хөхиүлэн дэмжиж, ахиц дэвшил гарах явдлыг хангах, баяр баясгалант дэмжин тэтгэх зорилготой юм.”²⁸**
- 19 Хоногийн Баяр шиг ийм чухал үйл явдлыг яаран сандран зохион байгуулж болдоггүй. Хүн бүр мөргөл уншиж эргэцүүлэн бодох замаар Баярт өөрийгөө

оюун санааны хувьд бэлдэж, арга хэмжээнд бие сэтгэлээрээ оролцох ёстой. Мөргөлийн хэсэгт Бахайн сургаалаас өөрөө уншсан ч эсвэл бусдын уншихыг сонссон ч; тайлан тавьсан ч, удирдамж авсан ч, эсвэл санал бодлоо хуваалцсан ч; баярыг өөрөө хөтөлсөн ч эсвэл хөтлөгчийн найрсаг занг баяр хөөртэйгөөр хүлээн авсан ч тэр. 19 Хоногийн Баярын тухай захидалдаа Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон:

“Баярын бэлтгэл ажлын чухал хэсэгт сургаал, эшлэлүүд болон удирдамжийг нарийн сонгох, яруу сайхан уншдаг хүмүүсийг урьдчилан томилох, мөргөлийн хэсгийг танилцуулах болон эхлүүлэхдээ зохистой байдлыг дагах зэрэг ордог. Гадаа ч бай дотор ч бай баяр зохион байгуулах орчныг анхаарах нь арга хэмжээнд ихээхэн нөлөөлдөг. Цэвэр цэмцгэр байдал, орон зайг тохитой бөгөөд гоёмсог байдлаар засах явдал гээд бүхий л зүйл чухал үүрэг гүйцэтгэдэг. Цаг баримтлах нь бэлтгэл сайн хангагдсаны шинж юм.

“Баяр амжилттай болох нь тухайн хүний хувийн бэлтгэл болон оролцооноос ихээхэн шалтгаалдаг билээ. Хайрт Багш дараах зөвлөгөөг хүргэж байна: “19 Хоногийн Баярыг томоохон ач холбогдол өгч байгтун. Ингэснээр энэ өдрүүдэд Их Эзний хайрт шавь нар болон Нигүүлсэнгүй Бурханы шивэгчид Хаант улс өөд нүүр царайгаа хандуулж, мөргөл залбирлыг уянгалуулан дуудаж, Бурханаас тусламж гуйж, нэг нэгнээ хайрлан хүндэлж, мөн сэтгэлээр цэвэршин ариусах, Бурханаас айж эмээх, дур хүсэл болон өөрийгөө гэх үзлээ тэвчих нь улам бүр нэмэгдэх билээ. Ингэснээр тэд энэ тоост орчлонгоос хөндийрч, сүнсний гал цогт шумбан орно.”²⁹

Урьдын адилаар, дээр гарсан санаануудыг чөлөөтэй илэрхийлж сурахын тулд хэд хэдэн удаа уншиж бүлгээрээ хэлэлцэнэ үү. Доорх дасгалууд танд 19 Хоногийн Баярын ач холбогдлыг илүү сайн ойлгоход туслах болно:

1. Бурханыг магтан дуулахаар бидний цуглардаг орон байр болгоныг юу тодорхойлдог гэж Бахаулла бидэнд айлдсан бэ? _____

2. Хоёр дахь эшлэлд Бахаулла бидэнд айлдсанаар бид хамтдаа цугларч _____, _____ үг хэлээр ярьж,
_____ уншиж байвал зохилтой; учир нь _____
_____ нь Бурханы Үгс билээ.

3. Гурав дахь эшлэлд Абдул-Баха биднийг хуран цугларч тэнгэрлэг Сургаалаас уншиж, уянгалуулан дууд хэмээн зөвлөсөн. Чингэвээс:

- бидний амьдарч буй улс орон _____,

- бидний оршин суудаг газар нутаг _____

4. Бахайн хуанли хэдэн сартай вэ? _____

5. Сар бүр хэдэн хоногтой вэ? _____

6. Бахайн ямар цугларалт сард нэг удаа болдог вэ? _____

7. 19 Хоногийн Баярын гурван хэсгийг нэрлэнэ үү? _____

8. 19 Хоногийн Баярын эдгээр хэсгүүд ямар нэгэн дараалалтай юу? _____

9. Баярын мөргөлийн хэсэг ямар зорилготой вэ? _____

10. Баярын зөвлөлдөх хэсгийн зорилго юунд оршдог вэ? _____

11. Баярын чөлөөт хэсэг ямар зорилготой вэ? _____

12. Доорх сэдвүүдээс аль нь Баярын зөвлөлдөх хэсгээр хэлэлцэхэд тохиромжтой вэ?

___ Нийгэмлэгээс явуулж буй үйл ажиллагаанд шаардлагатай санхүү мөнгө

___ Үндэсний хөл бөмбөгийн багийн оноо

___ Нийгэмлэгийн хоёр гишүүний хоорондын маргааныг хэрхэн шийдвэрлэх вэ

___ Нийгэмлэгт зохиогдож буй Бахайн хүүхдийн хичээлийн ахиц

___ Нийгэмлэгийн нэгэн гишүүний долоо хоногийн эхэнд уншиж судалсан эшлэлийн утга

___ Нийгэмлэгт хэрэгжиж буй залуусын хөтөлбөрийн эрч хүч

___ Тухайн газар залууст нээлттэй байгаа ажлын байр

___ Хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэг бүхий үйлчлэх төсөл хэрэгжүүлж буй өсвөр насныханд нийгмийн зүгээс үзүүлэх боломжтой дэмжлэг туслалцаа

___ Байгууллагаас хэрэгжүүлж буй боловсролын хөтөлбөрийн хүүхдүүд болон өсвөр насныхны эцэг эхтэй очиж уулзах

___ Нийгэмлэгийн мөргөн сүсэглэх явдлыг бэхжүүлэх нь

___ Телевизээр цацагдаж буй шоу нэвтрүүлгүүдийн цагийн хуваарь

___ Сургалтын дугуйланд баяр хөөртэй, сахилга баттай уур амьсгал бүрдүүлэх талаар олж авсан ойлголт

___ Удахгүй тохиох Ариун Өдрийг тэмдэглэх нь

___ Нийгэмлэгийг бүтээн байгуулах үйл явцаас урган гарах нийгэмд чиглэсэн санаачилга

13. 19 Хоногийн Баярын гурван бүрэлдэхүүн хэсгийн тэнцвэртэй байдал яагаад тийм чухал юм бэ? гэдэг асуултыг бүлгээрээ хэлэлцэнэ үү.

14. Харин одоо дараах хоёр асуудлаар ярилцана уу

a. Та 19 Хоногийн Баярыг хөтлөх явуулах байсан бол бэлтгэлээ яаж базаах байсан бэ?

b. Та баярт зүгээр оролцох тохиолдолд баярт яаж бэлдэх вэ?

13 ДУГААР ХЭСЭГ

Шүтлэгийн талаар ярилцаж байхад хүмүүсийн байнга асуудаг хоёр дахь асуулт бол Бахайн нийгэмлэг санхүүгийн хэрэгцээгээ хэрхэн хангадаг тухай юм. Энэ асуултад хариулахад тань хэрэг болох хэдэн санааг доор толилуулав:

- Бахайн нийгэмлэгийн материаллаг хэрэгцээгээ хангахад ашигладаг хэрэгсэл бол Бахайн Сан бөгөөд түүнийг орон нутгийн, үндэсний, тивийн болон олон улсын гээд шат шатны Бахайн институтууд удирддаг юм. Бахайчууд Шүтлэгээ түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгтэй холбоотой зардлыг өөрсдөө хариуцах ёстой гэж үздэг тул Бахайн Сан зөвхөн нийгэмлэгийн гишүүдээсээ л хандив тусламж авдаг билээ.
- Санд хандив өргөх нь сайн дурын хэрэг юм. Энэ нь хувь хүн, Шүтлэгийн институтууд хоорондын хэрэг гэдэг утгаараа нууц байдаг бөгөөд хандив өргөсөн хүний нэр, хандивын хэмжээг дэлгэж зарладаггүй. Нийгэмлэгийн гишүүдийг хандив тусламж өргөхийг шахаж шаарддаггүй. Институтууд нийгэмлэгт хандан уриалга гаргаж Сангийн ач холбогдлын талаар сануулж, хэрэгцээ шаардлагаа танилцуулдаг юм. Нийгэмлэг нь дотроо хандив босгох зорилт тавих нь ч бий. Ингэхдээ хувь хүмүүст хандивлах хэмжээг нь хэзээ ч тогтоож өгдөггүй, мөн араас нь нэхэж шаарддаггүй. Хүн бүр Сантай холбоотой зарчмуудын талаарх ойлголт дээрээ тулгуурлан хэдийг хандивлахаа өөрөө шийддэг.
- Бидний цогцлохоор хичээж буй соёл иргэншил материаллаг болон оюун санааны хувьд цэцэглэн хөгжих болно. Тодорхой нөхцөлийг хангасан тохиолдолд л баялгийг хүлээн зөвшөөрөх юм. Бид баялгийг шударга хөдөлмөрөөрөө олж авч, түүнийгээ хүн төрөлхтний сайн сайхны төлөө зарцуулах ёстой. Тэгсэн цагт л нийгэмлэг тэр чигээрээ сэргээд ирнэ; ихэнх хүн амьдралын наад захын хэрэгцээт зүйлсээр гачигдаж байхад цөөхөн хэд нь үлэмж чинээлэг байх нь байж боломгүй. Бахаулла бидэнд ийн айлдсан билээ:

“Өөрийн ажил хөдөлмөрөөр амьдрал ахуйгаа залгуулж, олсон хөрөнгөө бүх ертөнцийн Эзэн Бурханыг хайрласан хайрынхаа төлөө өөрсдөдөө болон төрөл нэгтнүүддээ зарцуулдаг хүмүүс бол хамгийн эрхэм дээд хүмүүс болой.”³⁰

“Та нар Миний цэцэрлэгт ургасан модод мөний учир өөрсдөдөө болон бусдад ашиг шим хайрлах сайн сайхан, гайхамшигт үр жимсээ өгөх ёстой... Хүн бүхэн ямарваа нэгэн ур ухаан, ажил мэргэжил эзэмших үүрэгтэй, чухам үүнд л баян байхын нууц оршино.”³¹

Тэгвэл Абдул-Баха бидэнд ийн тайлбарлажээ:

“Хүн ам бүхэлдээ баян байгаа цагт л баялаг гэдэг нэн сайшаалтай. Хэрэв, бусад нь ядуу зүдүү байхад цөөхөн хэд нь хэмжээлшгүй чинээлэг байж, тэр баялаг ямар ч үр жимс, ашиг тус өгдөггүй бол тэр нь зөвхөн тухайн эзэмшигчийн өр төлбөр юм.”³²

- Шударга бус явдал, ядуурлаас ангид нийгэм байгуулъя гэвэл бид өгөөмөр байх ёстой. Санхүүгийн нөөц бололцоо хомс байсан ч бид хүн төрөлхтний ахиц дэвшилд хувь нэмрээ оруулж байх хэрэгтэй; учир нь жинхэнэ хөгжил цэцэглэлтэд зөвхөн өгөхүйн замаар л хүрэх боломжтой. Өгөөмөр байдал бол хүмүүний сэтгэлийн нандин чанар; энэ нь бидний материаллаг нөхцөл байдалтай ямар ч хамаагүй. Эрдэнэсийн Нуугдмал Үгс-д Бахаулла ийн айлдсан байдаг:

“Өглөгч, өгөөмөр байх нь чухам Миний чанар буюу. Миний ариун нандин чанараар өөрийгөө чимсэн хүн нэн сайн.”³³

- Бидэнд байгаа аливаа баялгийн жинхэнэ эх сурвалж бол Хамгаас Өгөөмөр Бурхан гэдгийг бид мартах ёсгүй. Тэр биднийг амь зуух хэрэгслээр хангаж; Тэр бидэнд ахиц дэвшил гаргах боломж олгодог. Бид Санд хандив өргөх нь Түүний бидэнд өгсөн зүйлийн тодорхой хэсгийг Түүний Үйл хэрэгт зориулж буй хэрэг. Тэгэхээр Бахайчуудын хувьд Санд хандив өргөх нь өгөөмөр сэтгэлийн асуудал төдий биш; энэ нь оюун санааны хишиг буян бөгөөд хувь хүний үүрэг хариуцлага юм. Энэ талаар Асран тэтгэгчийн өгсөн зөвлөгөө:

“Бид байгаа бүхнээ байнга шавхаж, нүднээ үл үзэгдэх эх сурвалжаас тасралтгүй бялхан дүүрдэг усан оргилуур эсвэл булаг шанд мэт байх ёстой. Ядуурч хоосорно хэмээн үл эмээн, хамаг баялаг болон хамаг сайн сайхны Эх сурвалжийн дундаршгүй өгөөж буянд найдан ахан дүүсийнхээ сайн сайхны төлөө байнга туслах нь зөв амьдрахуйн нууц юм.”³⁴

Танд энд гарсан зарим нэг санааг илүү дэлгэрэнгүй авч үзэх боломж “материаллаг арга хэрэгсэл” сэдвээрх дараагийн сургалтын үеэр гарна. Одоохондоо, урьдын адилаар дээрх агуулгыг нэг бүрчлэн хэлэлцээд, санаагаа чөлөөтэй илэрхийлж сурахын тулд дараах дасгалуудыг хийхийг зөвлөө.

1. Дээр дурдсан эшлэлүүдийг үндэслэн дараах өгүүлбэрүүдийг гүйцээнэ үү.

а. Бахаулла	биднийг	өөрийн	ажил	хөдөлмөрөөр
_____		залгуулж,	олсон	хөрөнгөө

b. Бид өөрсдөдөө болон бусдад _____
_____, _____ үр жимсээ
өгөх ёстой...

c. Хүн нэг бүр ямарваа нэгэн _____,
_____ үүрэгтэй, чухам үүнд л
_____ оршино.

d. Абдул-Баха бидэнд зөвлөснөөр _____ баян байгаа
цагт л баялаг гэдэг _____.

e. Хэрэв _____ нь _____ байхад
_____ нь хэмжээлшгүй _____ байж; тэр _____
ямар ч _____, _____ өгдөггүй бол тэр
нь зөвхөн _____ юм.

f. Бахаулла хэлэхдээ “ _____, _____ нь
чухам Миний чанар буюу. Миний
_____ өөрийгөө
_____ хүн нэн сайн” гэсэн билээ.

g. Бид байгаа бүхнээ байнга _____,
_____ тасралтгүй _____ эсвэл
_____ мэт байх ёстой.

h. _____ хэмээнс _____,
_____ ахан дүүсийнхээ _____ төлөө байнга
_____ нь зөв амьдрахуйн нууц юм.

2. Дээр танилцуулсан санаануудыг дарааллаар нь буулгана уу.

14 ДҮГЭЭР ХЭСЭГ

Эхлээд өсвөр насны залуучуудын эцэг эхчүүдтэй тогтмол харилцан яриа өрнүүлэхэд суурь болдог агуулгыг авч үзэцгээе. Бидний өмнөх түүхээс хойш хэсэг хугацаа өнгөрч, Беатрис одоо хоёрдугаар номыг судалж байгаа гэж төсөөлөх болно. Алехандраа Беатрисаас, өөрийнх нь дэмжлэгтэйгээр бүлэг байгуулах гэж байгаа хэсэг өсвөр насныхны гэрээр айлчлахад нь хамт явмаар байна уу хэмээн асуусанд найз нь дуртайяа зөвшөөрөв.

Александра Беатрист юу төсөөлж байгаагаа тайлбарлав. “Бид уулзалт бүрээ, эцэг эхчүүдэд хүү эсвэл охиных нь сонирхож буй хөтөлбөрийг танилцуулж, энэ нь тухайн бичил хороон дахь нийгэмлэгийг бүтээн босгох үйл явцын нэгээхэн хэсэг гэдгийг дурдаж ярьснаар эхлүүлнэ. Дараа нь бид хөтөлбөрийн гол санаа болон үзэл баримтлалыг хамтдаа судлах болно. Энэ нь цуврал айлчлалын анхных нь байх бөгөөд яриа цааш өрнөх тусам тухайн гэр бүл нь өсвөр насныхны бүлгийг төрөл бүрээр идэвхтэй дэмжээд зогсохгүй нийгэмлэгийнхээ өсвөр насныхныг оюун санааны хувьд хүчирхэгжүүлэх явдлыг дэмжигчид болно гэдэгт бид найдаж байна” гэж тэрээр хэллээ.

Александра Беатрис хоёр айл болгонтой хөндөж ярилцахаар төлөвлөж буй зарим асуудлын талаар үргэлжлүүлэн ярилцав. Тэд чухал гэж үзсэн бүх санаагаа цаасан дээр буулгахаар болов. Ингэхдээ зөвхөн цөөхөн хэдийг нь эхний айлчлалын үеэр танилцуулж, үлдсэнийг нь дараа дараагийн уулзалтаар хөндөж ярина гэдгээ тэд мэдэж байлаа. Өсвөр насныхны нөөц чадавх, боломжийн талаар тэдний жагсааж бичсэн зүйлс гэвэл:

- Аливаа хүний амьдралд 12-оос 15 нас хүртэлх гурван жил бол хүүхэд наснаас нас биед гүйцэх маш чухал үе байдаг.
- Энэ насан дээрээ яваа залуусыг бид “өсвөр насны залуучууд” гэдэг. Тэд хүүхэд байхаа больсон ч орь залуу насандаа хараахан хүрээгүй яваа.
- Харамсалтай нь өсвөр насныхан түргэн зантай, дураараа, дотогшоогоо бөгөөд хямралд өртөмтгий гэх өрөөсгөл атлаа өргөн тархсан ойлголт байдаг. Тэгвэл бид тэднийг өөр өнцгөөс хардаг юм. Амьдралын энэ ахархан хугацаанд бид бие махбод, сэтгэл санаа болон оюун ухааны хувьд түргэн өөрчлөгддөг нь үнэн. Зарим талаараа дураараа авирладаг нь ч бас үнэн. Гэтэл бодит байдал дээр энэ бол асар их боломж, асар их найдвар дүүрэн нас юм.
- Бид өөрсдөө өсвөр насан дээрээ явсан цаг саяхан тул эдгээр өөрчлөлт бидэнд хэрхэн нөлөөлснийг мартаагүй. Зарим үед бид зоримог, зарим үед зүрх зориг хүрдэггүй байв. Зарим өдөр бид нүүрэмгий, зарим өдөр бүрэг ичимхий болчихдог байсан. Бусдын анхаарлыг хүсэх атлаа ганцаараа баймаар үе цөөнгүй тохиолдоно. Бид юу чадахаа, мөн ямар авьяас чадвартайгаа ойлгохыг хүсдэг байсан. Хүмүүс биднийг юу гэж харж, бидний бодол санааг юу гэж боддог нь бидний хувьд чухал санагддаг байв.
- Ийм зан байдал түр зуур л үргэлжилдэг гэдгийг ойлгох нь чухал. Хүний амьдралын энэ үед оюуны зарим чадавх хурдацтай хөгждөг. Бид оршихуйн талаарх суурь асуултуудад хариулт хайж эхэлдэг. Бид эргэн тойронд маань

болж буй зүйлд дүн шинжилгээ хийж, бидэнд зааж сургасан ихэнх зүйлд эргэлзэн асууж шалгадаг. Ялангуяа тэдний үг үйлдэл хоорондоо зөрж байгааг хараад бид томчуудын хий гэснийг шууд дагахаа аяндаа больдог.

- Өсвөр насны залууст шинэ ур чадвараа үр дүнтэй ашиглахад нь тусалъя л гэвэл тэдэнтэй хүүхэдтэй харьцаж байгаа юм шиг харьцахаас зайлсхийх нь чухал. Энэ үеийг Абдул-Баха ийн тайлбарласан байдаг билээ:

“Хэсэг хугацааны дараа тэрээр залуу насан дээрээ ирж, өмнөх нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага нь зэрэг ахихад хамаарахуйц шинэ хэрэгцээ шаардлагаар солигддог. Аливааг ажиглах чадвар нь өргөжин гүнзгийрч; оюуны чадавх нь хөгжин сэргэж; эрч хүч, ололт амжилт нь хүүхэд ахуйн үеийнх нь хязгаарлалт, нөхцөл байдалд баригдахаа больдог.”³⁵

- Бахайн Шүтлэгийн удирдах байгууллага болох Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон нь өсвөр насны залуустай ажиллахдаа бидний баримталдаг болсон арга барилын талаар ингэж хэлсэн байдаг:

“Дэлхий дээр өсвөр насныхныг тун хүндрэлтэй, бие махбодын ба сэтгэл санааны өөрчлөлтөд автан хөлөө алдсан, хувиа хичээсэн, аливаад сэтгэлгүй хэмээн төсөөлөх хандлага түгээмэл байдаг бол Бахайн нийгэмлэг өөрийн ашиглаж буй хэл яриа болон арга барилдаа үүнээс эсрэг чиглэлд шийдэмгийгээр урагшилж байгаа билээ. Өсвөр үеийн залуучууд нь бусдын төлөө гэсэн сэтгэлтэй, шударга ёсыг мэдрэх соргог мэдрэмжтэй, орчлон ертөнцийн учир начрыг танин мэдэх эрмэлзэлтэй, мөн сайн сайхан дэлхий ертөнцийг бүтээн байгуулахад өөрсдийн хувь нэмрийг оруулах тэмүүлэлтэй гэсэн үзэл баримтлалтай байдаг билээ.”³⁶

Дараа нь Алехандра Беатрис хоёр оюун санааны чадавхыг дээшлүүлэх хөтөлбөрт анхаарлаа хандуулж, зарим нэг онцлогийг нь тодорхойлохыг оролдоно.

- 12-15 насны залуус үе тэнгийн нөхөдтэйгөө нэг бүлэгт орж, тэдэнтэй санал бодлоо хуваалцах, аливаа төсөл дээр хамтран ажиллах, спортоор хичээллэх хүсэлтэй байдаг. Ийм ч учраас хөтөлбөрийг “өсвөр насны залуучуудын бүлэг” гэх ойлголт дээр тулгуурлан боловсруулсан болно. Бүлэг тус бүрийг “удирдагч” удирдан чиглүүлдэг бөгөөд тэрээр бүлгийнхээ гишүүдэд чадавхаа хөгжүүлэхэд нь жинхэнэ анд нөхрийн хувьд тусалдаг, тэднээс эгч/ах хүн байдаг.
- Бүлгүүд тогтмол уулздаг бөгөөд уулзалтынхаа үеэр өсвөр насныхан аливаа ойлголтыг ухаж судлан, санал бодлоо ямар нэгэн дүрэм хорионд баригдаж, элэг доог болохоос айж эмээлгүйгээр илэрхийлж сурдаг. Тэднийг сонсох,

ярих, эргэцүүлэн бодох, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргаж түүнийхээ дагуу ажиллахад нь дэмжиж өгдөг.

- Та бид, залуусын сэтгэхүй болон биеэ авч явах байдалд маш олон сөрөг хүчин зүйл нөлөөлдөг болсон цаг үед амьдарч байна. Удирдагчид нь тэдэнд нийгэм дэх ёс суртахууны доройтлоос өөрийгөө хамгаалаад зогсохгүй дэлхийн сайн сайхны төлөө үйлчлэхийн тулд эдгээр хүчин зүйлстэй тэмцэхэд нь тусалдаг юм.
- Хөтөлбөр нь хүнд төрөлхийн байдаг бөгөөд өсвөр насны эхэн үед улам ихээр илэрч эхэлдэг чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн болно. Сэтгэн бодох, аливааг илэрхийлэх чадвар нэн чухал юм. Залуу хүмүүс ертөнцийн талаар гүн гүнзгий санаа илэрхийлэх, мөн ертөнцийг яаж өөрчлөгдөөсэй гэж хүсэж явдгаа томъёолж гаргахад шаардлагатай үг хэллэгийг хөгжүүлэх ёстой.
- Өсвөр насны залуус зорилготой амьдралын суурь зарчмуудын утга учрыг тунгаан бодохыг хичээдэг. Аз жаргал, итгэл найдвар, төгс төгөлдөр байдал бол цөөн хэдэн жишээ. Хүмүүс эдгээр зарчмын талаар өнгөц бодолтой явдаг нь харамсалтай. Эдгээр зарчмын талаар гүн гүнзгий ойлголттой болж, өдөр тутмын амьдралд хэрхэн илэрдгийг нь таньж мэдэх нь залуу хүмүүст бат бөх ёс суртахуунтай болж төлөвшин, нийгэм дэх сөрөг хүчин зүйлсийн эсрэг зогсоход нь туслах юм.
- Аливаа зарчмын талаар ойлголттой байх нь оюуны хөгжилд зайлшгүй хэрэгтэй. Өсвөр насны хүүхдүүд суурь зарчмыг нь ойлгоход хангалттай дэмжлэг авалгүйгээр өөр өөр сэдвээр маш их мэдээлэл авдгаасаа болж сургууль дээрээ хүндрэлтэй тулгарах нь бий. Хөтөлбөр нь тэдэнд ёс суртахууны, математикийн, шинжлэх ухааны зарчмуудын талаар ул суурьтай бодоход нь түлхэц өгдөг бөгөөд энэ нь тэдний сурлагад эергээр нөлөөлдөг юм.
- Өсвөр насныхан аливаа юмны учир начрыг ойлгохыг их хүсдэг. Тэд эргэн тойронд нь болж байгаа зүйлийн учир шалтгааныг ойлгохыг хичээдэг. Амжилтад хүрэхийн тулд тэд зөвхөн нүдээрээ төдийгүй билгийн мэлмийгээрээ харж чаддаг байх ёстой. Тиймээс, хөтөлбөрийн чухал зорилго оюун санааны мэдрэхүй буюу оюун санааны хүчийг таньж, тулгараад буй нөхцөл байдалд оюун санааны зарчмуудыг тодорхойлох чадварыг сайжруулахад оршино.
- Хөтөлбөр нь ёс суртахуун, оюун санааны мэдрэхүй, илэрхийлэх чадварыг хөгжүүлэх зорилгодоо хүрэхийн тулд цуврал номуудыг ашигладаг. Эдгээр

нь дэлхийн өнцөг булан бүрд байгаа залуусын амьдралын тухай энгийн түүхүүд юм. Өсвөр насныхан эдгээр материалуудыг хамтдаа судалж, агуулгынх нь талаар ярилцаж, өгөгдсөн дасгалуудыг гүйцэтгэхийн зэрэгцээ спортоор хичээллэж, урлаг болон гар урлалын талаар сурч мэддэг.

- Удирдагчийн тусламжтайгаар бүлгүүд хэд хэдэн үйлчлэх төсөл боловсруулж, хэрэгжүүлдэг нь хөтөлбөрийн томоохон бүрэлдэхүүн хэсэг юм. Эдгээр төслөөр дамжуулан өсвөр үеийнхэн нийгэмлэг болон түүний хэрэгцээ шаардлагын талаар бодож, зөвлөлдөж, өөр хоорондоо болон нийгэмлэгийн бусад хүмүүстэй хамтран ажиллахад суралцдаг.
- Текстүүд янз янзын сэдэвтэй; тус бүр нь өсвөр насны залуусыг оюун санааны хувьд чадавхжуулахад чухал ач холбогдолтой сэдвийг хөнддөг. Эхний ном, жишээ нь, эрхэм зорилгод хүрэхийн төлөө бидний гаргадаг хүчин чармайлтыг Бурхан баталгаажуулдаг тухай “баталгаа” гэх сэдэвтэй. Өөр нэг нь “итгэл найдвар” буюу бид хамгийн хүнд үед ч ирээдүй өөд итгэл найдвар дүүрэн харах ёстой тухай юм. Мөн “төгс төгөлдөр”-ийн талаарх концепц дүн шинжилгээ хийдэг. “Аз жаргал” бол нэг түүхийн сэдэв бол “үгийн хүч” нь өөр нэгэн түүхийн эргэцүүлэн бодох сэдэв юм. Математикийн зарчмуудын талаарх олон түүхийн нэг нь цэгцтэй сэтгэх дадлын тухай юм. Шинжлэх ухаантай холбоотой хэсэгт бие махбодын, сэтгэцийн болон оюун санааны эрүүл мэнддээ хэрхэн анхаарах талаар байдаг. Өсвөр насны залуус гурван жилийн дотор арав гаруй сэдвийг судалдаг.

Александра Беатрис хоёр, эцэг эхчүүд сонирхож магад гээд ганц хоёр материал авч явахаар болов. Хэрэв та ном материалуудаас төдийлөн сайн мэддэггүй бол цаг гарган аль болох олон түүх унших нь танд хэрэг болно. Ингэснээр та нийгэмлэгт янз янзын сэдвээр өрнөж буй ярианд оролцож чаддаг болно. Тэр хооронд, тавдугаар номд илүү дэлгэрэнгүй тусгагдсан дээрх санаануудыг бүлгийнхээ бусад оролцогчидтой сайтар хэлэлцэхийг танд зөвлөе. Тэр номыг судалсныхаа дараа та өсвөр насны залуусын бүлгийн удирдагч болохоор шийдвэл бүлгийнхээ гишүүдийн гэрээр тогтмол зочилж, эдгээр болон ижил төстэй олон санааг хамтдаа судалдаг болно. Та одоо ч гэсэн, Беатрисын нэгэн адилаар, туршлагатай хүн дагалдан нийгэмлэгийнхээ өсвөр насныхны гэрээр хэд хэдэн удаа зочилж болох юм.

15-Р ХЭСЭГ

Маргааш өдөр нь Александра Беатрис хоёр, бичил хороонд нь шинээр байгуулагдаж байгаа бүлэгт нэгдэх гэж буй гурван залуусын гэрээр зочиллоо. Эцэг эхчүүд нь оюун санааны хувьд чадавхжуулах хөтөлбөрийн талаар ярианд ямар

98 - Үйлчлэхээр эгцлэн босохуй

урамтай оролцож буйг харах Беатрист сайхан байлаа. Үдээс хойш гэхэд тэрээр Алехандрад өсвөр насны бүлэгт тусалж, өөрөө ч шинэхэн бүлгийн удирдагчаар жилийн дотор үйлчилж сурмаар байгаадаа итгэлтэй болсон байв. Тэр болтол институтийн хэд хэдэн номыг судалж дуусгах ёстойгоо тэрээр ойлгож байгаа. Тэрээр энэ хүртэл ямар хурдтай явж ирсэн тэр л хурдаараа тэдгээр номуудыг үзэж судална хэмээн хатуу шийджээ.

Ингээд Алехандрагийн байнгын тусламж дэмжлэгтэйгээр Беатрис үйлчлэхүйн замаар урагшилсаар байна. Беатрисын түүхийг хэдэн сарын дараа, түүнийг гуравдугаар номд дуусгах үед үргэлжлүүлцгээе. Сургалтын дугуйлангийн сургагч нь хүүхдийн ангийн багш Марибелээс шинээр байгуулагдсан нэгдүгээр ангийн хүүхдүүдийн эцэг эхтэй уулзахаар явахдаа Беатрис болон бусад оролцогсдыг нэг нэгээр нь дагуулж явахыг хүсэв. Беатрис гуравдугаар номыг үзэж судалснаар багагүй зүйл сурсан гэдэгтэй итгэлтэй байгаа аж. Энэ тухай өмнө нь нэг бус удаа ярьж байсан Алехандрагаас тэрээр, уг номоос олж авсан мэдлэг нь түүний удирдагчаар үйлчлэх чадавхыг нэмэгдүүлнэ гэдгийг ч мэдэж авчээ.

Марибель Беатристай уулзаад “Хоёулаа Эммагийн ээжийнд очно. Эмма бол сурч мэдэх сонирхолтой хөөрхөн охин. Би аав ээжтэй нь өмнө нь нэг уулзаад Бахайн хүүхдийн хичээлийн мөн чанарыг тайлбарлаж өгсөн. Тэд Эммаг хичээлд оролцохыг нь дуртайяа зөвшөөрсөн. Ээж нь хичээлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдмээр байна гэсэн болохоор би тэднийд эргэж очин, бидний заадаг материалын суурь санаануудын талаар ярьж өгнө гээд амлачихсан юм. Би өөртөө хэдэн зүйл тэмдэглэж авсан. Хүсвэл хоёулаа тэдгээрийг хамтдаа уншиж ярилцаж болох юм” гэв. Беатрис ч зөвшөөрлөө. Ингээд тэдний хэлэлцсэн зүйл гэвэл:

- Эхлээд би хатагтай Мартинезд, Эмма манай ангид байгаад баяртай байгаагаа хэлээд зарим нэгэн сайхан чанаруудаас нь дурдаад өнгөрнө.
- Бахауллагийн Сургаалаас авсан энэ эшлэлийг түүнтэй хамт уншсанаар ярилцлагаа эхлүүлбэл зүйтэй болов уу:

“Хүмүүнийг үнэлж баршгүй эрдэнийн чулуугаар баялаг уурхай хэмээн үзэгтүн. Зөвхөн боловсрол түүний эрдэнэс баялгийг нээн илрүүлж, хүн төрөлхтөнд түүний ач тусыг хүртээж чадмуй.”³⁷

- Энэ үг багш хүний хувьд надад ямар их нөлөөлсөн тухай зарим бодлоо хуваалцаж болох юм. Ангийнхаа хүүхдүүдийг хараад, тэднийг үнэлж баршгүй эрдэнийн чулуун уурхай гэж бодох болгонд зүрх минь баяр хөөрөөр бялхдаг гэж би хэлнэ. Хүүхэд тэнгэрлэг нандин шинж чанаруудыг харуулах боломж бий. Хүүхэд нээн хөгжүүлэх авьяас чадвар бий. Хүүхэд бүр нийгмийн үнэ цэнтэй гишүүн болон төлөвшиж, хүн төрөлхтний сайн сайханд хувь нэмрээ оруулах боломжтой.

- Боловсролоор дамжуулан хүүхэд бүрээс нээж болох эрдэнэсийг жишээн дээр ярих зүйтэй байх. Байгалийн хуулийг нээх, гайхамшигт уран бүтээл туурвих, сайн сайхан бодол илэрхийлэх зэрэг оюуны чадваруудаас дурдаж болох юм. Хүүхдүүд зохих боловсрол эзэмшсэнээр энэ бүх чадварыг хөгжүүлж эхэлдэг гэдгийг тайлбарлаж өгнө. Үүний тулд тэд, зарим зан чанаруудыг бага наснаасаа олж авах учиртай. Жишээ нь тэд анхаарлаа төвлөрүүлж, шаардлагатай үед шаргуу хөдөлмөрлөж, хийж буй зүйл дээрээ төвлөрч сурах хэрэгтэй. Тэд бусдын сайн сайханд санаа тавьдаг, нийгэмд үйлчлэх хүсэлтэй хувь хүн болон төлөвших ёстой. Тийм ч учраас зан байдлыг нь багаас нь хөгжүүлэхэд анхаарах нь нэн чухал юм.
- Энэ үед хатагтай Мартинезээс, охиноо ямар хүн болоосой гэж бодож явдгийг нь асуухад яг болно. Түүний бодлоор Эмма ямар зан чанартай байх нь чухал бол?
- Түүний дурдах зарим зан чанар лав оюун санааных байх бөгөөд тэр нь миний дараагийн сэдэв байх юм. Хүний оршин тогтноход зайлшгүй чухал зан чанарууд гэж байдаг. Тэдгээр нь хүний сүнсэнд хамаардаг юм. Тэдгээрийг бид сэтгэлийнхээ толийг өнгөлж Бурханы шинж чанаруудыг тусгах замаар хөгжүүлдэг. Бидний оюун санааны хэмээдэг эдгээр шинж чанарыг бид нэгдүгээр хичээлд заадаг хичээлээр голлон авч үздэг.
- Би гуравдугаар номын нэгдүгээр ангийн хичээлээр үздэг оюун санааны зарим чанарыг дурдаж, холбогдох эшлэлүүдийг хуваалцъя гэж бодож байна. Түүнд би “Эмма эдгээр эшлэлүүдийг цээжлэх тул та охиноороо цээжилсэн эшлэл, мөргөлүүдийг нь уншуулж байж болох юм” гэж тайлбарлана:

– **Энэрэл хайр:**

“Аяа, Анд нөхөр! Зүрх сэтгэлийнхээ цэцэрлэгт зөвхөн хайрын сарнайг тарьж ургуул...”³⁸

– **Шударга ёс:**

“Шударга ёсны замаар замнагтун. Учир нь энэ бол үнэнхүү шулуун зам болой.”³⁹

– **Шударга зан:**

“Үнэнч шударга зан бол хүмүүний бүхий л ариун нандин чанарын үндэс суурь мөн.”⁴⁰

– Баяр баясгалан:

“Аяа, Хүмүүний үр! Сэтгэл зүрхнийхээ угаас баярлан баясагтун. Тэгэх ахул Надтай нүүр учирч, Миний үзэсгэлэнт дүрийг тольдон тусгах заяа чамд олдмуй.”⁴¹

Марибель Беатриз хоёр дээрх санаануудыг эхний удаадаа хангалттай гэж үзлээ. Удахгүй та гуравдугаар номыг судлах бөгөөд Рухи Институтийн хүүхдийн оюун санааны боловсрол олгох зургаан жилийн хөтөлбөрт тусгагдсан зарим зарчмын талаар эргэцүүлэн бодох боломжтой болно. Тэр болтол танд хүүхдийн хичээлийн багшийг дагалдан хэд хэдэн эцэг эхтэй уулзах завшаан олдвол энд гарсан санаанууд хэрэг болох тул бүлгээрээ нэг бүрчлэн ярилцах хэрэгтэй.

16 ДУГААР ХЭСЭГ

Бид Абдул-Бахагийн “Хүмүүсийн хооронд нөхөрлөл, эв нэгдлийн холбоо хэдий чинээ бат бөх байна хүний үйл ажиллагааны бүхий л салбарт бүтээлч сэтгэлгээ, ололт амжилт төдий чинээ хүчтэй байна” хэмээн айлдсан үгийг өмнө нь уншсан. Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон бидэнд айл өрхүүдээр зочилж, мөн гэртээ урьж залах нь “оюун санааны анд нөхдийн холбоог бий болгож “нэг нийгэмлэг” гэх мэдрэмжийг бэхжүүлдэг” гэсэн билээ. Тиймээс өсөн тэлж буй нийгэмлэгийн маань соёлд энэ зан үйлийн үзүүлэх нөлөөг бид дутуу үнэлж болохгүй.

Өмнөх хэсгүүдэд бид, нэг нэгнийхээ гэрээр айлчлах үеэр өрнөж болох хэд хэдэн төрлийн харилцан яриаг авч үзлээ. Бид үйлчлэхүйн замаар алхан явахдаа тосгон, хот эсвэл бичил хороондоо “Бахауллагийн сургаалыг хувийн болон хамтын амьдралдаа хэрэгжүүлэх” талаар өргөн хүрээг хамарсан яриа хэлэлцээнд оролцох болно. Заримдаа энэ нь улам олон хүнд сургаалын талаарх мэдлэгээ дээшлүүлэх боломж олгох үүднээс зохиогдох албан ёсны цуврал айлчлалын үеэр болно. Институтийн боловсролын хөтөлбөрүүд, тэдгээрийн зорилго, агуулгын талаар хэлэлцүүлэх үе ч олонтоо гарна.

ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. Бахаулла, *Эрдэнийн нуугдмал үгс* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2003, 2012 оны хэвлэлт), Араб хэл дээрх но. 4, 4-р нүүр.
2. Бахаулла, *Бахайн Мөргөл: Бахаулла, Абдул-Баха, Баб нарын нээсэн мөргөлийн түүвэр* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2002, 2017 оны хэвлэлт), 4-р нүүр.
3. *Бахауллагийн сургаалын дээжис* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 1983, 2017 оны хэвлэлт), IV, 1-р догол мөр, 5-р нүүр.
4. Дээрхийн адил, V, 2-р догол мөр, 6-7-р нүүр.
5. ‘Abdu’l-Baha, in Baha’н Prayers, p. 81.
6. Дээрхийн адил, 111-р нүүр.
7. Дээрхийн адил.
8. 1912 оны 8-р сарын 16-нд хэлсэн үгнээс, *Энх тайвны тунхаг бичиг: Абдул-Бахагийн 1912 онд АНУ болон Канад улсад айлчлахдаа айлдсан айлдварууд* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2012 он), 23-р догол мөр, 364-р нүүр.
9. Абдул-Баха, *Бахайн Мөргөл*, 130-р нүүр.
10. *Бахауллагийн сургаалын дээжис*, XLV, 1-р догол мөр, 111-12-р нүүр.
11. Абдул-Баха, Шогн Эффендигийн эш татсанаар, *Бахауллагийн Дэлхийн Хэв журам: Түүвэр захидал* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 1991, 2012 оны хэвлэлт), 139-р нүүр.
12. *Бахауллагийн сургаалын дээжис*, V, 5-р догол мөр, 8-р нүүр.
13. Абдул-Бахагийн 1912 оны 5-р сарын 5-нд айлдсан айлдвараас, *Энх тайвны тунхаг бичиг*, 4-р догол мөр, 128-р нүүр.
14. 1911 оны 10-р сарын 21-нд хэлсэн үгнээс, *Парисын айлдварууд: Абдул-Бахагийн 1911 онд айлдсан айлдварууд* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2006, 2016 оны хэвлэлт), но. 6.7-8, 22-р нүүр.
15. *Бахауллагийн сургаалын дээжис*, CXLVI, 1-р догол мөр, 357-р нүүр.
16. Абдул-Бахагийн 1912 оны 5-р сарын 5-нд айлдсан айлдвараас, *Энх тайвны тунхаг бичиг*, 4-р догол мөр, 128-р нүүр.
17. *Эрдэнийн нуугдмал үгс*, Перс хэл дээрх но. 44, 37-р нүүр.

18. Дээрхийн адил, Перс хэл дээрх но. 66, 45-р нүүр.
19. Абдул-Бахагийн Мөргөл-өөс. (албан ёсны орчуулга)
20. Абдул-Бахагийн 1912 оны 9-р сарын 25-нд айлдсан айлдвараас, *Энх тайвны тунхаг бичиг*, 2-р догол мөр, 478-79-р нүүр.
21. *Абдул-Бахагийн сургаалын түүвэр* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2010, 2015 оны хэвлэлт), но. 43.1, 125-р нүүр.
22. Дээрхийн адил, но. 207.3, 360-р нүүр.
23. Бахаулла, *Бахайн цугларалт: Бахаулла, Абдул-Баха, Баб болон Шоги Эффенди нарын сургаалын түүвэр*, Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоны Судалгааны Хэлтсээс эмхэтгэснээр (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 1976, 1980 оны хэвлэлт), 3-р нүүр.
24. Дээрхийн адил.
25. *Абдул-Баха Аббасын Мөргөлүүд* (Нью Йорк: Бахайн хэвлэлийн хороо, 1916, 1930 оны хэвлэлт), 3-р боть, 631-р нүүр. (албан ёсны орчуулга)
26. Бахаулла, *Китаб-и-Агдас: Хамгаас Ариун Судар* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 1993, 2013 оны хэвлэлт), 57-р догол мөр, 41-р нүүр.
27. *Абдул-Бахагийн сургаалын түүвэр*, но. 48.1, 130-р нүүр.
28. 1989 оны 8-р сарын 27-нд бичсэн захидлаас, *Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоны захидлууд, 1986–2001: Бүтээн босголтын эрин цагийн Дөрөв дахь үе* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2010 он), но. 69.2, 132-33-р нүүр.
29. Дээрхийн адил, но. 69.9–10, р. 135.
30. *Эрдэнийн нуугдмал үгс*, Перс хэл дээрх но. 82, 51-р нүүр.
31. Дээрхийн адил, Перс хэл дээрх но. 80, 51-р нүүр.
32. Абдул-Баха, *Тэнгэрлэг иргэнилийн нууц* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2007, 2016 оны хэвлэлт), 46-р догол мөр, 33-р нүүр.
33. *Эрдэнийн нуугдмал үгс*, Перс хэл дээрх но. 49, 39-р нүүр.
34. Шоги Эффенди, *Бахайн Сонин*, но. 13 (1926 оны 9-р сар), 1-р нүүр.
35. Абдул-Бахагийн 1912 оны 11-р сарын 17-нд айлдсан айлдвараас, *Энх тайвны тунхаг бичиг*, 3-р догол мөр, 617-р нүүр.
36. 2010 оны 4-р сарын 21-ний өдрийн захидлаас, *Framework for Action: Даян*

Дэлхийн Шударга Ёсны Ордонь захи́длын түүвэр болон туслах материал, 2006–2016 (Уэст Палм Бич: Palabra Publications, 2017), no. 14.16, 82-р нүүр.

37. *Бахауллагийн сургаалын дээжис*, СХХII, 1-р догол мөр, 294-р нүүр.
38. *Эрдэний нуугдмал үгс*, Перс хэл дээрх no. 3, 23-р нүүр.
39. *Бахауллагийн сургаалын дээжис*, СХVIII, 1-р догол мөр, 283-р нүүр.
40. Абдул-Баха Шогь Эффендигийн эш татсанаар, *Тэнгэрлэг шударга ёс айсуу* (Уильметт: Бахайн хэвлэлийн газар, 2006, 2018 оны хэвлэлт), 40-р догол мөр, 39-р нүүр.
41. *Эрдэнийн сургаал үгс*, Араб хэл дээрх no. 36, 12-р нүүр